Эрхлэгчийн зурвас 4

Монголын Хил Судлалын Академийн ажил амьдрал

Монголын хил судлалын академ байгуулагдаж нээлтээ хийлээ 8
Монголын хил судлалын академийн дүрэм 10

Хил Судлалын шинжлэх ухааны онол практик

Д.Нямдорж: Хил судлал бол шинжлэх ухааны бие даасан салбар мөн 16
Ц.Ганболд:Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад хил судлалын ухааны үүрэг, байр суурь 26
Н.Наранжамц: Бүс нутаг ба хилийн аюулгүй байдал 35
Г.Дагважамц: Даяаршлын үеийн хилийн харилцаанд заавал анхаарах зарим асуудал 40

Лимологийг эхлэн судлахуй

А.Муратхан: Лимологи нь шинжлэх ухааны бие даасан салбар мөн 46

Гадаадын судлаачид хилийн асуудлаар

С.Голунов: Хилийн аюулгүй байдал: хөрш зэргэлдээх улсуудын хилийн харилцааны загвар, гадаадын жишээн дээр 50

Пограниометрикийн үндсүүд

Пограниометрикт нийтийн үйлчилгээний системийг хэрэглэх нь 61

Богино болон бэсрэг өгүүллүүд

Цэргийн дарга бүхэн багш байх үүрэгтэй учраас тэднийг багш болгож бэлтгэх ёстой 69
Бэсрэг бичвэрүүд 71

Монголын Хил Судлалын Академийн гишүүн судлаачид бичиж байна

Х.Гөлгөө: Оюуны зураглал хэмээх шинэ бичиг үсэг 72

Философи судлаачийн булан:

Д.Бухбат: Буддын гүн ухаан бол манай ертөнцийн хамгийн ууган шинжлэх ухаан мөн 81

Хил хамгаалалтын инноваци:

Т.Баяр-Эрдэнэ: Хилийн манааны цана төсөл 85

Хэлтэй бол хөлтэй:

Английские пословицы и поговорки 88

Чөлөөт цагийн булан:

Сталины алиаллууд 91

Эрхлэгчийн зурвас

НОМЫН АВРАЛД ИТГЭЭ

(Чой Ла Жав Сү чий)

(Номыг уншиж, сэтгэлдээ дадуулан, улмаар гэгээрэлд хүрэх зам мөрөө засахын тухайтад мэргэд ингэж айлдаж...)

"Дээдийн шидэд хүрэх гэж бий. Тэр нь үндсэндээ гэгээрч байгаа нь юм. Хэн ч бидний өмнөөс гэгээрэлд хүрэхгүй, хэн ч гэгээрлийг бидэнд өгөхгүй, номыг хүртэж өөрийн сэтгэлийн урсгалд дадуулсан нэгэнд л гэгээрэл ирэх нь магадтай. Номыг тогтон сууж, уншин бясалгаснаар бидний амьдрал түүнтэй нэг болж, үтэр түргэн гэгээрэлд хүрэх боломжтой болно, авралыг өөрийн дотоод мөн чанараасаа хай" гэж Дээрхийн Гэгээнтэн 14 дүгээр Далай лам айлджээ. Хэзээ ном уншдаг, номонд сүслэдэг, ***авралыг*** (ажил сайжруулах аргыг) номноос хайдаг болцгоох вэ? Номтой нөхөрлөж байж л, "юм" (мэдлэг)-тай болдог гэж мэргэд айлддаг сан.

Амьдрал баян. Ингэнэ, тэгнэ гэсэн бэлэн жор байхгүйгээс хойш ажлыг сайжруулах аргыг, амжилтанд хүргэх нууцыг ном, сэтгүүл уншиж хайна, юм юм сонсож хайна. Ахмадаасаа асууж хайна, анд нөхөдтэйгээ маргаж хайна, ажлынхантайгаа зөвлөж хайна. Эцэс төгсгөлгүй эрэлд хатаж, энд тэндгүй хайна, сурал болж, эрэл хийхэд ном тусална.

Та өөрийнхөө төлөө 100 хувь хариуцлага хүлээнэ гэдэг бол бүх буруутай эзэн та өөрөө гэдгийг хүлээн зөвшөөрөхөд хамаг учир байдаг аж. Амьдралынхаа бүх үйлдлийн эзэн шалтгаан нь зөвхөн өөрөө гэдгийг хүлээн зөвшөөрч байж, өөрийн хүсэл мөрөөдлийг биелүүлэхийн төлөө өөрөө ухамсартайгаар зүтгэж чаддаг гэнэ.

Ном бол нүүр харж, тал засдаггүй, ачилж аварсныхаа шанг горьддоггүй, үнэгүй туслагч, үнэнч зөвлөгч. ***"Ухаантай хүнд зөвлөгөө хэрэггүй, тэнэг хүнд бүр ч хэрэггүй. Тэнэгүүд түүнийг хэзээ ч хэрэглэдэггүй"*** гэж "Амьдралын алтан ном"-д бичиж, ***"Хүмүүс зан авираа засаж сайжруулахгүй, сургаж хэлээд байгаа юмыг ойлгохгүй, бас үүргээ мэдэж буй атлаа түүнээ биелүүлж, гэм согогоо хаяж гээх чадваргүйг хараад би гасалж ганихрах юм даа"*** гэж Кунз сургаж.

Огт байхгүй юманд итгэх нь төөрөгдөл мөн. Харин мэдрэхгүй, ойлгож хүчрэхгүй байгаа болгоноо огт байхгүй мэтээр няцаах нь түүнээс дутахгүй төөрөгдөл мөн. Хүн, аливаа хүндрэл, бэрхшээл зовлонгийн учир шалтгааныг өөрөөсөө эрэх дургүй амьтан. Ер нь миний бяргүйгээс, хурдан гүйж чаддаггүйгээс, хувийн сэрэмж дутсанаас ингэлээ гэж гунихын оронд, онгон модны мөчир хугалсан, тахил шүтээнийг гомдоосон зэрэг хөндлөнгийн учир шалтгаантай хэмээн үзэх нь хамаагүй хялбар аж. Түүнчлэн модонд очиж мөргөөд асуудлыг шийдэх нь өөрөө хурдан гүйдэг болох, огт заяагаагүй овсгоо самбааг эзэмшихээс хямд төсөр ажээ. Хүн чадал мөхөсдөхийн хэрээр сүсэглэх хэрэгцээ гарна. Үүнийг өрнөдийн мэргэд ***"бодит боломж багасахын хэрээр хий горьдлого ихэснэ"*** хэмээн томъёолсон удаатай.

Танин мэдэх үйл ажиллагааны үр дүнд хүний эзэмших үйлийн баримжааг тодорхойлох тухайн судлагдахуун болон ур ухааны нэгдлийн тогтолцоог ***мэдлэг*** гэдэг байна. Өнөө бид, хувь хүний хувьд мэдлэгтэй мэдээлэлтэй ***хүн,*** шүтээний хувьд **мэдлэг,** хувирах нөөцийн хувьд ***оюун ухааны нөөц***, хөгжлийн шатны хувьд ***оюуны технологийн хөгжлийн эрчимжилтийн шатандаа орох*** үед амьдарч байна.

Юм уншилгүй мэдлэг хуримтлуулсан, ном шүтэлгүй эрдэмд ***гэгээрсэн*** бодгаль одоохондоо гараагүй байна.

Ном бол шагналд өгдөг халуун сав, баярын бичиг, хэдэн халтар төгрөгний аль аль нь ч биш, харин сайн хүмүүсээ **шагнаж урамшуулмаар үнэтэй цайтай эд**. Манайхан "юмхан"-аар шагнаад, номоор шагнадаггүй нь сонин. Эндээс л номонд хандах хандлага нь харагдаад байгаа юм.

Сурсан болж хуурамбууд, дипломны булангаас зуурамбуудад л хэрэггүй байдаг юм уу гэхээс биш, ном бол манай залуус бие биенээсээ эрж сураад, урьтаж унших гэж уралдаж давхиад, тэртээ холоос тэн тэнгээр нь тээж ирээд хүртэж суумаар эрдмийн охь, эрднийн шижир л юм шүү дээ...

...Миний өмнө Үенчийн хилийн отрядын 2013 оны эхний 10 сараар авсан офицер, ахлагч, энгийн ажилчдын уншсан номын жагсаалт байна. Нийт 47 уншигч давхардсан тоогоор 176 ном уншсаныг дундажлавал нэг хүн ойролцоогоор 4 ном уншсан нь энэ жагсаалтаас харагдана. Эдгээр 47 хүний нэг (ангийн захирагч) нь 10 сарын дотор 26 ном уншсан нь анхаарал татах агаад, Хил хамгаалах байгууллагын хэмжээнд хэд дүгээр байранд орох бол гэж бодохоор... уралдуулаад үзмээр, урамтай санагдана...

Энэ отряд яах аргагүй, ХХЕГ-ын удирдлагын өгсөн "хүнээ хөгжүүлэх" үүргээ биелүүлж, хүмүүсээ гэгээрэл өөд хөтлөж яваа, хүмүүсийнхээ сэтгэлийг хөглөж байгаа отряд мөн харагдана.

Хүн байхын тулд гурван тэнхээтэй байх ёстой гэдэг. Нэгдүгээрт, сэтгэлийн тэнхээтэй; хоёрдугаарт, биеийн тэнхээтэй; гуравдугаарт, мэдлэгийн тэнхээтэй байх ёстой байнам. Дэлхийн болоод манай сонгодгууд ***"...ганцхан бурхан буй тэр бол мэдлэг"*** (Сократ) хэмээгээд, ***"Баяжихыг бус боловсорч гэгээрэхийг хичээ. Эд баялаг амархан, үрэн таран болно, эрдэм ухаан хэзээ ч үрэгдэж алга болдоггүй"*** (Эзоп) ***"Үзэх, мэдрэх гэгч нь орших гэсэн, сэтгэх, хөдөлмөрлөх гэгч амьдрах гэсэн үг"*** (Виллиан Шекспир), ***"Мэднэ, сурна гэдэг ялна, дийлнэ гэсэн хэрэг"*** (А.Несмеянов) үүний тулд, ***"Зун цагийн болжмор мэт эрт босож бай. Хүмүүний амьдрал гэдэг, өвлийн өдөр шиг богинохон"*** (М.Шагдарсүрэн) гэжээ.

"Мэдэж, сурах"-ын эрэлд мордогсдын, эдэлж болохгүй эрх нь ***"залхуурал"*** агаад, ***"Залхуу бол цаг хугацаагаар өл залгагч адгуус"*** (А.Декурсель), ***"Залхуу бол бие, сэтгэлийг царцаан хөлдөөгч"*** (В.Белинский), ***"Залхуу бол ухаан бодол, бие махбодийг гэмтээгч зэв"*** (М.Монтень), ***"Залхуурал бол хэн бүхэнтэй хялбархан эвлэрдэг дайсан"*** (Ф.Ларошфуко), ***"Залхууран зүгээр суугч бол, зүүгүй цагтай адил"*** (Ф.Купер), ***"Залхуурч суух нь, аз жаргалаасаа зугтаж байгаа хэрэг"*** (М.Достоевский) болохоор залхууралтай заавал тэмцэж, ямарч нөхцөлд ялан дийлэх хэрэгтэй болох нь.

Номонд шамдахад ойлгоцын дөрвөн хэлбэр байдаг. Энэ нь үсэгчлэн чээжлэх, ерөнхий утгыг олох, далд утгыг мэдрэх, амин утгыг ойлгох болой. Жинхэнэ гэгээрэлд хүрэх гэвэл номын амин утгыг олох хэрэгтэй. Тэрхүү "амин утгыг сэтгэлдээ дадуулах" шаардлагатай.

"Сайн номыг унших нь сарууль ухаант хүнтэй ярилцах адил" (Н.Толстой) агаад, ***"Хүнийг нөхөрлөж буй нөхрөөр нь танихын адил, уншиж буй номоор нь таньж болдог"*** (С.Смайлс) болохоор, ***"Надад байгаа сайн сайхан бүхэн номын ач"*** (М.Горький), ***"Номын ачаар бидний дотоод сэтгэлийн ертөнц нээгдэж, хорвоо ертөнцийг танин мэдэх бяр суудаг"*** (С.Цвейг)-аас, ***"Номын ертөнцөд умбахдаа бид хорвоогийн хаад ноёдын чуулганаас илүү баяр***

хөөрийг эдэлдэг" (Бокачо) байнам.

Ертөнцийн гурван цагааны нэг: ***"өөдлөхөд номын мөр цагаан"***, гурван харанхуйн нэг: ***"номгүй хүний тархи харанхуй"***, гурван хайрны нэг: ***"уншиж сураагүйд ном хайран"***, гурван чимэгийн нэг: ***"сайхан ном ухааны чимэг"***, гурван сайхны нэг: ***"эргүүлж уншихад ном сайхан"***, гурван тусын нэг: ***"төөрөлдөж явахад номын тус"***, гурван шившгийн нэг ***"унших дургүй хүнийг, сонсох хүртэл шившиг"***, гурван бүтний нэг: ***"уншиж судалдгийн ухаан бүтэн"***, гурван тэнэгийн нэг: ***"эрхэм тэнэг номоо магтана"***, гурван холын нэг: ***"уншдаггүй хүнд ном хол"***, гурван бугийн нэг: ***"номгүй оюутан сургуулийн буг"***, гурван давхрагын нэг: ***"өргөн мэдлэг номын давхаргатай"***, гурван ханийн нэг: ***"оюутан хүнд ном хань"***, гурван нууцын нэг: ***"уншаагүй номын утга нууц"***, гурван баяны нэг: ***"эрдэмтэй хүний толгой баян"***, гурван хоосны нэг: ***"номгүй хүний толгой хоосон"***, гурван хөөрхийн нэг: ***"гэртээ номгүй айл хөөрхий"*** гэснээс үзвэл гэртээ номгүй хүн, гавалдаа юмгүй, аягүй бол "сум"-тай байж мэдэх гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Ном уншдаг хүн дэлхийгээр сэтгэдэг, уншдаггүй хүн "дэнж"-ээрээ сэтгэдэг болохоор НОМ бол Ц.Дамдинсүрэн гуайн хэлсэнчлэн: Өндөр ууланд шат шүү, өргөн далайд сал шүү, харанхуй мунхагт зул шүү, харгүй замд газарч шүү, бөглүү замд хүнс шүү, бүгд газар хөтөч шүү, ядрахад үл орхих янаг шүү, ямарч үед алдагдахгүй эрдэнэ шүү.

"Өдөр цаг бүхэн өлзий буян, од, гараг бүхэн онцгой сайн, муу сэтгэлээ ялагч бүхэн зовлонгүй, мунхгийн нойроос сэрэгч бүхэн чадал төгөлдөр" гэж Будда сургасан нь "Найман гэгээн" сударт дурайн үлджээ.

Үүнийг цухас үгүүлэн цааш үгүүлэх нь, Монголын Хил Судлалын Академи "Хил шинжлэл" сэтгүүлийнхээ анхны дугаараар эрхэм уншигч тантай учран золгож байна. Яагаад "Хил шинжлэл" гэж нэрлэснийг уншигч та сонирхож байгаа. Судлах, шинжлэх хоёр хоршиж хэрэглэгдэх нь ховор ажээ. Эрдэмтэн Я.Цэвэлийн тайлбарласан *(Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1966. х.487)*-аар судлах гэдгийг сураглах, ажиглах, турших замаар учир шалтгааныг олж мэдэх гэсэн бол, шинжлэх (исследовать) гэдэг үгийг 1. Шинжлэх; исследовать законы природы-байгалийн хууль шинжлэх 2. Шинжих, нарийвчлан үзэх *(Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. Орос-Монгол толь. УБ. 1982. Х.201)* гэжээ. Эндээс үзвэл судлаач нь <<сураглах, ажиглах, турших /судалгаа хийх/ замаар учир шалтгааныг олж мэддэг>> бол, шинжээч нь <<тухайн шинжлэх ухааны хууль, зүй тогтлыг шинжих, нарийвчлан үзэх>> чадвартай, судлаачаасаа тохой өндөр, толгой илүү мэргэжилтэн учраас, манай залуу судлаачид түргэн боловсорч шинжээчийн зиндаанд хурдан хүрээсэй, хил шинжлэлийн материалаар, эл сэтгүүлээ дараад өгөөсэй гэсэн холын бодлоор энэ нэрийг сонгосон болой.

Шинжлэх ухаан гэдэг бол "бодит байдлын тухай үнэн зөв мэдлэг буй болгож, түүнийг онолын хувьд цэгцлэх хүний үйл ажиллагаа" юм. Далдыг харах авъяас хүн болгонд заяадаггүй болохоор, таны хариуцсан албаны "бодит байдал", судалгаа шинжилгээгээр л тодорхой болно.Тэгвэл, энэ судалгаа шинжилгээг чинь хэн хийх юм бэ гэж асуух гэж байна уу? Та хийнэ, тийм ээ, тухайн отряд (анги)-од байгаа доктор, магистр, бакалавр зэрэгтэй **хүн болгон** хийнэ.

Тусгайлан сургагдаж бэлтгэгдэн, судалгаа шинжилгээний аргазүй эзэмшсэн, эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхлэх эрхийн үнэмлэх (доктор, магистр, бакалаврын диплом) авч, <<Эрдэм шинжилгээний ажилтан>> байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан

бүх хүмүүс энэ ажлыг хийнэ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 6 дугаар сарын 11-ний "Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 201 тоот тушаалын хавсралт, "Эрдэм шинжилгээний ажилтанд зэрэг дэв олгох шалгуур үзүүлэлт"-эд заасан:

-Шинжлэх ухааны доктор-эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

-Доктор (Ph.D)-эрдэм шинжилгээний ахлах ажилтан

-Магистр-эрдэм шинжилгээний дэд ажилтан

-Бакалавр-эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан доктор, магистр, бакалавр зэрэгтэй хүмүүс (тэдний тоог отряд, отрядоороо, отряд, нэгж, албад, салбаруудын хэмжээнд нэг бүрчлэн гаргаад үзээрэй, бараг бүгдээрээ байгаа, хараад та гайхах болно, гайхаад байх юм байхгүй, байгаагаа бид мэддэггүй л байсан) хийнэ. Ийнхүү шинжилгээ судалгаатай ажилласнаар ажлаа мэддэг, албаа таньдаг болно. Хил хамгаалалтанд шинжлэх ухааны хандлага төлөвших эх суурь тавигдана. Энэ үйлсэд "Хил шинжлэл" сэтгүүл хилчидтэйгээ хамтдаа зүтгэнэ.

Д.Нямдорж

МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИ БАЙГУУЛАГДАЖ НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ

Хил Хамгаалах Байгууллагаас төрсөн эрдэмтдийн санал санаачлагаар, Монгол Улсад Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, хил хамгаалалтад шинжлэх ухааны хандлага төлөвшүүлэн, шинэ техник технологи нэвтрүүлж, хилийн аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагааг мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилан зохион байгуулахад, Хил хамгаалах болон бусад салбарын эрдэмтэн, судлаачдыг нэгтгэсэн бие даасан байгууллага болох Монголын Хил Судлалын Академийг үүсгэн байгуулж 2016 оны 7 дугаар сарын 1-нд нээлтээ хийж анхны хуралдайгаа зохион байгууллаа.

Хуралдайн тэргүүлэгчээр доктор, профессор П.Даш, доктор, профессор С.Гүржав, доктор, профессор Д.Нямдорж нар ажиллаж, ХХЕГ-ын дарга доктор, хошууч-генерал Ш:Лхачинжав урилгаар оролцсон юм.



Хуралдай дэгийн дагуу үргэлжилж, “Монголын Хил Судлалын Академийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл”-ийн талаар П.Даш мэдээлэл хийж, Д.Нямдорж “Монголын Хил Судлалын Академийн дүрэм”-ийн төслийг танилцуулсан ба С.Гүржав Зохион байгуулалтын асуудал хэлэлцүүлэн, Академийн Ерөнхийлөгчөөр доктор, профессор П.Даш, дэд ерөнхийлөгчөөр доктор, профессор Д.Ганбаатар, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор, профессор Д.Нямдорж, ажлын албаны даргаар доктор, профессор Ц.Цэрэндорж, тэргүүлэгч гишүүдээр доктор, профессор С.Гүржав,.доктор, профессор Н.Наранжамц, доктор, профессор Ц.Ганболд, доктор, профессор А.Муратхан нар сонгогдлоо. Монголын Хил Судлалын Академийн хэвлэл болох “Хил шинжлэл” сэтгүүлийг улирал дутам гаргаж байхаар шийдвэрлэв.

Хуралдайн төгсгөлд уг арга хэмжээнд оролцсон эрдэмтдийн төлөөлөл хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлж санал бодлоо солилцов.



Академи байгуулагдсантай холбогдуулан уншигчдаас асуух зүй ёсны зарим асуултанд товч хариулт бэлтгэснээ хүргэе.

МХСА ЮУ ХИЙХ ЮМ БЭ?

МХСА-ийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг, сэтгүүлд нийтлэгдсэн Академийн дүрмийн <<Академийн үйл ажиллагааны зорилго, зорилт>> хоёрдугаар хэсгээс уншигч дэлгэрэнгүй танилцах боломжтой.

АКАДЕМИЙН ГИШҮҮН ХЭН БАЙХ ВЭ?

Тусгайлан сургагдаж бэлтгэгдэн, судалгаа шинжилгээний аргазүй эзэмшсэн, эрдэм шинжилгээ судалгааны ажил эрхлэх эрхийн үнэмлэх (доктор, магистр, бакалаврын диплом) авч, << Эрдэм шинжилгээний ажилтан>> байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан бүх хүмүүс энэ академийн гишүүн байж үйл ажиллагаанд нь оролцох юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 6 дугаар сарын 11-ний "Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 201 тоот тушаалын хавсралт, "Эрдэм шинжилгээний ажилтанд зэрэг дэв олгох шалгуур үзүүлэлт"-эд заасан:

-Шинжлэх ухааны доктор-эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан

-Доктор (Ph.D)-эрдэм шинжилгээний ахлах ажилтан

-Магистр-эрдэм шинжилгээний дэд ажилтан

-Бакалавр-эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан доктор, магистр, бакалаврууд академийн гишүүн байж, <<Монголын Хил Судлалын Академийн академич>> болох цаашдын ирээдүй хүлээж байна.

Хил судлалаас бусад салбарын доктор, магистр, бакалаврууд танай академийн гишүүн байж болох уу?

Бид шинжлэх ухааны төлөө гэсэн нэгэн зорилгод нэгдсэн хүмүүс, шинжлэх ухааны судалгаа хийдэг, эрдэм шинжилгээний ажилтан болгон манай "хамаатан", хамаатнаа халуун дотно хүлээн авалгүйдээ.

ТИЙМ ХҮМҮҮС ОТРЯД (АНГИ)-УУДАД АЛЬ ХЭР ОЛОН БАЙДАГ ЮМ БОЛ?

Үүнийг нэгэн отрядын жишээн дээр авч үзье л дээ. Энэ отрядод 5 магистр, 200 орчим бакалавр байна гэвэл Хил хамгаалах байгууллагын хэмжээнд хэдий тооны эрдэм шинжилгээний ажилтан (шинжилгээ судалгааны ажил эрхлэх эрхтэй, эрхээ дагаад үүрэгтэй) хичнээн байгаа нь тодорхой болно.

Тэгээд яагаад хүн бүхэн, албад болгон судалгаа шинжилгээтэй ажиллаж чадахгүй байна вэ?

Эдгээр магистр, бакалаврууд эрдэм шинжилгээний ажил (судалгаа шинжилгээ хийх) эрхлэх үүрэгтэй гэдгээ ойлгодоггүй, дээрээс нь тэгэж шаарддаггүй, энэ тал дээр дээр доргүй ойлголт нэгдээгүйгээс зай завсар үүсээд гай болоод байгаа юм.

Энэ бүгд Хил хамгаалах байгууллагын бодлого зорилттой яаж уялдах юм бэ?

Хил хамгаалах байгууллагын удирдлага "Хил хамгаалах албаны үйл ажиллагааг судалгаа шинжилгээнд тулгуурлан зохион байгуулж, шинжлэх ухааны үндэстэй шийдвэр гаргах, улсын хил хамгаалатанд шинжлэх ухааны хандлага төлөвшүүлэн, шинжлэх ухааны хангалтаар хангах.." **шинэ мянганы** гэмээр сайхан зорилт дэвшүүлсэн билээ. Тэгвэл энэ их хүч, эрдэм шинжилгээ, судалгааны ажилтны энэ том "арми" энэ өргөн фронт дээр тулалдах болж байна. Энэ бүгдийг ойлгуулахаас ажлаа эхэлж, тэр болгоныг уншигчиддаа нарийвчлан тайлбарлаж байгаа маань ойлголтын зөрүүгээ багасгах гэсэн манай ажлын анхны алхам юм.

МОНГОЛЫН ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИЙН ДҮРЭМ

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Монголын Хил Судлалын Академи "Монголын хил судлалын академи" (цаашид Хил судлалын академи гэж нэрлэнэ) нь Монгол Улсад Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэн, хил хамгаалалтад шинэ техник технологи нэвтрүүлж, шинжлэх ухааны хандлага төлөвшүүлэн, хилийн аюулгүй байдалд хандах хандлага, түүнийг хангах үйл ажиллагааг мэдлэг, мэдээлэл, дүн шинжилгээнд суурилан зохион байгуулахад, Хил хамгаалах болон бусад салбарын эрдэмтэн, судлаачдыг нэгтгэсэн бие даасан, Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан төрийн бус, шинжлэх ухааны байгууллага мөн.

1.2. Монголын Хил Судлалын Академи нь өөрийн үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр тэгш эрхтэй оролцоо, хууль дээдлэх зарчим дээр тулгуурлаж явуулна.

1.3. Монголын Хил Судлалын Академи нь Монгол Улсын нутагт өөрийн үүрэгт ажлыг Монгол Улсын Үндсэн хууль, "Төрийн бус байгууллагын тухай" хууль, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрэмд нийцүүлэн явуулна.

1.4. Монголын Хил Судлалын Академи нь хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.

Монголын Хил Судлалын Академи нь бие даасан санхүү, харилцах данстай байна.

1.5. Монголын Хил Судлалын Академийн ажилчид Монгол Улсын хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хяналтын тухай хуулийн заалтыг эдлэх эрхээр хангагдана.

1.6. Монголын Хил Судлалын Академи нь өөрийн тамга, тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудас, билэгдэл харилцааны бусад таних тэмдэг, нэрийн хуудас ашиглана.

1.7. "Монголын Хил Судлалын Академийн байршил"

Монгол Улс. Улаанбаатар хот.

Улаанбаатар хот.Баянзүрх дүүрэг. Хууль Сахиулахын Их Сургууль.

Хичээлийн III байр. 406 тоот.

Утас:99850602

E-mail: ndj_0112@yahoo.com

1.8. Монголын Хил Судлалын Академи нь өөрийн тусгай салбаруудыг хилийн отряд, ангиудад байгуулж ажиллуулах ба тэдгээрийг байгуулах, үйл ажиллагаа явуулах, удирдлагыг нь томилох шийдвэрийг Хил судлалын академийн тэргүүлэгчдийн хурлаар, энэ талаар гаргасан тусгай журмыг үндэслэн гаргана.

Салбарууд нь, Хил Судлалын Академийн өөрт оногдсон үүргийг хэрэгжүүлэх ба хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.

ХОЁР. АКАДЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1.Академийн зорилго нь: Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, шинжлэх ухааны мэдлэгт суурилсан хил хамгаалалтыг шинэ мэдлэг, мэдээлэл, дэвшилтэт технологиор хангахад оршино.

2.2.Хил Судлалын Академи нь зорилгодоо хүрэхийн тулд шинжлэх ухааны мэдлэгт суурилсан хил хамгаалалтад шилжихэд чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцогчдын бүтээлч, идэвхтэй үйл ажиллагааг дэмжих замаар хил хамгаалалтад хэрэглэх шинэ мэдлэг, дэвшилтэт технологийг тасралтгүй буй болгож, улсын хил хамгаалалтын чанар үр дүнг дээшлүүлэх замаар дараах

үндсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1. Хил Судлалын Академийн үндсэн зорилтуудыг хангах чиглэлээр Хил хамгаалах байгууллагын харъяаны боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагууд (Шинжлэх ухаан технологийн төв зөвлөл, Хилийн түүх, стратеги судлалын сектор, Хилийн түүхийн музей, Төв архив, Төв музей, Хилийн сургууль, Хил судлалын төв, Хилийн отряд, ангиудын шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлүүд)**-тай нягт хамтран ажиллаж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд шинжлэх ухааны дэмжлэг үзүүлэх**.

2.2.1.1 Хил хамгаалах байгууллагын харъяа сургалт эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байгаа эрдэмтэд судлаачид, хилчин офицеруудтай хамтран хил хамгаалалтанд шаардлагатай судалгаа шинжилгээний ажил хийж улсын хил хамгаалалтанд нэвтрүүлэх тогтолцоо, механизмыг бүрдүүлнэ.

2.2.1.2. Хил хамгаалалтанд шаардагдах Шинжлэх ухааны салбар түүний эрдэмтэд, судлаачидтай гэрээ байгуулж хамтран ажиллана.

2.2.2. Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг, хил хамгаалах бодлого, үйл ажиллагааны үндэс болгох.

2.2.2.1. Хилийн аюулгүй байдлыг хангах тулгамдсан асуудлыг судлан, шийдвэр гаргах зөвлөмж боловсруулна.

2.2.2.2. Хил хамгаалах урлагийн асуудлаар суурь, хавсарга, хэрэглээний судалгаа явуулж, захиалгат төслийг хэрэгжүүлэх асуудлыг жил бүр төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлнэ.

2.2.2.3. Хил судлалын шинжлэх ухаанаар шинжлэх ухааны болон боловсролын доктор бэлтгэх тогтолцоог Хил хамгаалах байгууллагад бий болгоход мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ.

2.2.2.4. "Хил шинжлэл" сэтгүүлийг эрхлэн гаргаж, Хил судлалын болон бусад салбарын эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл туурвилыг хэвлэн нийтэлж, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулж, ном бүтээл хэвлэн гаргана.

2.2.2.5. Дотоод гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачдын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгааны үр дүнг Хил хамгаалах байгууллагад хэрэгжүүлэх, дэвшилтэт технологи нутагшуулахад чиглэсэн санаачилга гаргаж ажиллах, судалгаа, шинжилгээний үр дүнг нэвтрүүлэх, патентлах, худалдах ажлыг зохион байгуулна.

2.2.2.6. Эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг оновчтой болгож, судалгаа, туршилт, зохион бүтээлтийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

2.2.3. Хил хамгаалах байгууллын харъяа сургалт эрдэм шинжилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд хилчин эрдэмтдээс дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах.

2.2.3.1. Хилийн сургуулийн доктор, магистр, баклаврын сургалт болон хилчдэд зориулсан бусад сургалт дамжаанд хилчин эрдэмтэд, судлаачдаар хичээл заалгах асуудлыг хилийн сургуультай хамтран жил бүр зохион байгуулна.

2.2.3.2. Хил хамгаалах байгууллага, түүний харъяа сургалт эрдэм шинжилгээний байгууллагаас зохион байгуулж байгаа сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөнд эрдэмтдийг идэвхтэй оруулцуулах замаар хил хамгаалах байгууллагын бодлого үйл ажиллагааг байнга мэдэрч үйл ажиллагаатайгаа уялдуулан ажиллаж хэвшүүлнэ.

2.2.3.3. Хил хамгаалах байгууллагын шугамаар эрдэм шинжилгээний байгууллага, Хилийн

сургууль, бусад сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээ, сургалт, магистр, докторын зэргийн сургалт, хамгаалалтад оролцож эрдэмтэн бэлтгэнэ.

2.2.4. Сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулах.

2.2.4.1. Дангаараа болон гадаад, дотоодын байгууллага, Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудтай хамтран туршилтын түшиц газар байгуулж, курс, дамжаа хичээллүүлнэ.

2.2.5. Хил хамгаалах байгууллагыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангах.

2.2.5.1. Гадаадын орнууд, олон улсын байгууллагуудтай туршлага, мэдээлэл солилцох, тэдний болон өөрийн орны хилчдийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх зэргээр олж авсан тэргүүний арга барил, туршлага сургамжийн талаарх мэдээллээр хил хамгаалах байгууллагыг хангаж ажиллана.

2.2.6. Хил хамгаалалтыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулж явуулах, хилчдийн сэтгэлгээнд шинэчлэл хийх талаар Хил хамгаалах байгууллагатай байнга нягт хамтран ажиллах

2.2.6.1. "Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалах бодлого, үйл ажиллагааны үндэс болгох" зорилтыг хэрэгжүүлж байж, хил хамгаалалтад чанарын өөрчлөлт гарна гэдгийг бүх шатны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудад бүрэн ойлгуулж нийт хилчдийн сэтгэлгээнд шинэчлэл хийнэ.

ГУРАВ. ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИЙН ГИШҮҮН, ТЭДНИЙ ЭРХ ҮҮРЭГ

3.1. Монгол Улсын болон гадаадын иргэн академийн гишүүн байж болно.

3.2. Академийн гишүүн нь Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, хил хамгаалалтад шинжлэх ухааны хандлага төлөвшүүлэн, түүний арга тактикийг боловсронгуй болгоход тодорхой хувь нэмэр оруулсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн, мэргэжилтэн, 18 нас хүрсэн хүн байж болно.

Академи нь хуулийн этгээд болох их дээд сургуулиуд, коллеж, үйлдвэр, албан байгууллага зэрэг хамт олны гишүүнчлэлтэй байж болно. Хамт олны гишүүнчлэлээр элсүүлэх асуудлыг хуулийн этгээдийн бүрэн эрхт төлөөлөгчийн албан ёсны бичгээр өгсөн өргөдлийг үндэслэн Монгол Улсын хуулийн дагуу Академийн тэргүүлэгчдийн шийдвэрээр хэрэгжүүлнэ.

Хил Судлалын Академи нь өөрийн жинхэнэ гишүүн /академич/, сурвалжлагч гишүүн, хүндэт гишүүн, идэвхтэн гишүүдтэй байж болно. Хүндэт гишүүн болон идэвхтэн гишүүнийг Мэдээлэл Судлалын Академийн тэргүүлэгчдийн хурлаас харин жинхэнэ гишүүн, сурвалжлагч гишүүнийг МХСА-ын хуралдайгаас гишүүдэд тавигдах шаардлагыг үндэслэн сонгож байна.

3.3. Хил Судлалын Академийн гишүүний эдлэх эрх

3.3.1. Хил Судлалын Академийн удирдах байгууллагыг байгуулахад оролцох, удирдах бүрэлдэхүүнд сонгогдох;

3.3.2. Хил судлалын академиас зохион байгуулах бүх арга хэмжээнд оролцох;

3.3.3. Хил Судлалын Академийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар дээрх академийн холбогдох байгууллагуудад санал дэвшүүлэх;

3.3.4. Хил Судлалын Академид өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалуулахаар хандах;

3.3.5. Хил Судлалын Академийн диплом, хүндэт үнэмлэхээр шагнагдах, Олон улсын шагнал, Монгол Улсын төрийн шагналын өргөмжлөлд нэр дэвшигдэх;

3.4. Хил Судлалын Академийн гишүүний үүрэг.

3.4.1. Хил Судлалын Академийн дүрэм, академийн тэргүүлэгчдийн болон нэгдсэн хуралдайн шийдвэрийг биелүүлэх;

3.4.2. Хил Судлалын Академийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг сурталчлах;

3.4.3. Хил Судлалын Академид төр, нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн, мэргэжилтэнг татан оролцуулах;

3.4.4. Хил Судлалын Академийн үндсэн зорилтуудыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцуулах;

3.4.5. Хил Судлалын Академийн гишүүдийн нэгдсэн хуралдайгаар тогтоосон хэмжээ, хугацаанд багтаан гишүүний элсэлтийн татварыг тушаах

3.5. Хил Судлалын Академийн гишүүнчлэлээс гаргах үндэс нь гишүүнээс чөлөөлж өгөхөөр хүссэн гишүүний өргөдөл байх болно. Өргөдлийг өгсөн өдрөөс эхлэн 2 сарын дотор Хил Судлалын Академийн гишүүдийн нэгдсэн хуралдайгаар хэлэлцэнэ.

3.6. Хил Судлалын Академийн гишүүн нь академийн үүрэг, өр төлбөрийн төлөө хариуцлага хүлээхгүй. Академи ч гишүүний өр төлбөр түүний үүргийн төлөө хариуцлага хүлээхгүй.

ДӨРӨВ. ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИЙН УДИРДАХ БАЙГУУЛЛАГА

4.1. Хил Судлалын Академийн дээд байгууллага нь тус академийн гишүүдийн нэгдсэн хуралдай байна.

4.2. Нэгдсэн хуралдайг жилд 1-ээс доошгүй удаа хуралдуулна. Ээлжит бус хуралдайг шаардлагатай үед Хил Судлалын Академийн ерөнхийлөгч буюу тэргүүлэгчдийн санаачлагаар хуралдуулж болно.

4.3.Нэгдсэн хуралдайн бүрэн эрх:

4.3.1. Хил Судлалын Академийн үйл ажиллагааны стратеги, тактикийг боловсруулна.

4.3.2. Академийн дүрэм, хөтөлбөрийн бичиг баримт тэдгээрт оруулах нэмэлт өөрчлөлтийг авч хэлэлцэнэ.

4.3.3. Академийн гишүүнээр элсэгчдийн өргөдлийг хүлээн авч хэлэлцэж, академийн бүрэлдэхүүнд оруулж, сонгосон тухай шийдвэрийг гаргана.

4.3.4. Академийн ерөнхийлөгчийг 5 жилийн хугацаагаар сонгоно.

4.3.5. Академийн дэд ерөнхийлөгчийг сонгоно.

4.3.6. Эрдэмтэн нарийн бичгийн даргыг сонгоно.

4.3.7. Хянан шалгах комиссыг сонгоно.

4.3.8. Академийн ерөнхийлөгч, тэргүүлэгчид, хянан шалгах комиссын үйл ажиллагааны тайланг сонсоно.

4.3.9. Нэрэмжит шагнал, тэтгэлэг, хүндэт цол, медалийг баталж эдгээр шагналыг олгох тухай шийдвэр гаргана.

4.3.10. Академийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн өөрчлөх, үйл ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргах.

4.3.11. Хил Судлалын Академийн үйл ажиллагаанаас урган гарсан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.3.12. Хил Судлалын Академийн гишүүдийн 50 хувиас доошгүй бүрэлдэхүүн оролцсон хуралдайг хүчинтэйд тооцогдоно. Академийн салбар, хэсгүүд нэгдсэн хуралдайд тэдгээрийн дүрэмд заасан журмын дагуу оролцоно.

Хуралдайд оролцогсдын ихэнх

/50 хувь +1 санал/ өгснөөр хуралдайн шийдвэр хүчин төгөлдөр болно.

4.4. Хил Судлалын Академийн нэгдсэн хуралдайн хооронд удирдах байгууллага нь тэргүүлэгчид байна. Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүн нь 5-аас доошгүй байх ба бүрэлдэхүүнд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид, эрдэмтэн нарийн бичгийн дарга бусад гишүүд орно.

4.5. Мэдээлэл Судлалын Академийн тэргүүлэгчдийн бүрэн эрх.

4.5.1. Академийн үйл ажиллагааг удирдана.

4.5.2. Нэгдсэн хуралдайг, тэр дотроос ээлжит бус хуралдайг хуралдуулах, бага хурал, чуулга уулзалт явуулах, тэдгээрийн хэлэлцэх асуудал, дотоод журмын тухай шийдвэр гаргах.

4.5.3. Академийн салбар, нэгжийг байгуулах, тэдний удирдах байгууллагыг батлах, үйл ажиллагааны тухай тайланг сонсох.

4.6. Мэдээлэл Судлалын Академийн ерөнхийлөгчийн бүрэн эрх:

4.6.1. Академийн шинжлэх ухаан, зохион байгуулалтын үйл ажиллагааг мэдээлэл сурталчилгааны ерөнхий удирдлагаар хангах.

4.6.2. Тавигдаж байгаа зорилтуудтай уялдуулан тэргүүлэгч гишүүдийн үүргийг хуваарилах, тодотгох.

4.6.3. Академийн тэргүүлэгчдийн ажлыг уялдуулан зохион байгуулах, хуралдааныг удирдах, тэргүүлэгчдийн шийдвэрт гарын үсэг зурах.

4.6.4. Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд зохион байгуулалтын өөрчлөлт оруулах тухай нэгдсэн хуралдайд санал дэвшүүлэх.

4.6.5. Хил Судлалын Академийн салбар хэсгийн дүрмийг батлах.

4.6.6. Академийн ажлын албаны тухай, түүний бүтэц, салбарууд, албан тушаалтны орон тоо, дагаж мөрдөх дүрэм, зааврыг баталж, байгууллагын ажилтан, албан хаагчдын цалин хангамжийн тогтолцоо, хэлбэр хэмжээг тодорхойлох.

4.6.7. Академийн ажлын албаны болон үйлдвэр аж ахуйн газрыг удирдах, академийн боловсон хүчнийг шилж сонгох, хуваарилах, авах, чөлөөлөх үйл ажиллагааг Монгол Улсын хөдөлмөрийн хуулийн дагуу явуулах, орон тооны албан хаагчидтай гэрээ, хэлэлцээ хийх ба ажлын түр хэсэг байгуулах.

4.6.8. Академийн санхүү, аж ахуй болон албан хэрэг зохион байгуулалтын ажлыг удирдлагаар хангаж, академийн үйл ажиллагааны асуудлыг бие даан шийдвэрлэнэ.

4.6.9. Академийн нэрийн өмнөөс тусгайлсан итгэмжлэхгүйгээр гадаад, дотоодын үйлдвэр, байгууллага, албан газар, хувь хүнтэй, академийн эрх ашгийн өмнөөс гэрээ хэлэлцээр хийх, академийн эд хөрөнгийг захиран зарцуулах, итгэмжлэл гаргаж өгөх, валютын ба тооцооны данс нээх эрх эдэлнэ.

4.6.10. Академийн ажлын албаны зардал, төсвийг батлах.

4.6.11. Монгол Улсын хууль тогтоомж энэхүү дүрмээр олгогдсон өөрийн бүрэн эрхийн хэмжээнд багтаан бусад үүрэг гүйцэтгэх.

Академийн ерөнхийлөгчийн эзгүй үед түүний шийдвэрээр томилогдсон аль нэгэн дэд ерөнхийлөгч, ерөнхийлөгчийн бүрэн эрхийг эдэлнэ.

Дэд ерөнхийлөгчийн эдлэх бүрэн эрхийн хүрээг академийн ерөнхийлөгч тодорхойлж, тогтооно.

4.7. Эрдэмтэн нарийн бичгийн дарга нь академийн өдөр тутмын ажлыг удирдаж, салбаруудын удирдлагаас академийн шийдвэрийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, академийн бичиг хэргийн хэрэгжилтийг зохион байгуулна.

4.8. Хянан шалгах комисс

нь академийн гишүүдийн нэгдсэн хуралдайгаас 5 жилийн хугацаатай сонгогдоно.

Тэргүүлэгч гишүүд хянан шалгах комиссын бүрэлдэхүүнд орохгүй.

Хянан шалгах комисс нь академийн санхүү, аж ахуйн үйл ажиллагааг шалгах явцад академийн гүйцэтгэх байгууллага, ажилтнуудаас холбогдох материал, санхүүгийн болон бусад бичиг баримтыг гаргаж өгөхийг шаардах эрхтэй байна.

Хянан шалгах комиссын үйл ажиллагааны үр дүнг академийн нэгдсэн хуралдайгаар авч хэлэлцэн батална.

ТАВ. ХИЛ СУДЛАЛЫН АКАДЕМИЙН ХЭРЭГСЭЛ, ЭД ХӨРӨНГӨ

5.1. Академи нь дүрэмд заасан үйл ажиллагааны материаллаг хангалтад шаардлагатай соёл гэгээрэл, эрүүл ахуйн зориулалттай өөрийн өмчийн барилга байгууламж, орон сууц, төхөөрөмж, эд хогшил, мөнгөн хөрөнгө, хувьцаа үнэт цаас зэрэг бусад эд хөрөнгөтэй байж болно.

Академийн өмчид түүнчлэн хэвлэлийн газар, үйлдвэр, түүний дотор туршилт, сорилтын үйлдвэрлэл, түүнчлэн академийн зорилго, зорилтыг хангахад нийцсэн энэрлийн байгууллага, өөрийн хэрэгцээг хангах туслах аж ахуй байж болно.

Мэдээлэл Судлалын Академийн бие даасан гишүүн байгууллага нь академийн эд хөрөнгө, тэр дотроос академиас хэрэгцээнд нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгө, түүнчлэн гишүүний элсэлтийн татварыг захиран зарцуулах эрх эдлэхгүй.

5.2. Академийн санхүү нь элсэлтийн татвар, байгууллага, үйлдвэр, албан газар, ивээн тэтгэгч, хандивлагч иргэдийн сайн дурын хандив, чуулга уулзалт, бага хурал, сугалаа, лекц, үзэсгэлэн, спорт болон бусад арга хэмжээ зохиосны орлого, үйлдвэр, аж ахуй, хэвлэл, эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагааны орлого, хамгаалуулах зөвлөл, шинжээчдийн товчооны ажлын орлогын зохих хэсэг зэрэг хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

5.3. Академийн салбар, хэсэг нь хуулийн этгээд болох Хил Судлалын Академийн зөвшөөрөлтэйгөөр зөвхөн дүрмээр тогтоосон зорилго, зорилтыг хангах зориулалтаар аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох ба оруулсан хөрөнгийг академийн гишүүн байгууллагын дундын өмчийн хэлбэрээр хуваарилах буюу дүрэмд зааснаас өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

ЗУРГАА. АКАДЕМИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ, НЭМЭЛТ ОРУУЛАХ, ТҮҮНИЙ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ӨӨРЧЛӨХ, ТАТАН БУУЛГАХ

6.1. Академийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг академийн гишүүдийн нэгдсэн хуралдайгаар шийдвэрлэнэ. Дүрмийн нэмэлт өөрчлөлт нь Монгол Улсын хууль, тогтоомжид нийцсэн байх ба эрх бүхий байгууллагад бүртгэгдсэний дараа хүчин төгөлдөр болно.

6.2. Академи нь нэгдэх, хамтрах, салах буюу үндсээрээ өөрчлөгдөх замаар зохион байгуулалтаа шинэчлэн өөрчилж болно. Энэ нь Монгол Улсын хууль, тогтоомжид нийцэж байвал зохино.

6.3. Академи нь нэгдсэн хуралдайн шийдвэр эсвэл Монгол Улсын хуульд заасан үндэслэлээр шүүхийн шийдвэрээр татан буугдана.

6.4. Академийг шинэчлэн өөрчлөх, татан буулгахыг академийн нэгдсэн хуралдайн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

6.5. Академийг татан буулгасан нөхцөлд академийн зохих зээл,

төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хогшил, мөнгөн хөрөнгийг энэхүү дүрэмд заасан зорилгод нийцсэн үйл ажиллагаанд зориулна.

ХИЛ СУДЛАЛ БОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ БИЕ ДААСАН САЛБАР МӨН



Д.Нямдорж

Монголын Хил Судлалын Академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор, Хууль Сахиулахын Их сургуулийн багш

Улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах явдал шинжлэх ухааны мэдлэгт суурилсан хамгаалалтад шилжиж хэрэгжих болов. Мэдлэгт суурилсан зохион байгуулалтын цоо шинэ менежмент шаардлагатай боллоо.

Энэ зорилтыг хэрэгжүүлж байж хил хамгаалалтад чанарын өөрчлөлт гаргах юм. Энэ бүхэн юуг хэлж байна вэ гэвэл эрдэмтдийнхээ санаа оноо, судалгаа шинжилгээг Хил хамгаалах байгууллага сонсож үйл ажиллагаагаа тэр бүхэн дээр түшиглээчээ гэсэн үг юм. Эрдэмтэд, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагууд ч бас Хил хамгаалах байгууллагынхаа өмнө хариуцлага хүлээж, түүнд үйлчлэх ёстой.

Тэгэхээр Хил хамгаалах байгууллага шинжлэх ухаанд суурилсан үндэсний хөтөлбөрийг боловсруулж, түүнийгээ дагаж мөрдөж хэрэгжүүлэх учиртай болж байна. Бүр ягштал баримтлах хэрэгтэй байна. Үүний үр дүнд тогтвортой хамгаалалт бий болно. Энэ бүхэн үндсэндээ хамгаалалтын эрүүл тогтолцоог авчирна. Ерөөсөө сэтгэлгээний эрх чөлөөг дээдлэх хэрэгтэй байна. Одоо бол ямар нэг юм хийдэг, хийснээрээ ямар нэг үнэлэмжийг бий болгочихоод, хүмүүсийн үнэлэмжинд хандах хандлагыг загварчлаад байгаа байдал зарим газар ажиглагдаж байна.

Энэ бол байгаа газартаа гаж тогтолцоог үүсгэдгээс гадна албанд төдийлөн ашигтай бус уур амьсгалыг бүрдүүлдэг. Хил хамгаалалтад шинжлэх ухаанчаар хандах хандлагыг төлөвшүүлэхэд шинжлэх ухааны боловсрол тусална. Тийм учраас бүх улс орнууд шинжлэх ухааны боловсрол гэдэг асуудлыг цоо шинээр нэвтрүүлэх боллоо. Шинжлэх ухаан-технологи-инноваци гэж шинжлэх ухааныг ойлгодог улс орнууд тэгж ханддаг болсон байна. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр шинжлэх ухааны болоод шинэ техник технологийн үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх шинэ сэдлийг инноваци гэж нэрлээд түүнийг чухалчлах болсон байна.

Орчин үеийн технологийн хувьсал нь даяаршлын хувьсалтай давхцаж энэхүү хоёр лут хүч нэгдэн нийлж XXI зууны мэдээллийн сүлжээний шинэ парадигма (язгуур шинж)-ыг бүтээж байна. Инновацийн үйл явцыг хөгжүүлэх шинэ технологийг түгээн дэлгэрүүлэх шинэ бүтэц бүрэлдэн тогтож байна. Дэлхий даяар газар сайгүй үүсэж буй ийм төвүүдэд эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, үйлдвэрийн газар, дундын хөрөнгө

технологийн хөгжлийн сүлжээнд нэгдэж хамтран ажиллах болж байна. Энэ өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх улс орон, байгууллага, хүн үндсэндээ алга.

Байдал нэгэнт ийм байгаа болохоор улс орон бүр үндэсний болон дэлхийн түвшинд төрийн бодлогоо өөрчилж өнөөгийн технологийн трансформацыг ашиглах боломж нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй болж байна. XXI зууны дэлхийн хөгжлийн парадигм ийм аж.

Шинжлэх ухааны мэдлэг, оюуны багтаамжтай өндөр технологи, дээд зэргийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд тулгуурласан дэлхийн шинжлэх ухаан техникийн дэвшлийн тэргүүлэгч орнууд, эдгээр оронд буй болсон тэрхүү нийгмийг үйлдвэржсэн, мэдээлэлжсэн гэх буюу мэдлэгийг үндэслэсэн хэмээн нэрлэх болжээ.

Тэдний санхүүгийн ба батлан хамгаалалтын чадавхи давамгайллын суурь нь математик, байгаль, нийгэм технологийн бүх салбарт буй болсон мэдлэгийн хуримтлал ажээ. Эндээс үзэхэд технологийн хүчин чадал, эдийн засгийн тогтвортой өсөлт, материалын болон оюун санааны баялгийн үндэс шинжлэх ухаан гэдэг нь тов тодорхой байна. Шинжлэх ухааны салбар нь мэдлэг үйлдвэрлэдэг бол боловсролын салбар нь эдгээр мэдлэгийг дэлгэрүүлэн хүн амын чанарыг дээшлүүлдэг ба түүний дотор ажиллах хүчний чанар, чадвар дээшилдэг аж.

Ийнхүү нийгмийн нэг баялаг (мэдлэг) нь нийгмийн өөр баялгийн (боловсролын түвшин) үйлдвэрлэлийн эх материал болж байна.

Улсын хил хамгаалалт нь Үндэсний Аюулгүй байдлын салшгүй хэсэг бөгөөд түүнийг хангах олон талт үйл ажиллагаанаас өөрийн бие даасан онцлог үйл ажиллагаагаараа ялгагддаг. Тэр нь улсын хилийн шугамын явалтыг өөрчлөх гэсэн аливаа оролдлогыг таслан зогсоох, улсын хил, хязгаар нутагт иргэд, түүний өмч хөрөнгөнд элдэв аргаар халдсан халдлагыг няцаах, зорчигч, тээврийн хэрэгсэл, эд зүйлийг хилийн боомт гарцгүй газраар эсвэл боомт гарцаар хууль бус аргаар нэвтрүүлэх оролдлого гаргуулахгүй байх, гаргахаас урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа бараа, бусад зүйлийг шалган нэвтрүүлэх зэрэг ажиллагаагаар илэрч байдаг. Зэвсэгт хүчний тайван цагийн гол үүрэг нь байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг хангах, түүнд бие бүрэлдэхүүнийг бэлтгэхэд чиглэж байдаг бол Хил Хамгаалах Байгууллагын үндсэн үүрэг нь хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ хэлэлцээр, Монгол Улсын Хилийн тухай хууль, тогтоомжийг сахиулахад чиглэсэн байдаг. Үүгээрээ Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн сургалт, бэлэн байдлын обьект болж байхад Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүн хил хамгаалах үйл ажиллагааны субъект болж байдгаараа эрс ялгаатай юм.

Энэ бүхнээс үзэхэд тэмцэл явуулах объектоос шалтгаалаад тухайн субъектийн үйл ажиллагааны зорилго, зорилт, арга, хэлбэр, хүч хэрэгсэл, бүтэц зохион байгуулалт харилцан адилгүй байх бодит зүй тогтол байгаа нь харагдаж байна.

Үүнээс үүдээд улсын хил хамгаалах байгууллага нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд өөрийн гэсэн байртай, үүрэг рольтой өвөрмөц субъект болох нь харагдаж байна. Үндэсний аюулгүй байдлыг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлохдоо: "Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ" гэсэн байдаг.

Иймд "Үндэсний аюулгүй байдлыг

хангах" гэж Монгол Улсын Үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлж тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлого, төр түүний байгууллага, албан тушаалтнаас авч буй, иргэдээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлдэг байна.


Улсын хил хамгаалалтын мөн чанар нь хязгаар нутагт дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлдэгт оршино. Өөрөөр хэлбэл: Улсын хил, хязгаар нутагт аюулгүй байдлыг хангах улс, нийгэм, иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах ажиллагааг хил хамгаалалт гэж нэрлэдэг. Ийнхүү үндэсний аюулгүй байдлыг хангахад хил хамгаалах үйл ажиллагаа чухал рольтой байдаг. Энэ нь хил судлалын шинжлэх ухааны зорилго, обьект, судлах зүйл зэргээс тодорхой харагдаж байна.

Дэлхий нийтээр шинжлэх ухаан, технологийн дэвшил дээр суурилан хөгжих нь нийгмийн хөгжлийн зүй тогтол гэдгийг бодит амьдрал дээр баталж өгсөн XX зууны шувтарга 1990-ээд оны дунд үеэс хил судлал (погранология) шинжлэх ухааны бие даасан салбар болж хөгжсөн билээ.

Тусгаар тогтносон улсын хил болон хязгаар нутагт болж байгаа үйл явцын мөн чанар, шинж байдал, хилийн орон зайд хамаарагдах бие хүн, улс төрийн ашиг сонирхлыг хамгаалж буй төр, олон нийт, хүчний болон бусад байгууллагын үйл ажиллагааг харьцуулан судалдаг шинжлэх ухааныг томъёолж "Хил судлал" гэж нэрлэх болсон ба түүнийг шинжлэх ухааных нь хувьд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, 1995 оны 12 дугаар сарын 06-нд Оюуны бүтээлийн Олон улсын бүртгэлийн танхимд (Международная палата интеллектуальной новизны)-д EIW 0001175 дугаартайгаар бүртгэсэн юм.

Хил судлал, погранология буюу frontiology гэдэг нь пограничный-хилийн гэсэн орос, frontier –хил гэсэн англи, logos- мэдлэг гэсэн грек үгнээс гаралтай, хилийн асуудлын хүрээнд (пограничная сфера) явагдах үзэгдэл, үйл явц, хууль, зүй тогтлуудыг судалдаг шинжлэх ухаан юм.

Аливаа шинжлэх ухаан зорилго, чиглэл, объект, судлах зүйл, хууль зүй тогтлынхоо онцлогийг илэрхийлж чадах ойлголтын аппараттай байдаг. Үүгээрээ бусад шинжлэх ухаанаас ялгагдаж байх ёстой. Хил судлалын шинжлэх ухаанд өөрийн өвөрмөц онцлогийг илэрхийлсэн улсын хил, хязгаар нутаг, хилийн харилцаа, хилийн хүрээний үйл ажиллагаа, хилийн аюулгүй байдал гэсэн ойлголтууд байдаг бөгөөд тэдгээр нь хил судлалын шинжлэх ухааны бүтцэд тусгалаа олжээ.



Улсын хил: Улсын хилийг янз бүрээр тодорхойлсон нь бий. Ихэвчлэн улс орны газар нутгийн зах хязгаарыг заагласан шугам гэсэн агуулгаар авч үзсэн байдаг. Энэ нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд шаардлагатай чухал ойлголт гэдгийг хэн ч үгүйсгэх аргагүй юм.

Гэвч бие даасан улс байж үндэснийхээ эрх ашиг, тусгаар тогтнолыг нийгмийн амьдралын бүхий л салбарт хамгаалахад дээрх ойлголт тэр бүр хангалттай биш байдаг. Улс

үндэстний язгуур ашиг сонирхол нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, шинжлэх ухаан, техник, цэрэг, байгаль орчны зэрэг бүх салбарт хамгаалагдаж байж тухайн улсын тусгаар тогтнол баталгаатай хангагдана. Тийм учраас улсын хил гэдэг тодорхойлолт улс төрийн утгаар шинжлэх ухааны үүднээс авч үзвэл маш өргөн ойлголт байна.

Оросын холбооны улсын хил судлалын эрдэмтэд улсын хилийг тодорхойлохдоо: Нийгмийн систем өөрийнхөө амьдрал үйл ажиллагааг тодорхой хязгаарт хангаж оршин тогтнох арга гэж үзжээ. Энэ нь хил судлалын шинжлэх ухааны цар хүрээг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Хязгаар нутаг: Энэ нь хилийн харилцаа үүсэн бий болох хилийн шугамын дагуух хил залгаа орны болон өөрийн улсын нутаг дэвсгэрийг хамарсан нийгэм газар зүйн ойлголт юм. Хилийн орон зайг тодорхойлох нь хил хамгаалах үйл ажиллагааны хамрах хүрээг тогтоох үндэс болох бөгөөд хилийн харилцаа гэдэг ойлголтыг бий болгодог. Иймд хилийн харилцаа гэдэг ойлголтыг тайлбарлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хилийн харилцаа: Энэ нь хилийн асуудлаар харилцах улс гүрэн, төр, олон нийтийн байгууллага, хүмүүсийн харилцаа юм. Хилийн харилцааг тодорхойлсноор хил хамгаалалтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа субъектүүд, тэдний харилцааг судлах боломжийг олгож байна.


Хилийн хүрээний үйл ажиллагаа: Улсын хил, хязгаар нутгийн хөгжил, аюулгүй байдлын асуудлаар төр, засаг байгууллага, иргэдээс явуулж байгаа үйл ажиллагааг хилийн хүрээний үйл ажиллагаа гэнэ. Энэ нь хил хамгаалалтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа субъектуудын гүйцэтгэх үүрэг чиг хандлагыг тодорхойлоход чухал ач холбогдолтой ойлголт юм. Үүнтэй холбогдуулан хилийн аюулгүй байдал гэсэн ойлголт гарч ирнэ.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь улсын хил, хязгаар нутагт улс, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол хангагдсан байх нөхцөл юм. Тэр нь улсын хилийн баталгаажилт ба улсын хил хамгаалалтаар хангагддаг.

Хил судлал шинжлэх ухаан болохын хувьд тодорхой зорилготой байна. Хил судлалын шинжлэх ухааны зорилго нь хилийн холбогдолтой үзэгдэл үйл явцыг танин мэдэх, тодорхойлох, тайлбарлах, хэтийн төлөв чиг хандлагыг тогтооход оршино. Үүнээс үзвэл хил судлалын шинжлэх ухаан нь төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндэс болох нь тодорхой юм.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого гэж улс, нийгэм, хувь хүний язгуур ашиг сонирхлыг хилийн орон зайд хангахад чиглэсэн төрийн гадаад дотоод улс төрийн бодлогыг хэлнэ. Уг бодлогыг хэрэгжүүлэгч гол субъектууд нь улс орны гадаад харилцаа, хууль хяналт, хил хамгаалалт, тагнуул, гааль, эдийн засаг, эрүүл ахуй, байгаль орчин, батлан хамгаалах гэх мэт асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд байдаг.


Энэ бүгдээс үзэхэд хил судлалын шинжлэх ухааны нийгэмд эзлэх байр суурь ач холбогдол ямар өндөр, түүний хамрах хүрээ хичнээн өргөн болох нь тодорхой байна. Хил судлалын шинжлэх ухааны объект нь улсын хил хилийн аюулгүй байдлын асуудал байдаг бөгөөд түүний судлах зүйлд хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хууль, зүй тогтол, арга хэлбэр, зарчмууд, түүний тулгамдсан асуудал, хөгжлийн чиг хандлага зэрэг асуудал хамрагддаг.



ХИЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ НИЙГЭМД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

Зорилго, объект, судлах зүйл зэргээс үзэхэд хил судлалын шинжлэх ухаан нь шинжлэх ухааны бүхий л салбарыг хамарсан маш өргөн хүрээтэй цогцолбор шинжлэх ухаан юм.

Хил судлалын шинжлэх ухаан арга зүйн хувьд философи, математик, системчлэл /системийн онол/ зэрэг шинжлэх ухааны ерөнхий онол, хил хамгаалалтын, гаалийн гэх мэт тусгай онол, чиглэлийн хувьд улс төр, цэрэг, эдийн засаг, аюулгүй байдлын ерөнхий онол, улс төр судлал, түүхийн, хууль зүй, техникийн ухаан, сэтгэл судлал, сурган хүмүүжүүлэх ухаан зэрэг хилийн асуудалд дам холбогддог шинжлэх ухаан дээр тулгуурласан байдаг.



ХИЛ СУДЛАЛЫН ШИНЖЛЭХ УХААН ЦОГЦОЛБОР ШИНЖЛЭХ УХААН МӨН

Ийнхүү хил хамгаалалтын онол нь хил судлалын ухаанд тусгайлан хэрэглэгддэг онолын нэг юм.

Улсын хил хамгаалалтын онол бол цэргийн шинжлэх ухаан ба онольн бусад салбаруудтай диалектик холбоотой оршдог, шинжлэх ухааны мэдлэгийн тусгай салбар, улсын хил хамгаалалтын мөн чанар, зүй тогтол, үр ашгийг дээшлүүлэх арга зам, алба-байлдааны ажиллагааны арга хэлбэр, хилийн цэргийн байгуулалтын онцлог зэргийг судалдаг үзэл бодлын систем юм.

Үүнээс үзэхэд улсын хил хамгаалалтын онол нь хил судлалын ухааны гол

цөмийг бүрдүүлж байна гэж үзэх үндэстэй бөгөөд түүний ач холбогдол хил судлалын шипжлэх ухааны зорилгоор тодорхой харагдаж байна. Хил судлалын шинжлэх ухаан олон шинжлэх ухааны цогц болдгийн мөн чанар нь тэдгээр шинжлэх ухааныг улсын хил, түүний хамгаалалт гэсэн нэг цэг дээр төвлөрүүлж тэдний уялдаа холбоог хангаж байдагт оршино. Ийм цогц шинжлэх ухааны тусгай онол нь болдгийн хувьд хил хамгаалалтын онол хил судлалын шинжлэх ухааны цөм болж байдаг.

Хил судлалын шинжлэх ухаан нь, эрдэмтэн судлаачид, Хилийн сургуулийн багш, сонсогчид, цэргийн албан хаагчид судалгааны хэрэглүүр болгон, онолын бүтээл туурвих, төр, засаг, яам, командлалаас гарах бодлогын шинжтэй бичиг баримт боловсруулахад ашиглах боломжтойгоороо онолын, дүгнэлт зөвлөмжүүдийг амьдрал, улсын хил хамгаалалтын үйл ажиллагаанд шууд нэвтрүүлж хэрэгжүүлэхэд ач тустайгаараа практикийн ач холбогдолтой юм. Үүний тодорхой жишээ бол улс, нийгэм, хувь хүний ашиг сонирхлыг хил хязгаар нутагт хангахад чиглэгдсэн төрийн гадаад, дотоод улс төрийн бодлого, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг Мэдээлэл Судлалын Монголын Академи, Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг, Хилийн Цэргийн Дээд Сургуулийн эрдэмтэн судлаачид Хил Хамгаалах Ерөнхий Газартай хамтран боловсруулж Монгол

Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 16-ны 20 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж эхэлсэн явдал юм.

Улсын хил хамгаалалтын эрх зүйн орчин боловсронгуй болсноор улсын хилийн баталгаажилт хангагдан, хил орчмын тодорхой бүс нутагт гадаад, дотоодын хөрөнгө оруулалт хийгдэх нөхцөл бүрдэж тухайн бүс нутгийн хөгжил дээшлэх ба улсын хил түүнтэй холбоотой асуудал шийдвэрлэгдэх боломж сайжирч, зэргэлдээ улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцаа хамтын ажиллагаа бэхжин, харилцан мэдээлэл солилцох тогтолцоо буй болж, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллагуудын үүрэг үйл ажиллагаа уялдаатай болж, хилчдийн мэргэжил, чадвар сайжирч, албан үүргээ гүйцэтгэх идэвхи хариуцлага дээшлэх ба энэ нь хөтөлбөрийн хэрэгжилтээс гарах үр дүн юм. Одоо улс үндэстнийхээ түүх, соёл, ёс заншлыг нэвтэрхий мэдэж дээдэлсэн, эх оронч сэтгэлтэй, удирдахуйн ухааны орчин үеийн мэдлэгийг, тухайлбал менежмент, системийн онол, синергетик, кибернетик зэргийг эзэмшсэн, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтыг хүлээн авч хэрэглэх, тэдгээрийн өөрчлөлтийг мэдэрч дасан зохицох, хөгжих, дэлхийн өрсөлдөөнт зах зээлд гарч байр суурыа бэхжүүлэх чадвартай меритократ, латерал сэтгэлгээтэй удирдах ажилтнуудыг бэлтгэх асуудал чухлаар тавигдаж байна.

Улс орны аюулгүй байдлын салбарт Хилийн цэргийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг шинжлэх ухааны төвшинд авч үзэхэд Хилийн сургууль чухал үүрэг, хариуцлага хүлээдэг. Улсын хилийг хамгаалах, хилийн болон хил орчмын аюулгүй байдлыг хангах үндсэн хүч бол Хил хамгаалах байгууллагын мэргэшсэн боловсон хүчин мөн бөгөөд аливаа үйл хэргийн эцсийн чанар, үр дүн боловсролоор дамжиж хэрэгждэг учраас Хилийн сургууль үүнд шийдвэрлэх байр эзэлж, чухал үүрэг гүйцэтгэдэг юм. Иймээс Хилийн сургууль нь Монгол Улсын Хил хамгаалах болон төрийн бусад байгууллагад ажиллах хилийн алба, ар тал, инженер,сэтгэл зүй, ёс суртахуун, соёл хүмүүжлийн чиглэлээр бакалавр, магистрын зэрэгтэй офицер, боловсон хүчин, тусгай мэргэжлийн ахлагч нарыг өдөр, эчнээгээр бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, шинжлэх ухааны суурь болон хавсрага судалгаа явуулах чиг үүрэг бүхий сургалт эрдэм шинжилгээ, мэдээллийн бие даасан байгууллага болон бэхжиж байна. Иймээс улсын хилийн ба түүний хамгаалалтын асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, хил хязгаар нутагт өрнөж буй үйл явдлыг судлах, хилийн талаарх төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхэд оролцох, улсын хил, хязгаар нутагтай холбоотой төслүүдийг эрдэмтэд, төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийн хүчээр боловсруулж хэрэгжүүлэх, хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах шаардлага зүй ёсоор урган гарсан билээ.

Монгол улсад хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүнийг олон улсын төвшинд гаргах, ингэснээр эх орныхоо хил, хязгаар нутагт аж төрж, хөдөлмөрлөж буй хүмүүсийн үйл ажиллагаа, үзэгдлийн мөн чанарыг судалж, харилцан мэдээлэх, мэдээллийн шинэ орчныг бий болгох шаардлагад тулгуурлан Хилийн сургуулийн хэсэг багш нар санаачлан 2000 онд Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг (МХСҮН)-ийг байгуулсан билээ. Энэ нийгэмлэг нь Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академитай холбоо тогтоохоос ажлаа эхэлж юуны түрүүнд уг академийн Холбооны Хилийн Албаны Академийн хил судлал (погранология)-ын хүрээлэнтэй харилцаа тогтоож,

хамтран ажиллах болсон юм.

Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэг ийнхүү гадаад үйл ажиллагаагаа улам эрчимжүүлж 2001 оны 10 дугаар сарын 12-ны өдөр тус сургуулийн багш, нийгэмлэгийн тэргүүн академич, доктор, профессор Г.Дагважамц Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академийн ерөнхийлөгч, академич Александр Григорьевич Харитонтой Москва хотноо уулзаж Монголын Хил Судлальн Үндэсний Нийгэмлэгийг түшиглэн Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академийн салбар байгуулж болохыг дэмжсэн Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байсан, одоо Монгол Улсьн УИХ-ын дарга М.Энхболдын албан бичгийг түүнд гардуулж хамтын ажиллагааны тунхаглалд гарын үсэг зурснаар Мэдээлэл Судлалын Монголын Академи байгуулагдах эрх зүйн үндэс тавигдсан юм.

Бид гадаад харилцаагаа өргөжүүлэх мэдээллийн болон хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх чиглэлээр ОХУ-ын Хабаровскийн Хилийн цэргийн дээд сургууль, ОХУ-ын Холбооны хилийн албаны академи, Унгар, АНУ-ын дээд сургуулиудтай холбоо тогтоож, эдгээр сургуулиудын туршлагыг нэвтрүүлэн, 60 гаруй ном, товхимлыг авчирч орчуулан нийтийн хүртээл болгосон нь зохих ач тусаа өгсөн юм.

Сургуулийг эрдэмжүүлэн, эрдмийн уурхай болгох хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд манай шинэ тутам байгуулагдаад байгаа Монголын Хил Судлалын Академи чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй.

Хил судлалын шинжлэх ухааны бүрэлдэхүүн хэсгүүд тодорхойлогдож системчлэгдэн, бүрэн ойлгомжтой мэдлэг хуримтлагдаж шинжлэх ухааны бие даасан салбар болсон тул, Монголын Хил Судлалын Академийн эрдэмтдийн уйгагүй хөөцөлдлөгөө, идэвхтэй хүчин чармайлтын үр дүн болж, <<Хил судлал>>-аар магистр, докторын зэрэг хамгаалах, Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайдын "Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэх тогтоох тухай" 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 235 тоот тушаал гарсан (тушаалыг хавсаргав) билээ.

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2010 оны 05 сарын 20 өдөр Дугаар 235 Улаанбаатар хот

Мэргэжлийн чиглэл, индекс
шинэчлэн тогтоох тухай

Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагад бэлтгэх ерөнхий мэргэжлийн чиглэл, индексийг нэгдүгээр, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэх мэргэжлийн жагсаалт, мэргэшлийн түвшин, зэргийг хоёрдугаар, Сургалтын байгууллагын мэдэлд үлдээх мэргэжлийн чиглэл, индексийг гуравдугаар, Эрүүл мэндийн шинжлэх ухааны чиглэлээр төрөлжүүлэн эзэмшүүлэх мэргэжлийн чиглэл, индексийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Шинэчилсэн мэргэжлийн чиглэл, индексийг 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/, холбогдох сургуулийн захирал нарт үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэгдсэнтэй холбогдуулан оюутны суралцаж буй мэргэжлийн чиглэл, индекс өөрчлөгдсөн тохиолдолд оюутныг тухайн мэргэжлээр төгсөх хүртэл нь үргэлжлүүлэн суралцуулахыг холбогдох сургуулийн захирал нарт зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан "Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн тогтоох тухай" 2005 оны 181 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжавт үүрэг даалгасугай.

САЙД Ё.ОТГОНБАЯР

Бакалаврын дээд боловсролын мэргэжлийн индекс	Магистрын түвшний боловсролын мэргэжлийн индекс	Докторын боловсролын мэргэжлийн индекс	Салбар	Мэргэжил	Төрөлжсөн мэргэжил	Мэргэжлийн чиглэл
		F	86	00	00	**3.4.Аюулгүй байдлын алба**
D	E		89	01	00	Цагдаагийн ажил-эрх зүй
D	E		86	02	00	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын ажил-эрх зүй
D	E		86	03	00	Онцгой байдлын байгууллагын ажил-эрх зүй
D	E	F	86	04	00	Аюулгүй байдал
D	E	F	86	05	00	Цэрэг, батлан хамгаалах алба
D	E		86	06	00	Ерөнхий цэргийн команд
D	E		86	07	00	Артиллерийн команд
D	E		86	08	00	Зенитийн артиллерийн команд
D			86	09	00	Салаа, ротын түвшингийн алба, бэлтгэл, мэргэжил дээшлүүлэлт
D	E		86	10	00	Радио техникийн команд
D	E		86	11	00	Иргэний хамгаалалтын команд
D	E		86	12	00	Ар талын алба
D	E		86	13	00	Хуягт танкийн алба
D	E		86	14	00	Химийн алба
D	E		86	15	00	Авто, гинжит машины алба
D	E		86	16	00	Холбооны алба
D	E		86	17	00	Зэвсгийн алба
D	E		86	18	00	Цэргийн инженерийн алба
D			86	19	00	Хилийн алба
D			86	20	00	Шалган нэвтрүүлэх алба
D			86	21	00	Хөгжмийн алба
D	E		86	22	00	Батальон /дивизон/-ы түвшингийн алба, бэлтгэл, мэргэжил дээшлүүлэлт
	E	F	86	23	00	Стратеги тактик, команд-штаб
	E		86	24	00	Хороо /бригад/-ны түвшингийн алба, бэлтгэл, мэргэжил дээшлүүлэлт
	E		86	25	00	Стратеги /дээд/ дамжаа
	E	F	86	25	00	Хил судлал
D			86	26	00	Криминалистикийн шинжилгээ-эрх зүй
D			86	27	00	Дотоодын цэргийн ажил-эрх зүй
D	E		86	28	00	Радио электрон тэмцэл
	E	F	86	29	00	Цэргийн зэвсэглэл, техник
	E	F	86	30	00	Цэргийн түүх
D	E		86	31	00	Цэргийн байр зүй

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ХИЛ СУДЛАЛЫН УХААНЫ ҮҮРЭГ, БАЙР СУУРЬ



Ц.Ганболд

Монголын Хил Судлалын Академийн тэргүүлэгч гишүүн, доктор, профессор, Монгол улсаас ОХУ-ын Улаан-Үүд хотноо суугаа Ерөнхий консулын газрын дэд консул

Нэгдмэл, суурь шинжлэх ухааны хүрээнд системчилсэн тайлбар хийх онцгой шаардлагатай байсан хил хамгаалалтын талаарх мэдлэгийг, харьцангуй саяхныг болтол цэргийн, тагнуулын, нийгмийн болон бусад шинжлэх ухаанд тараангуй байдлаар салбарлуулан авч үздэг байсан юм. Энэ нь бие хүн, нийгэм, улс орны эрх ашгийг хилийн орон зайд хамгаалах тухай бие даасан шинжлэх ухаан бүрэлдэн төлөвшихөд саад учруулж, түүний үүрэг роль, тэр тусмаа хилийн үйл ажиллагааны онол, практикийг шинжлэх ухааных нь хувьд ихээхэн бүдэгрүүлж байлаа. Хориод жилийн тэртээ, ЗХУ-ын Улсын аюулаас хамгаалах хорооны Хилийн командын дээд курсын профессор Виктор Александрович Сальников хилийн тухай тусгай шинжлэх ухааныг бүрэлдүүлэн төлөвшүүлж түүнийг хил судлал хэмээн нэрийдэх санааг дэвшүүлсэн юм. Харин 1993 оноос хилийн орон зайд бие хүн, нийгэм, улс орны эрх ашгийг хангах, хамгаалах үүрэг бүхий нийгэм улс төрийн үзэгдлийн шинж, хууль, зүй тогтлыг судалдаг, шинэ шинжлэх ухаан болох “хил судлал” хэмээх шинжлэх ухаан, практик хэрэглээнд нэвтэрч эхэлсэн юм. Энэ үед хил судлал шинжлэх ухаан болохынхоо хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн гэж хэлж болно. Түүхийн урт хугацааны туршид хил судлал, цэргийн болон чекистийн шинжлэх ухааны олон тооны онолуудаас аажмаар салж бүрэлдэн хөгжсөн билээ. 80-90-ээд онуудад хил хамгаалалтын талаарх орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг зохион байгуулалтад орж, нэг талаас онолд дүн шинжилгээ хийж өөрчлөх, нөгөө талаас түүний хэтийн агуулгыг үндэслэн хөгжүүлэх хүчтэй түлхэц болсон шинжлэх ухааны хувьд өөрийгөө танин мэдэх, хурдацтайгаар бүрэлдэн тогтох үе шат явагдсан юм.

Өнөө үед онолын олон салаа тогтолцоог багтаасан шинжлэх ухааны мэдлэгийн бие даасан салбар болохынхоо хувьд хил судлалыг институцчилэх процесс явагдаж байна. Дэлхий дахинаа соёл иргэншлийн үйл явц эргэлтэд орж, “хүйтэн дайнд” ялагдал хүлээсэн ЗХУ задран бутарсан өнөө үед энэ нь бүр ч чухал юм. Олон улсын гэрээ хэлэлцээрээр хүлээн зөвшөөрөгдсөн баталгаат хил бүхий улс орнуудын нутаг дэвсгэрийн эрх зүйн баталгаа алдагдаж байна. Өмнө нь дэлхийн хоёр тогтолцооны хоорондын харилцааг тодорхойлогч түгээмэл аюулгүй байдлын асуудалд төвлөрч байсан цэрэг, улс төрийн ухаанууд, түгээмэл болон бүс нутгийн аюулгүй

байдал хоорондоо хэрхэн нийцэж холбогдох, геополитикийн нэгдмэл нэг орон зай үүсгэж буй хүчтэй болон, жижиг улс орнуудын нийгэм соёлын болоод бусад хамтын ажиллагаа ямар хамааралтай байх ёстой зэрэг асуултад хариулт өгч чадахгүй байна.

Улс төрийн байдал өөрчлөгдөж, шинээр боловсруулагдан бий болсон дэлхийн соёл иргэншлийн туулан өнгөрч буй энэ хямралын үед бусад орон болон олон улсын байгууллагуудтай харилцах харилцаа улам эмзэг байдалтай болж байна. Ийм нөхцөлд аюулгүй байдлыг хангах найдвартай хэрэгслүүдийн нэг нь хил судлалын онол арга зүйд үндэслэсэн улсын хилийн бодлого юм. Шинжлэх ухааны үндэстэй хилийн бодлого нь нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, оюуны болон биет соёл, эдийн засаг, нийгмийн бүтцийг хамгаалах Оросын өөрийн хүсэл эрмэлзлийг хэрэгжүүлэх болон, даяаршлаас үүдэлтэй хилийн харилцааг өөрчлөхөд тодорхой хариу үйлдэл үзүүлэх боломжийг олгож байгаа юм.

Орчин үеийн нийгэм-эдийн засаг, нийгэм-улс төрийн үсрэнгүй үйл явцууд уламжлалт арга хэрэгслээр, урьд нь хуримтлуулсан туршлагадаа суурилан улс орон, нийгэм, бие хүний эрх ашгийг үр ашигтай хамгаалах боломжийг хязгаарлаж байна. Шинээр бүрэлдэн бий болсон асуудлуудад хариулт эрж хайх нь цэвэр эмпирик салбарт үр ашиг багатай. Үүнийг улсын хил хамгаалалтын тогтолцоог өөрчлөн зохион байгуулах гэсэн арван таван жилийн туршлага нотлон харуулж байна. Үзэгдэл юмсыг харилцан хамааралтайгаар, нийгэм улс орны эрх ашгийн үүднээс онолын хувьд ухамсарлах хэрэгцээ шаардлага бий болж байгаа юм. Энэ хэрэгцээ хилийн үйл ажиллагааны талаарх цогц шинжлэх ухаан болох хил судлалыг хөгжүүлэхүйгээр хангагдаж чадахгүй.

XX зууны дунд үе хүртэл хил судлал нь төрөл бүрийн хууль,тогтоол, дүрэм гэх мэтийн хэм хэмжээний актуудад биеллээ олдог эмпирик ухаан байлаа.

Анх 1931-34 онуудад А.Х.Артузов улсын хилийн бодлого болон улс төрийн хамгаалалт, ЗХУ-д Хилийн цэрэг байгуулах тухай ерөнхий онолын үндсийг тавьсан нь, Г.Ф.Донченко, Ф.Ф.Помитяев, Д.И.Горшков, Н.А.Веревкин-Рохальскийн нарын болон ЗХУ-ын ДХЯ-ны УАХХ-ны цэргийн хүрээлэнгийн бусад эрдэмтдийн бүтээлд хожим тусгалаа олсон юм.

Хил хамгаалалтын онолын салбарт тулхтай, системчилсэн судалгаанууд Эх орны дайны дараа Хилийн цэргийн хүрээлэнд, дараа нь Хилийн командын дээд курсд хийгдсэн юм. Учир нь энд албаны арвин туршлагатай, өргөн мэдлэгтэй, бүтээх туурвих чин хүсэлтэй мэргэжилтнүүд төвлөрсөн байсан бөгөөд эндээс манай эрдэмтэд төрөн гарсан юм. Эдгээр судалгааны үр дүн эмпирик мэдлэгийг тусган, практик туршлагыг нэгтгэсэн их дээд сургуулийн сурах бичиг, гарын авлага гэсэн хоёр хэлбэрээр хэвлэгдэн гарахын зэрэгцээ, онолын шинэ мэдлэг, судалгааны эрэл хайгуулын үр дүнг тусгасан диссертац, нэг сэдэвт бүтээл байдлаар гарсан юм.

Сүүлийн үед орчин үеийн нийгэм-улс төрийн практикт хилийн салбар нь олон тооны шинэ, уламжлалт бус үзэгдлүүдтэй тулгарах болсон нь шинжлэх ухааны үүднээс тайлбарлах боломжгүй байдлыг үүсгэж байна. Энэ нь сүүлийн 20 жилд ажиглагдаж буй хилийн талаарх шинжлэх ухааны үсрэнгүй хөгжил нь бүрэн зүй тогтолтой, зөв зүйтэй гэдгийг баталж байгаа юм. Энэхүү процессын үр дүн болж улсын хилийг онолын хувьд судлах үүрэгтэй улс төрийн газар зүйн салбар ухаан болох лимологи 90-ээд онд төлөвшин хөгжсөн явдал юм. Хил

судлалын ухаанаас арай хожуу бүрэлдэн тогтсон шинжлэх ухааны энэ чиглэл нь хүлээн зөвшөөрөгдөж, хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагуудаар дэмжигдэн боловсролын процесст ороод байна.

Өнөө үед улс хоорондын харилцаанд хилийн асуудлыг олон улсын эрх зүй, түүх, дипломатын түүх, геополитик, социологи, гүн ухаан гэх мэт олон салбар ухаанууд судлах болсон нь тохиолдлын зүйл биш ээ. Учир нь хил зөвхөн төрийн мэдэж хариуцдаг зүйл биш олон нийтийн гадаад ертөнцтэй харилцах өргөн хүрээний харилцаа холбоог тээгч нь болж хувирсанд оршиж байгаа юм. Олон орон, ард түмэн, бүс нутаг, тивийн улс төр, эдийн засаг, мэдээлэл-соёлын амьдралд улам хүчтэй болсоор байгаа интеграцчилах, үл интеграцчилах явц хүчээ авахад энэ баримт онцгой чухал юм. Өнөөдөр энэ бүхнийг саяхан бидний туулж өнгөрсөн үетэй харьцуулахад илүү тодорхой харагдаж байгаа юм. Энэ бүхнийг хамтад нь авч үзэх нь хилийн салбарт идэвхтэй судалгаа явуулж, ойлголт ухагдахуун, зарчим, хандлага зэрэг зохих үндэслэлүүдийг бүрдүүлэн төлөвшүүлэх, хилийн салбарт гарч буй үйл явцын хөгжлийг тоймлох, зүй тогтлыг нь илрүүлэхийг шаардаж байна. 1995 онд Мэдээлэлжүүлэлтийн олон улсын академи байгуулагдсан нь хил судлалын хөгжилд чухал түлхэц болсон билээ. Хил судлалын салбар нь хилийн орон зайд улс орны эрх ашгийг хамгаалах чин хүсэлтэй нийгэм, төрийн зүтгэлтэн, эрдэмтэн, мэргэжилтнүүдийн нэгдэл юм. Үйл ажиллагааныхаа явцад тус салбар мэдлэгийн янз бүрийн салбарын 50 гаруй нэрт эрдэмтэн, мэргэжилтнүүдийг өөрийн эгнээндээ нэгтгэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдлөө. Монголд хил судлалыг хөгжүүлж байгаа нь үүний нэг тод жишээ юм.

Салбарын жил бүрийн эмхтгэлд хил судлалын чиглэлээр 160 гаруй зохиогчийн 203 өгүүлэл хэвлэгдэж, хилийн аюулгүй байдлын асуудлаар 3 цогц эрдэм шинжилгээний ажил хийгдэж, Оюуны бүтээлийн олон улсын бүртгэлийн газраас 3 лиценз авч, салбарын гишүүд 50 гаруй ажлыг хэвлүүлж, өөр өөр зориулалт бүхий хөтөлбөрүүдийг боловсруулаад байна. Салбарын гишүүдийн оролцоотойгоор ОХУ-ын Хилийн бодлогын үндэс, Хилийн бодлогын бүс нутгийн стратеги, Хилийн нэвтэрхий толийн олон тооны өгүүллүүд, Хилийн академид зориулсан хэд хэдэн сурах бичиг, гарын авлага боловсруулагдан гарлаа. Салбарын зүгээс жил бүр Академийн сонсогч-гишүүдийн дунд зохион байгуулан явуулж, диплом шагнал гардуулдаг шилдэг эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаан нь суралцагсдын бүтээлч боломжийг хөгжүүлж, авьяастныг олж тодруулан, онолыг баяжуулахад ихээхэн нөлөө үзүүлдэг билээ.

Ач холбогдол нь өнөөг хүртэл өсөн нэмэгдсээр байгаа 1996 оны "ОХУ-ын хилийн бодлогын үндэс"-т хил судлалын тэргүүлэх чиглэлүүдийг оруулж, энэхүү асуудлыг судалдаг эрдэмтэд 9 цуврал бүтээлдээ хил судлалын үндсийг тодорхойлсон юм.Үүнд:

- Хил судлалын техник эдийн засгийн болон боловсон хүчний асуудал- 1999 он
- Хил судлал: Хилийн бодлогын асуудлууд- 2000 он
- Хил судлал: Эрх зүйн асуудлууд- 2000 он
- Хил судлал: Арга зүйн асуудлууд- 2001 он
- Хил судлал: Мэдээллийн үндэс- 2002 он
- Хил судлал: Түүхийн үндсүүд- 2002 он
- Хил судлал: Тэнгисийн хилийн орон зайн хамгаалалт- 2004 он
- Хил судлал: Эрдэм шинжилгээ судалгааны арга зүй- 2006 он

- Хил судлал: Хилийн орон зайн экологи- 2010 он.

Үүнээс гадна хил судлалаар хэд хэдэн цуврал эрдэм шинжилгээ-судалгааны ажил хийгдсэн. Тухайлбал: "ОХУ-ын хилийн бодлогын арга зүйн үндэс", "ОХУ-ын хилийн бодлогын бүс нутгийн стратегийн үндэс", "Хилийн орон зайд ОХУ-ын аюулгүй байдалд учрах аюул занал", "Улс орны хилийн бодлогын асуудал ба түүнийг шийдвэрлэх арга зам", "Тэнгисийн хилийн хяналт", "Хилийн толь бичиг" зэрэг нэг сэдэвт бүтээл мөн түүнчлэн хууль тогтоох болон эрх зүйн хэм хэмжээт актууд, бусад баримт бичгийн төслийг боловсруулласа. Эдгээр ажлыг хийж гүйцэтгэхэд янз бүрийн байгууллага, чиглэлийн 60 гаруй эрдэмтдийг татан оролцуулжээ. 2008 оноос Хил судлалын салбар ОХУ-ын ХАБА-ны Хилийн Академитэй хамтран Хил судлалын чиглэлээр эрдэм шинжилгээний семинарыг тогтмол зохион байгуулан, энэ хугацаанд ОХУ-ын эрдэм шинжилгээ, боловсролын 53 байгууллагын 200 гаруй эрдэмтэн, судлаачид илтгэлээ хэлэлцүүлсэн байна.

Хил судлал гэдэг нь улсын хил ба хилийн орон зайд улс орон, нийгэм, бие хүний аюулгүй байдлыг хангах, тэдний эрх ашгийг хамгаалах нийгэм улс төрийн нарийн түвэгтэй үзэгдлийн шинж байдал, хууль, зүй тогтлын талаарх мэдлэгийн тогтолцоо, геополитикийн бие даасан салбар юм.

Үүнээс үүдэн хил судлалын судалгааны гол төвд хилийн тодорхой нөхцөл байдал, хилийн харилцааны тохиолдлын хэлбэрүүд, тухайн үед үйлчилж буй хилийн албаны арга хэрэгсэл төдийгүй хилийн өөрийнх нь мөн чанар, тодорхой нэг улсын хил, орчин үеийн Оросын хилийн бодит байдал төдийгүй хилийн болон улс орнуудын хамтын ажиллагааны мөн чанар бүхэлдээ оршдог. Гэхдээ өнөөгийн бодит байдал хилийн байдлыг түүний нэг шинэ бүрдэл хэсэг болгон залуу шинэ онол бүрдүүлж байгааг үгүйсгэх аргагүй юм. Хил судлал үүсэн бий болсон нь манай нийгмийн өмнө орчин үеийн Оросын хилийн салбарын гаргаж тавьсан олон тооны асуудал, тодорхойгүй байдалд шинжлэх ухааны хариулт нь болж байгаа юм.

Хил судлалын судалгааны обьект нь хилийн олон талт, нарийн нийлмэл ертөнц, улсын хил, улс хоорондын хамтын ажиллагаатай холбоотой олон тооны обьект, судлах зүйл, үйл явц, үзэгдлийн нийлмэл цогц болох хилийн орон зай юм.

Иймээс хил судлал нь нийгмийн тодорхой тогтолцоо болох улс орнуудын харилцаа, хамтын ажиллагааг хилийн харилцаанд авч үзэж судалдаг. Хилийн харилцаа нь олон талт шинжтэй бөгөөд энэ нь нийгмийн амьдрал, үйл ажиллагааны хилийн салбарын нарийн түвэгтэй талыг тусгаж байдаг, хилийн харилцааны өөр өөр үндэслэлүүдтэй байдгаар онцлог юм.

1. Янз бүрийн нийгмийн бүтэц, эдийн засаг, улс төр, оюуны болон харилцааны тогтолцоо бүхий, харилцан адил бус байх нь хилийн харилцааны үндэс юм.

2. Эдгээр улс орнуудад буй болсон нийгмийн тогтолцооны өвөрмөц шинж бүхий, нийгмийн байгууллын хэлбэр байдлаар улс орнууд оршин тогтнож, тогтвортой байдал нь хилийн харилцааны дараах үндэслэлүүдийг бүрдүүлдэг.

3. Тодорхой нийгмийн тогтолцоо ба улс орны хэрэгцээ нь нийгмийн тогтолцоо үндсэн шинжээ хадгалан, байгаа байдлаараа үлдэх тэрхүү хязгаарыг тодорхойлох аргыг бий болгодог. Иймхүү тодорхой тогтолцооны хязгаарыг тогтоох арга нь улсын хил тогтоох арга юм. Хил тодорхой байх нь хилийн харилцааны чухал нөхцөл юм.

4. Зэрэгцэн оршихын тулд ерөнхий нэг хилтэй байх хэрэгцээ нь харилцан холбоо, хамаарал бүхий хилийн орон зайг бүрдүүлэхэд нөлөөлдөг. Харилцан холбоо хамааралт чанар нь хилийн харилцааны үндсийг бүрдүүлдэг.

5. Хилийн салбар дахь хүмүүсийн ухамсарт, хамтын үйл ажиллагаа- нийгэмших нь хилийн харилцааны өөр нэгэн чухал үндэс болдог бөгөөд эцсийн дүндээ хүмүүсийн ухамсарт, зорилго чиглэл бүхий үйл ажиллагааны үр дүн юм.

Хилийн салбарын үндсэн элементүүд, тэдгээрийн харилцан хамаарал, түүний хөгжлийн зүй тогтол, хэтийн төлөв, хилийн үйл ажиллагаа, нийгмийн хилийн салбар, улс орны хилийн салбар зэрэг нь хил судлалын судлах зүйл юм.

Нийгмийн хилийн салбар гэдэг нь нийгмийн орон зайн хил хязгаарыг төлөөлж, түүнийг гадаад ертөнцтэй холбож байдаг нийгмийн өөрмөц салбар юм. Нийгмийн хилийн салбар нь юуны өмнө хилийн орон зайд төвлөрч байдаг.

Хилийн орон зай гэдэг нь хил дамнан харилцан зорчиж, харилцаа холбоо, хамтын ажиллагаа, улс хоорондын зааглалыг тодорхойлох процессууд явагддаг, түүхийн хувьд нийгмийн тогтолцоо болон улс гүрнүүдийн уулзвар зааг дээр бүрэлдэн тогтсон нийгэм улс төрийн онцгой бүс юм. Өөрөөр хэлбэл хилийн орон зайн мөн чанар нь ерөнхий нэг хил бүхий нийгмийн тогтолцоонууд (улс гүрнүүд) зэрэгцэн орших нөхцлийг хангадаг аргуудын нэг нь болдогт оршино.

Улс орны хилийн салбар гэдэг нь хилийн харилцааны тогтолцоонд бие хүн, нийгэм, улс орны эрх ашгийг хамгаалдаг төрийн институцүүд мөн тэдгээрийн үйл ажиллагааны арга хэлбэрийн цогц юм. Улс орны хилийн салбар нь хилийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Хилийн үйл ажиллагаа гэдэг нь хүмүүсийн тулгамдсан хэрэгцээ, зорилгод нийцүүлэн улсын хил ба хилийн орон зайг өөрчлөн зохион байгуулах субьектүүдийн үйл ажиллагааны ухамсартай, зохистой практик бөгөөд нийгмийн хөгжлийн үнэт зүйл, ёс суртахуун ухамсрын хандлага, эрх ашиг энэхүү үйл ажиллагааны үндэс нь болдог. Нийгмийн хэрэгцээг хангана гэдэг нь зарчмын хувьд нийгмийн харилцаа холбоо, хамтын ажиллагааг оршин амьдрах нийгэм, байгалийн орчинтой нь холбож, тодорхой хугацаа, нөхцөлд обьектод учрах хор хохирлоос урьдчилан сэргийлэх өвөрмөц үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн аюулгүй байдлыг хангаснаар хэрэгжих боломжтой болно. Иймээс хилийн үйл ажиллагааг хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хэмээн тодорхойлж болно.

Хилийн аюулгүй байдал гэдэг нь нийгэм, улс орон, түүний иргэдэд хор хохирол учраагүй үед хилийн үйл ажиллагааны бусад субьект, нөхцөл, хүчин зүйлүүдтэй холбогдох хилийн харилцааны тодорхой байдал бөгөөд улс орон иргэдийн хэрэгцээ, нийгмийн дэвшил хөгжлийн үнэт зүйлс, ухамсар ёс суртахууны чиглэлд нийцүүлэн улсын хил ба хилийн орон зайг өөрчлөн зохион байгуулах нөхцлийг бий болгодог. Үүнээс үүдээд хилийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл нь хилийн аюулгүй байдлыг хангах явдал юм. Улс орны хилийн аюулгүй байдлыг хангахын мөн чанар нь хилийн үйл ажиллагааны тогтолцоо бусад тогтолцоонуудтай тэнцвэртэй харилцаа холбоо, хамтын ажиллагаатай байх хилийн харилцааны тогтолцоог хөгжүүлэх нөхцлийг төрөөс бий болгоход оршино.

Бусад шинжлэх ухааны нэгэн

адил хил судлал нь тухайн түүхэн үе шатанд өнгөрсөн үеийн бүхий л ололт амжилтыг нийлмэл байдлаар нэгтгэн авч үзэх кумулятив шинжийг агуулж байдаг. Хил судлал нь бусад шинжлэх ухааны арга хэрэгслүүдийг ашиглан явуулдаг шинжлэх ухаан хоорондын болон цогц судалгааг идэвхтэй ашигладаг. Хил судлал нь цэргийн, оператив, техникийн, эдийн засаг, улс төр, эрх зүйн болон бусад мэдлэгийн салбар ухаануудын уулзвар дээр оршдог нь түүний цогц, интегратив шинжийг илэрхийлж байгаа юм. Судалгааны обьект, судлах зүйлээс нь үүдэн хил судлалыг нийгмийн шинжлэх ухаанд хамруулж үзэх зайлшгүй шаардлага байна. Үүний зэрэгцээ хил судлал нь бусад шинжлэх ухаантай нарийн холбоонд оршдог.

Хил судлал:

- Улс төр судлал: хилийн орон зайд улс төрийн ашиг сонирхол, харилцаа, үйл явцын онцлог
- Хууль зүйн шинжлэх ухаан: хилийн салбарын төрийн удирдлагын эрх зүйн чиглэлүүд, түүнд зориулсан хэм хэмжээ тогтоох процессын эрх зүйн үр дагавар
- Социологи ба соёл судлал: хилийн бодлогын нийгэм соёлын агуулга
- Түүх, улс төр, эдийн засгийн газар зүй, бүс нутаг судлал болон лимологи, нийгэм, улс төрийн сэтгэл судлал: улсын хил болон нутаг дэвсгэрийн талаарх мэдлэгийг бий болгох төрөл бүрийн чиглэлүүд
- Тогтолцооны ерөнхий онол, шийдвэр гаргалтын онол: хилийн орон зайн стратегийн удирдлагын онолын үндэс, погранометрик
- Мэдээлэл зүй: хилийн салбарын стратегийн удирдлагын мэдээлэл хангамж, геополитикийн загварчлал
- Гүн ухаан, даяаршил судлал: хилийн бодлогын онтолог, гносеолог, үнэт зүйлсийн үндэслэл
- Ерөнхий экологи: хилийн орон зай экосистем болох нь
- Цэргийн ухаанууд: Улсын хил хамгаалах цэргийн чиглэлүүд

Хөгжлийн эхэн үедээ хил судлал хилийн асуудлын хууль эрх зүйн судалгаа, энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг төр эрх зүйн болон улс төрийн институцүүд, төрийн хилийн салбарын бүтэц мөн түүнчлэн хилийн эрх ашиг, түүнтэй холбоотой бодлого, улс орнууд, бүс нутаг, нийгмийн бүлгүүд болон хувь хүмүүсийн байдалд анхаарлаа хандуулж ирсэн. Өөрөөр хэлбэл энэ үе шатанд хилийн асуудал судлаачдын анхаарал үндсэндээ улсын хил, хил хамгаалах субьектүүд болох төрийн байгууллагуудын асуудалд төвлөрч байлаа.

Судалгааны олон тооны зорилтууд ОХУ болон бусад улс орнуудын хилийн салбарт төдийгүй нийт хүн төрөлхтөний өмнө сүүлийн жилүүдэд илрэн гарч буй олон тооны үзэгдэл, үйл явцын зүй тогтлыг илрүүлэн тодорхойлох, "үндэстний эрх ашгийн" байр сууринаас тэдгээрийг ангилах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг нь тодорхойлох, улс орны хилийн дэд бүтцийн удирдлагыг зүй зохистой зохион байгуулах, үйл ажиллагааны үр дүнгээс нь хамаарч улс орон түүний улс төрийн институцүүдийг авч үзэх, хилийн салбарт улс орны үндэсний эрх ашгийг хангах санал боловсруулахад хандаж байлаа. Аливаа шинжлэх ухааны нэгэн адил хил судлал нь дотоод үндэслэл бүхий дотоод логиктой. Шинжлэх ухааны үндэслэл гэдэг нь судалгааны стратегийг тодорхойлж, тодорхой онолын болон эмпирик мэдлэгийг нэгдмэл тогтолцоонд оруулж, түүнийг аль нэгэн түүхэн үеийн соёлд нэвтрүүлж буй тухайн шинжлэх ухааны суурь төсөөлөл, ойлголт, зарчмууд юм.

Хил судлалд дараах үндэслэлүүдийг ангилж үзэж болох юм:

1. Түүхэн үндэслэл (шинжлэх ухааны хөгжлийн онолын хандлага, зарчим, дотоод логикийг боловсруулан бий болгосон түүх)

2. Эмпирик үндэслэл (шинжлэх ухааны хуримтлуулсан үнэн зөв баримтуудын цогц)

3. Синтетик буюу нийтлэг үндэслэл (шинжлэх ухааны баримтуудыг нэгтгэн, онол байдлаар тодорхой санааг нэгтгэн дүгнэх)

4. Логик үндэслэл (ойлголт, дүгнэлт, баталгаа, зүй тогтол, хуулийн цогц)

5. Философи- арга зүйн үндэслэл (арга зүйн, ертөнцийг үзэх, социологийн зарчмууд)

6. Хавсарга үндэслэл (практик дүгнэлт, зөвлөмжийн зохистой чанар, нийцэл, үндэслэл)

Хил судлалын гүн ухаан-арга зүйн хамгийн чухал үндэслэл нь: улсын хил, хилийн орон зай, хилийн харилцаа, хилийн үйл ажиллагаа, улсын хилийн аюулгүй байдал, улсын хилийн аюулгүй байдлыг хангах зэрэг юм. "Хил" хэмээх ухагдахуун өөрөө гадаад ба дотоод, өөрийн болон харийн, төгсгөлтэй болон төгсгөлгүйн харилцан хамаарлыг нээн илрүүлдэг диалектикийн чухал ойлголт юм. Иймээс ч хилийн гүн ухаан хэмээх гүн ухааны шинэ чиглэл үүсэн бий болсон.

Хил судлалын үндэслэл нь дараах үүргүүдийг гүйцэтгэдэг: 1) шинжлэх ухааны суурь судалгааны хөтөлбөр болохын хувьд тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдэх арга замыг тодорхойлдог, 2) шинжлэх ухаан бүрийн онолын болон эмпирик мэдлэгийг нэгдсэн тогтолцоонд оруулж шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо үүсгэгч бааз суурь болдог. Мөн шинжлэх ухаан хоорондын харилцан хамаарал, мэдлэгийн шинжлэх ухаан хоорондын задлан шинжлэл, харилцан үйлчлэлийн стратегийг тодорхойлдог.

Хил судлалын ертөнцийг үзэх үзлийн онцлог нь нийгмийн, түүхэн, геополитикийн, эдийн засгийн болон соёлын хэрэгцээ, хүчтэй төрийн тусламжтайгаар тэдгээрийг хамгаалах, батлан хамгаалах чадамжаас үүдэлтэй улс орны болон нийт үндэстний эрх ашигт суурилсан үндэсний сургаалийн гол судас болох их гүрний үзэл юм.

Хилийн харилцаа, хилийн үйл ажиллагааг судалдаг хавсарга ухаан болохынхоо хувьд хил судлал нь төрийн хилийн бодлогын онолын бааз суурь бөгөөд үүнд түүний чухал үүрэг роль оршдог юм.

Эндээс төрийн хилийн бодлогыг бүрдүүлэхэд шаардагдах хил судлалын үндсэн үүргүүд урган гардаг:

- Хөтөлбөрийн онолын үүрэг (хилийн аюулгүй байдал, хилийн харилцаа ба хилийн үйл ажиллагааны үндсэн байр суурийг боловсруулах)
- Хэм хэмжээт зохицуулалтын үүрэг (хилийн харилцаа, хилийн үйл ажиллагааг эрх зүйн хувьд хангах)
- Төлөвлөгөөт задлан шинжлэлийн үүрэг (хилийн орон зайд учрах аюул занал, ашиг сонирхлыг тоймлож, задлан шинжилж дүгнэх, тэдгээрийг саармагжуулах арга хэрэгсэл)
- Зохион байгуулалт, удирдлагын үүрэг (эрх мэдэл бүхий байгууллагуудын хилийн үйл ажиллагааны амьд практик).

Материалист диалектик, синергетик, тогтолцоот болон үйл ажиллагааны хандлагуудын арга зүйг хамтад нь хэрэглэх хүрээнд хил судлал нь нийгэм, төрийн амьдрал үйл ажиллагаанд хилийн бодит байдал, түүний эрх ашиг, түүнд учрах аюул заналын талаар бүхэл бүтэн, тогтолцоот төсөөлөлтэй болгож өөрөөр хэлбэл хилийн бодит дүр зургийг бүрдүүлж, хилийн хууль сахиулах үйл ажиллагааг

сайжруулах боломж олгодог.

Ийнхүү хил судлал шинжлэх ухаан болохын хувьд судалгааны өөрийн обьект, судлах зүйл, судлах зүйлийн өвөрмөц зүй тогтол, судалгааны тусгай арга, зарчим, өөрийн ойлголтын аппараттай байдаг нь түүний амьдрах чадварыг тодорхойлж байгаа юм.

Хил судлалын судалдаг цогц асуудлуудыг хэд хэдэн салбарт хуваан үзэж болно:

- Улс хоорондын зааглалын нийгэм-гүн ухааны болон үзэл-онолын (ертөнцийг үзэх) чиглэлүүд, хилийн тогтолцооны тогтолцоо бүрдүүлэгч шинжүүд, түүхэн тодорхой үе шатад хамаарах улс хоорондын зааглалын үйл явцын парадигм

- Улсын хилийн антрополог ба типолог, түүнд байдаг үүрэг, дэглэмүүдийн хоорондын ижил төстэй болон ялгаатай тал, түүний давуу болон сул тал, тэдгээрийг өөрчлөх нөхцөл гэх мэт, энэ бүхэн хилийн албаны байгууллагуудын хилийн үйл ажиллагаанд нөлөөлөх нь

- Улс орны хилийн салбар, түүний хилийн үүрэг, институцүүд, төрийн хилийн бодлого болон хилийн үйл хэргийн онцлог, тэдгээрийг хөгжүүлэх зохистой чиглэл, арга, хэлбэрүүд

- Хилийн орон зайд улс орон, нийгэм, бие хүний эрх ашгийг хамгаалдаг хилийн хүч хэрэгсэл (улсын болон нийгмийн институцүүд), тэдгээрийн үйл ажиллагааны үр дүн, хөгжлийн хэтийн төлөв

- Улсын хил болон улсын эдийн засгийн онцгой бүсийг хамгаалах арга хэлбэр

Хил судлалын эдгээр дурдсан салбарууд нь агуулгын хувьд ижил ач холбогдолтой, дотоод бүтцийн хувьд харилцан хамааралтай юм.

Иймээс хил судлал нь нийгмийн ухамсрын бүрдэл хэсэг, хүний хамтын үйл ажиллагааны албан ёсны хэрэгсэлд тулгуурлан хилийн бодлогыг хэрэгжүүлдэг төрийн эрх мэдлийн арга болохынхоо хувьд хилийн бодлогыг бүрдүүлдэг, төрийн гадаад, дотоод бодлогын өвөрмөц хэсэг юм. Мэдээж шинжлэх ухааны шинэ чиглэл болохын хувьд хил судлалд даяаршлын энэхүү нөхцөлд хилийн үйл ажиллагаа, болон хилийн аюулгүй байдлын өнөөгийн тулгамдсан асуудлуудыг /нийгэмд аюултай, гэмт хэргийн хандлагууд, өсөн нэмэгдсээр буй хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхдээ хүний үндсэн эрхийг хангах, шинэ нөхцөлд хилийн бодлогын стратеги, тактик хэрэгжүүлэх гэх мэт/ хангалтгүй боловсруулсантай холбоотой үүсэх асуудлууд байдаг. Мөн түүнчлэн хил судлалыг шинжлэх ухааны чиглэл болохынх нь хувьд хүлэн зөвшөөрөх, эрдэм шинжилгээ судалгааны ажил зохион байгуулах, салбар шинжлэх ухааны хувьд хөгжүүлэх, судалгааны үр дүнг амьдрал практикт хэрэглэх зэрэг асуудал ч багтдаг.

Үүнээс үүдэн ойрын үед:

1. Хил судлалын бүх бүрдэл хэсгүүдийг (гүн ухаан нийгэм, улс төр, эдийн засаг, цэрэг, оператив, техник, түүхийн) хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх

2. Хил судлалыг сургалтын үндсэн суурь хичээл болохынх нь хувьд шинжлэх ухааны болон боловсролын үйл ажиллагаанд үе шаттайгаар нэвтрүүлэх механизмыг бүрдүүлэх

3. Хил судлалын бүтцийн бүрдэл хэсгүүдийг зохих онол, практик зөвлөмжөөр гүйцээх арга зүйг боловсруулах: хил хамгаалалтын гүн ухаан, ёс зүй, хил хамгаалалтын онол, практик, хил хамгаалалтын эдийн засаг, хил хамгаалалтын түүх, хил хамгаалалтын техник, технологи, хил хамгаалалтын сэтгэл судлал г.м.

4. Хилийн үйл ажиллагаа, лимологи, хил судлалыг журамлахад нөлөөлөх

5. Залуу эрдэмтэн, багш нарын бүтээлч идэвхийг өрнүүлж, шинжлэх ухааныг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх

6. Өөр өөр орны боловсролын процесст үндэсний аюулгүй байдлын хичээлүүдийг судалдаг, заадаг туршлагыг судлах

7. Хил судлалын салбарт шинжлэх ухааны мэдлэгийн бүтэц, динамик, хил судлалын онолын ангилал, тэдгээрийн практик хэрэглээ, боловсролын процесст оруулах зэрэгт судалгаа хийх шаардлагатай байна.

Хилийн салбарын бүхий л боловсролын байгууллагууд хилчин офицеруудыг бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх хөтөлбөртөө хил судлалыг суурь боловсролын хичээлүүдийн нэг болгон оруулсан тохиолдолд дээр дурдсан асуудлуудын ихэнхийг шийдвэрлэх боломжтой юм.

Бидний гол зорилт бол шинжлэх ухааны практикт зайлшгүй шаардлагатай, шинэ зүйл гэдгийг нь батлахын тулд хилийн талаарх бие даасан шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хамтран ажиллаж, хил судлалд байвал зохих орон зайг нөхөх явдал гэж харж байна.

БҮС НУТАГ БА ХИЛНИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ



Н.Наранжамц

Монголын Хил Судлалын Академийн тэргүүлэгч гишүүн, БХИС-ийн Сургалтын хэлтсийн дарга доктор, профессор, хурандаа

Хил хязгаарын тухай ойлголт нь хүн төрөлхтөн үүссэн цагаас бий болсон гэж үздэг. Энэ нь хүй нэгдлийн үеэс өнөөг хүртэлх хугацааг хамарч байгаа бөгөөд эртний хүн сүрэг нь идэх хоол хүнс, амьтан ургамлыг эрж хайх, олж эзэмших явцдаа байгалийн хил хязгаар хэмээх ойлголтыг бий болгож, өөр бусад хүн сүргээс олж эзэмшсэн хоол хүнс, байгалийн бүтээгдэхүүнээ хамгаалж ирсэн байна.

Хүн төрөлхтөний хөгжлийн явцад амьдрах орчин, нөхцөл өөрчлөгдөж, хүн сүргээс ухамсарт хүн бий болж, тэдний хэрэгцээ шаардлага өсөн нэмэгдэхтэй уялдан хэлбэр хэмжээ, их багын тухай ойлголт бий болж, энэхүү ойлголтыг хэмжих хэмжүүрийн нэгжийн хязгаар буюу "хил" хэмээх ухагдахуун бий болсон гэж судлаачид үздэг байна.

Өөрөөр хэлбэл "Хил гэдэг нь аливаа юмс зүйлсийн хэлбэр хэмжээг тодорхойлогч ухагдахуун" юм.

Үүнээс үзвэл хил нь хязгаарлагч, хязгаарын тухай ойлголт болох бөгөөд знэхүү ойлголтыг улс үндэстнүүд газар нутгийн хязгаарыг тодорхойлж буй утгаар нь өргөн хэрэглэж заншсан болно.

Тусгаар улсыг тодорхойлогч хэд хэдэн хүчин зүйлс байдаг. Үүнд:

- Өөрийн гэсэн газар нутагтай байх
- Өөрийн гэсэн хүн амтай байх
- Өөрийн гэсэн хэл соёлтой байх
- Өөрийн гэсэн тусгаар тогтнолоо дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд тунхаглан зарласан байх явдал юм.

Тусгаар тогтносон тусгаар улсыг тодорхойлогч чухал хүчин зүйлүүдийн нэг болох газар нутаг нь тодорхойлон тогтоогдож тэмдэглэгдсэн хил хязгаартай байх бөгөөд газар нутгийн үндсэн баталгаа нь өөрийн гэсэн улсын хилтэй, энэхүү хил хязгаараа зэргэлдээ улс орнуудаараа хүлээн зөвшөөрүүлж, гэрээ хэлэлцээрээр баталгаажуулан, хууль тогтоомжоор зохицуулсан байх явдлаар хангагдана.

Дэлхий дахинд улсын хил гэдэг ойлголтыг тусгаар тогтнолын баталгаа, газар нутгийн хаяа хязгаарыг тодорхойлогч гэж үзэн "улсын хил" гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн ухагдахуун бий болгон хэрэглэж нэгэнт заншсан болно.

Улсын хилийг:

- газрын хил;
- усан хил;
- агаарын хил;
- газрын хэвлийн хил гэж ангилан авч үздэг бөгөөд даяаршлын өнөөгийн үед улсын хилийн талаарх

ойлголт улам бүр өргөсч

- Нийтлэг хил хязгаар;
- Ашиг сонирхлын хил хязгаар;

- Газар нутгаас ангид хил хязгаар хэмээх шинэ ойлголтууд нэгэнт бий болоод байна.

Түүнчлэн улс гүрнүүдийн оршин байгаа газар нутаг нь:

Тусгаар тогтнолын баталгаа эсвэл тусгаар тогтнохын үндэс болдог;

Мөнхөд оршин байх, эзэмшин байх нь улс бүрийн язгуур ашиг **сонирхол** нь болдог;

Хүн амын амьдран байх үндэс, баялгийн эх сурвалж болдог төдийгүй үйлдвэрлэл, үйлчилгээ, хууль ёс сахих эх талбар, өөрийнхөө доорх баялаг нууцлагаараа бусдын ашиг сонирхлыг татаж байдаг юутай ч зүйрлэшгүй үнэт баялаг юм.

Дэлхийн улс гүрнүүд аюулгүй байдлаа хангах ундэсний бодлого стратегиа бий болгох, хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн анхааарч, ингэхдээ дэлхий дахин, бүс нутгийн аюулгүй байдлыг чухалчлан үзэж байна.

Цэргийн эрдэмтэд, онолчид ертөнцийн орон зайг геостратегийн орон зайгаар нь дараах бүсүүдэд хуваан авч үзэж байна.

Үүнд:

- Тивийн бүс;
- Эх газрын бүс;
- Далайн бүс;
- Стратегийн орон зайн бүс;
- Сансрын стратегийн бүс гэх мэт.

Эдгээрээс стратегийн бүсийг тив дэлхийн газар нутгийн хэсэг эсвэл тухайн газар нутгийг бүхэлд нь ойролцоо байх эдийн засгийн бүс, агаарын орон зайг хамтатган авч үзэж аливаа улсын цэрэг эдийн засгийн болзошгүй аюулаас хамгаалах орчин юм гэж тодорхойлсон байна.

Жишээ нь, ОХУ, Европын болон Евроазийн газар нутаг, Европын улсууд болон: Азербайждан, Армени, Гүрж, Кипр, Ливан, Сири болон Турк тэдгээрт хамаарах Атлант, Каспин тэнгисийн бүс нутгийн болон агаарын орон зайг оруулан дээрх чиглэл дэх гадаад тэнгисийн хилийг хүртэлх орон зайг багтаасан хуурай газар, тэнгис, далайн уудмыг өөрийн улсын Европ дахь стратегийн бүс гэж авч үздэг байна.

Монгол Улсын хувьд бүс, бүс нутаг, стратегийн болон оперативын орон зайгаа тодорхойлох зайлшгүй шаардлагатай бөгөөд өнөөдрийн байдлаар төв болон дундад, зүүн хойд, зүүн өмнөд Ази, Европын Орос дахь газар нутаг, Казакстан, Хятадын газар нутаг бүхэлдээ, Энэтхэгийн болон Номхон далай, Солонгосын хойгийг багтаасан орон зайг өөрийн улсын аюулгүй байдлын бүс, бүс нутаг гэж авч үзэж болох юм.

Өнөөдөр дэлхийн газар нутаг үндсэндээ их гүрнүүдийн хяналтад хуваагдаж, тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх аливаа сөрөг хүчин зүйлийг даван туулах, арилгахад чиглэсэн цэрэг-улс төр, худалдаа-эдийн засаг болон бусад бодлого, үйл ажиллагааг бүс нутгийн хэмжээнд **авч** хэрэгжүүлж **байгаа нь нэгэнт тодоохой** билээ. Уламжлалт их гүрнүүд болон хүн ам, газар нутаг, хөгжлөөрөө тэргүүлэгч улсууд **дэлхий** дахинд өөр өөрсдийн бодлого /улс төр, эдийн засаг, хууль, худалдаа, далай тэнгисийн баялаг, ашигт малтмал, газрын тосны нөөц гэх мэт хөгжилд түлхэц өгөхүйц эх сурвалжуудыг эзэмших, ашиглах, хяналтандаа байлгах/-ыг тодорхойлон өрсөлдөж байгаа нь нууц биш бөгөөд энхүү сөргөлдөөн тэмцлийн явцад тухайн бүс нутагт оршиж байгаа бага, дунд буурай улс орнуудын язгуур эрх ашиг, аюулгүй байдал хөндөгдөж, эдгээр эрх ашиг нь хөндөгдөж буй улс орнууд оршин байх, аюулгүй байдлаа хангахад

онцгой анхаарах боллоо.

Өөрөөр хэлбэл тухай улсын аюулгүй байдал нь бүс нутгийн аюулгүй байдал болон дэлхий дахин бүс нутгийн глобал хямрал /дэлхийн дулаарал, эдийн засгийн хямрал, байгаль-экологи, нөөцийн хомсдол гэх мэт/-аас шууд ба шууд бус хамааралтай болох нь нэгэнт тодорхой болж байна.

Монгол Улс хэдийгээр далайд гарцгүй, эх газрын улс боловч дэлхий дахин болон бүс нутагт нөлөө бүхий хүчирхэг их гүрнүүдтэй хил залган оршдог, аюулгүй байдал нь дээр дурдсан улсуудаас шууд хамааралтай төдийгүй бүс нутагт дээрх улсуудын нөлөөгөөр тогтвортой байх, тогтворгүй байх нь шууд шалтгаалах эмзэг орчинд оршин тогтнож байна.

Дэлхий дахинд цэрэг улс төрийн нөхцөл байдал төдийлөн таатай бус, бүс нутаг, улс хоорондын зөрчил тэмцэл үргэлжлэн, зарим тохиолдолд бүхэл бүтэн тив, улсыг хамарсан /хувьсгал/ тэмцэл гарч, дээрх бүс нутаг, улс оронд тогтворгүй байдлыг бий болгож, улмаар дэлхий дахины цэрэг, улс төр, нийгэм эдийн засагт нөлөөлөхүйцээр даамжрах хандлага бий болж байна.

Бүс нутгийн аюулгүй байдлын орчинд таагүй өөрчлөлт гарах, эдийн засаг, хүмүүнлэгийн хямрал нүүрлэх, улмаар хөрш орнуудын дотоод улс төрийн байдал хурцдах, үндэсний эв нэгдэл, нэгдмэл байдалд нь заналхийлэх хүчин зүйлс их биш ч, үгүйсгэж боломгүй хэмжээнд байна. Үйл явцын ийм таагүй өрнөлийн үед зэвсэгт бүлэглэлүүд салан тусгаарлагчид, олон улсын террористууд, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүдийн зохион байгуулалттай үйл ажиллагаа идэвхжиж болзошгүй.

Нөгөө талаар Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг үгүйсгэж, улсын хил зөрчин гэмт хэрэг үйлддэг, хил орчмын нутаг дэвсгэрт амьдрагч иргэдийн амь нас, аюулгүй байдалд заналхийлдэг, улсын хилээр хориглосон бараа материал, зэвсэг, галт хэрэгсэл хил нэвтрүүлдэг, зохион байгуулалттайгаар автомашин, спирт, ноос ноолуур, ангийн үс, эд эрхтэн, археологийн олдвор, үнэт металл, ховор эдлэлийг хууль бусаар хил нэвтрүүлэн худалдсан гэх мэт уламжлалт зөрчлүүд, сүүлийн үед хүн худалдаалах, хар тамхи, мансууруулах бодис хил давуулах гэмт хэрэг илэрхий даамжрах хандлагатай болж, бүс нутагт энэ төрлийн гэмт хэрэг идэвхжиж, манай улс дээрх гэмт хэргийн сүлжээнд бүртгэгдэж, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлээс манай улсын иргэдийг болон хилийн хяналт шалгалтын сайнгүй нөхцөл байдлыг гэмт үйлдэлдээ ашиглах боллоо.

Түүнчлэн улсынхаа хилийг эцэслэн тодорхойлж, тогтоогоогүйн улмаас хилийн асуудлаарх маргаан нь даамжран бүс нутгийн зарим улсуудын хооронд улс төр, дипломатын аргаар зохицуулахад хүндрэлтэй нөхцөл байдлууд бий болоход хүргэж байна. *Бүс* нутагт салан тусгаарлах үзэл, ажиллагаа идэвхжиж, үргэлжилсээр байгаа нь томоохон улсуудын улс төр, цэрэг, эдийн засгийн хүчийг туйлдуулах, залхаахад хүргэж, улмаар салан тусгаарлагчидтай хүчний тэмцэл явуулахад хүргэж байгаа нь дүрвэгсэд, нуцаар хил нэвтрэгсдийн тоог өсгөхөд хүргэж болзошгүй болно.

Бүс нутаг дахь таагүй нөхцөл байдал нь тухайн бүс нутаг дахь улс орнуудын аюулгүй байдал, түүний дотор улсын хил, хилийн орон зайд улс үндэстний аюулгүй байдалд *нөлөөлөх* тодорхой сөрөг хүчин зүйлүүдийг (нөхцлийг) бий болгодог байна.

Дэлхийн улсуудын авч үзэж байгаагаар дурьдсан нөхцөл байдлууд нь тухайн улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх, зайлшгүй анхаарвал зохих дараах сөрөг хүчин зүйлүүдийг бий

болгодог гэж үздэг байна.

Үүнд:

Хөрш улсуудын тусгай албадын явуулж буй тагнуул-сөрөг ажиллагаа;

Тухайн улсыг өөрийн геополиктикийн ашиг сонирхлын хүрээнээс гаргах зорилгоор бусад бүлэг улсуудын зүгээс тодорхой бүс нутагт өөрсдийн нөлөөллийг нэмэгдүүлэх хүчин чармайлт тавьж буй байдал болон найрсаг дотно харилцагч улсуудтай явуулах хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх оролдлого;

Хил залгаа улсуудын үндсэрхэг үзэлтэй байгууллагуудын зүгээс өөрийн төр засгаас тухайн улсад алдагдсан гэх газар нутгаа эргүүлэн авах гэх мэт элдэв | шаардлага үйл ажиллагаа;

Хилийн шугамын явалт өөрчлөгдсөнөөс үүдэлтэй нутаг дэвсгэрийн харъяаллын талаарх санал зөрөлдөөн;

Хил орчмын нутаг дэвсгэр дэх нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын хүндрэл;

Олон улсын гэмт хэргийн бүлэглэлүүд хууль бусаар дүрвэгсдийг тухайн оронд оруулах, гуравдагч улсад гаргах болон түүхий эд, үнэт зүйлс, материалын нөөц, зэвсэг галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх оролдлого;

Хил залгаа улстай хилийн шугам тодорхой тогтоогдоогүй байдал, цэрэг улс төрийн цагийн байдлын хурцдал, хил орчим дахь хууль бус бүлэглэлийн үйл ажиллагаа, улс орны дотоод зөрчлийг зохицуулах үйл явцын хүндрэлтэй холбоотойгоор хилийн зарим хэсгийн цагийн байдлын тогтворгүйжилт;

Хил хамгаалах байгууллага, хилчдийн эсрэг тухайлбал, улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт газаруудад гэмт этгээд, алан хядагчдын зүгээс явуулж буй хууль бус үйл ажиллагаа;

Мэдээллийн сөргөлдөөний идэвхжил, улс үндэстэн дамнасан гэмт , хэргийн бүлэглэлүүд төр засгийн эрх мэдлийг бууруулах, хил орчмын оршин суугч, цэргийн албан хаагчид, тэдний гэр бүлийн эсрэг хууль бус үйлдэл хийхэд турхирах, заналхийлэх замаар сэтгэл зүй, мэдээллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж| явуулах зэрэг болно.

Орчин үед дэлхийн улсуудын олон улсын тавцан дээрх байр суурь нь юуны түрүүнд байгалийн баялаг, технологи, мэдээллийн нөөц, тэдгээрийг борлуулах зах зээлиг эзэмших зорилго бүхий өрсөлдөх чадвараар хэмжигдэж байна.

Улсын хил, хилийн аюулгүй байдалд учруулж болох аюул заналыг бүхэлд нь:

- Улс төрийн;
- Эдийн засгийн;
- Нийгмийн;
- Цэргийн;
- Хүн амын;
- Байгаль экологийн аюулгүй байдалтай шууд холбоотой гэж үздэг тул улсын хил, хилийн орон зайд улсын хил хамгаалалтын найдвартай тогтолцоо бий болгохыг шаардаж байдаг.

Улсын хилийг хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах дээрх хэрэгцээ шаардлага, бүс нутгийн нөхцөл байдал, Монгол Улсын дотоод улс төр, хилийн цагийн байдлаас үндэслэн хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог шинээр бий болгох, Хилийн аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар ажиллах шаардлага тавигдаж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол Улсын хувьд:

Ерөнхийлөгч, **Улсын их хурал,**

Засгийн газарт хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хуулиар хүлээлгэх;

Засгийн газрын яам, агентлагуудад өөр өөрсдийн хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд хилийн аюулгүй байдлыг хангахад хэрхэн оролцох үүргийг нь тодорхойлох;

Бүтэцтэйгээр шинэчлэн байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Эдгээр үндэслэл, хэрэгцээ шаардлагыг тайлбарлах нь илүүц тул бүс нутгийн аюулгүй байдал, хилийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг шинэ шатанд гаргах, хилийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг шинэчлэн өөрчлөх, хилийн аюулгүй байдлын ажилтнуудыг сургах, бэлтгэх, техник технологийг сайжруулах, бэлэн байдал, ажиллагааны далайцыг эрчимжүүлэх гэх мэт олон талт арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Хил судлал.

Хил судлал.

ДАЯАРШЛЫН ҮЕИЙН ХИЛИЙН ХАРИЛЦААНД ЗААВАЛ АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



Г.Дагважамц

Монголын Хил Судлалын Академийн гишүүн, Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэгийн тэргүүн, Монгол Улсын олон улс судлалын профессор, доктор, НҮБ болон Дэлхийн мэдээлэл судлалын Парламентад Ерөнхий зөвлөх эрхтэй Олон улсын мэдээлэлжүүлэлтийн академийн жинхэнэ гишүүн /академич/

Орчин үеийн хилийн харилцаа бол олон улс хоорондын харилцааны бүрэлдэхүүн хэсэг, тэргүүлэх чиглэлүүдийн нэг хэсэг болж байна. Хилийн харилцаа жилээс жилд өргөжихийн хэрээр эерэг болон сөрөг үр дагаврууд үүсгэж байна.

Өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд Монгол орон улс төр, эдийн засаг, нийгэм хүмүүнлэгийн салбарт бүтцийн өөрчлөлт хийн, дотоодын зах зээл дээрх бараа бүтээгдэхүүний хомсдлыг арилгах, шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад гадаад валют, мөнгө хөрөнгийн ихээхэн шаардлага гарч, олон улсын банк, санхүүгийн байгууллагын тусламж дэмжлэгтэйгээр, макро эдийн засгийн тэнцвэртэй байдлын үндсийг тавих, хувийн хэвшилд тулгуурласан зах зээлийн эдийн засгийн бүтцийг бүрдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах бодлогыг тууштай хэрэгжүүлж ирсэн.

Аймаг нийслэлийн хүн амын өсөлт, бууралтад механик өсөлт нөлөөлж байна.

Нийслэл рүү чиглэсэн хөдөлгөөний урсгал ихсэж Улаанбаатар хот 2007 оны 4 сарын 11-ний өдөр 1 сая дахь иргэнээ бүртгэж дэлхийн сая түүнээс дээш хүн амтай 182 хотын нэг болсон. Гэхдээ агаар ус, хөрсний бохирдол, газрын менежментийн доголдол, экосистемийн эвдрэл зэрэг олон шийдвэрлэх асуудалтай тулгарч байгаа.

Монгол орны хувьд ойрын хөршүүдтэйгээ харилцан ашигтай хамтын ажиллагааг эрх тэгш үндсэн дээр хөгжүүлэх бодлого баримталж байна. Өнөөдөр Монгол Оросын харилцааны үндсэн хэлбэрүүд нь гадаад худалдааг өргөжүүлэх, хамтарсан үйлдвэр байгуулах, хил орчмын худалдаа, шинжлэх ухаан техник, боловсрол, соёл, үйлдвэрлэл, барилга, төрөл бүрийн үйлчилгээ, аялал жуучлалын чиглэлээр хөгжиж байна.

Сүүлийн үед хоёр орны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа бүс нутаг болон хил орчмын түвшинд улам эрчимжиж байна.

Гэвч Монгол Оросын бүх талын уламжлалт хамтын ажиллагааг сэргээхэд манай экспортын уламжлалт бараанд тавьж байгаа төрөл бүрийн тарифийн болон тарифийн бус хязгаарлалт, дотоодын тээврийн өндөр тариф урьдын адил саад учруулсаар байна.

Харин Монгол Хятадын харилцаа,

эдийн засгийн хамтын ажиллагаанд элдэв хориг саад, хязгаарлалт харьцангуй бага байгаа учир хоёр талын хамтын ажиллагаа богино хугацаанд хурдан хөгжиж мал аж ахуй, газар тариалан, аялал жуучлал, уул уурхай, дэд бүтцийн салбарт өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Өнөөдөр Монгол Улсын эдийн засаг 14 үндсэн салбар, 72 дэд салбараас бүрдэж байна.

Монгол Улсын хувьд Зүүн хойд Азийн бүс нутаг чухал ач холбогдолтой хэвээрээ байна. Энэ бүсэд Япон, ОХУ, БНХАУ, БНСУ, БНАСАУ болон Номхон далайн хойд хэсэгт оршдог АНУ, Канад зэрэг улсууд байгаа. Энэ утгаараа ЗХА-н бүс нутаг бол Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, эдийн засаг манай хөгжилд чухал нөлөөтэй. Энд Монгол Улсын худалдааны гол түншүүд, томоохон хөрөнгө оруулагчид, хамгийн том хандивлагч орнууд болон ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улсууд орж байгаа.

Өнөөдөр дэлхий нийтийг хамарсан хоёр аюултай хандлага бий болоод байна.

Нэг дэх нь: ГӨАБ-гений өөрчлөлтийн аюулт бодлого,

Нөгөө нэг нь: ХААРП-цахилгаан соронзон зэвсэг болой. Монголчууд бид генийн өөрчлөлтийн аюулт бодлогод ч, цахилгаан соронзон зэвсэгт ч өртөөд байна.

Сүүлийн жилүүдэд Монгол үхрийн шүлхий өвчин дэгдсэн тухай, шувууны болон гахайн ханиад тархсан тухай, сүү, тарагны найрлага өөрчлөгдсөн тухай яригдаж байгаа. Ийнхүү харийнхны генийн өөрчлөлтийн аюулт бодлогын дүнд үхэр, гахай, үр тариа, жимс ногоо, эрдэнэ шиш, сүү тараг, тахиа, өндөг бий болж байхад Монголын болон Солонгосын үндэсний малыг устгах явдал тэдгээрийн зальт ажиллагааны хэсэг болсон. Монгол Улсад 2010 онд ХААРП-н зуд болж 9 сая мал газарт булагдсаныг санаж байгаа байх. Эдгээр аюул чинь үүсэл угшилтай, санаачлагатай зүйл л дээ. 1948 онд АНУ-ын Төрийн Департаментад Жорж Кеннен тавьсан илтгэлдээ Америкийн эрин зууныг тунхаглахдаа:

"Газрын тосыг хяналтандаа байлгах замаар бусад орнуудыг эрхшээлдээ оруулж болно. Харин хүнсийг хяналтандаа байлгаж дэлхийн бүх хүн амыг эрхшээлдээ оруулж болно" гэсэн байдаг. Үүнийг Монгол оронд өрнөсөн үйл явдалтай уялдуулж үзэх юм бол Монголд тохиолдсон зуд ч ялгаагүй, их гүрнүүдийн цахилгаан соронзон зэвсэг ХААРП-ын зуд бөгөөд Монголчуудын амжиргааны үндэс болсон мал аж ахуйгаас нь салгах гэсэн тэдний далд бодлого юм.

2011 онд дэлхий нийтийн анхаарлыг татсан том үйл явдал Бразил, ОХУ, БНЭУ, БНХАУ, ӨАБНУ зэрэг хүчирхэг таван гүрэн чуулга уулзалт хийж улс төр эдийн засгийн их сөргөлдөөнийг шинэ чиглэлээр өрнүүлэх болсноо даян дэлхийд зарлан тунхагласан. Эдгээр таван гүрэн BRICS-ийг байгуулж түүний гишүүн улс болцгоосон. BRICS нь дэлхийн нийт хүн амын 40 хувийг хамарч дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 18 хувийг үйлдвэрлэж, дэлхийн нийт валютын нөөцийн гуравны нэгийг буюу бараг дөрвөн триллион доллар эзэмшиж байгаа юм.

Ийм ч учраас дээрх таван гүрэн Дэлхийн банк, ОУВС дахь АНУ, Европын 65 жилийн ноёрхлыг төгсгөл болгохоор тохиролцсон. BRICS-ийг Хятад гүрэн цааш нь залуурдах болно. Хятад гүрнээр манлайлуулсан таван гүрний том эвсэл тэмцлийнхээ торгон үзүүрийг АНУ руу, Европын холбоо руу хандууллаа. Ингэж хүн төрөлхтөн, дэлхийн улс орнууд хоёр том тэнхлэгт зааглагдаж эхэллээ. Монголчууд бидний

хувьд ийм том хоёр тэнхлэгийн цаана зөвхөн Орос Хятадын хамтарсан эдийн засгийн далд түрэмгийлэлд гүнзгий автагдсан гэдгийг дэлхий ертөнц мэдэрч байгаа. Дээр нь бас барууны неоколониализмд гүнзгий өртөж хараат замналаар сүйтгэл сүйрлийн гольдирлоор гэлдэрч яваа нь орчин үеийн хилийн харилцааны аюулгүй байдалд хамгийн их эмзэг асуудал болоод байна.

Хятад гүрэн даян дэлхийд байр сууриа Шанхайн хамтын ажиллагааны чиглэлээр бас BRICS-н гольдролоор бэхжүүлж эхлээд байна.

Өнөөгийн Хятад гүрэн далдын том хямралд өртчихөөд, Хятадад гурван чиглэлийн том диспорпорци төлөвшчихөөд байна. Эхний диспорпорци нь нийт хөрөнгө оруулалтын хэмжээ жижиглэн худалдаалах бараа гүйлгээнээс үлэмж давж хальсан, хоёрдох нь Хятад гүрний нийт мөнгөний хэмжээ нь дотоодын нийт бүтээгдэхүүнээсээ бараг хоёр дахин их болсон, гуравдах диспорпорци нь тус оронд ядуу баяны ялгаа асар их болсон. Хятад орны үсрэнгүй хөгжил гэдэгт туйлширч болохгүй л дээ. Хятад гүрнийг бодвол Монгол Улс, бусад орноос зэс, алт, мөнгө, нүүрс, төмрийн хүдэр зөөж улс орноо хөгжүүлэх айхавтар бэрхшээлтэй тулгарч үзээгүй улс л даа. Тэгээд ч зогсохгүй их Монгол Улсаас Хятадууд Манжийн колончлолын "ач буянаар" таван сая кв километр газар нутгийг эд баялагтай нь, хүн амтай нь авч "Хятад гүрэн" гэдэг нэр сүрийг олж авсныг мартаж болохгүй.

Өнөөдөр жинхэнэ коммунист нам Хятад Улсыг удирдаж байгаа юм биш харин жинхэнэ том колоничлогч нар Хятад гүрнийг агдлан барьж залуурдаж байгаа учраас Хятад үндэстэн, бас 55 өөр үндэстэн ястнууд гурван том диспорпорцид өртөж, ялангуяа эрдэс баялгийн асар их хомсдолд нэрвэгдсэн гэдгийг дэлхий дахинаа харсаар байна.

Далд колончлолын шинэ аюул даяаршлын нэрийн дор даян дэлхийг нөмөрч байгаа нь өнөөгийн хилийн харилцаанд заавал анхаарах асуудлын нэг боллоо. ДОХ, цөлжилт дэлхийн дулаарал, хүн, мал амьтны гоц халдварт өвчин, өнөөдөр ядуурлаас илүү аймшигт ур дагаврыг авч ирэх болов. Байдал хурдацтай явгадаж хүн ардын амьдрал, эрүүл мэндэд нэн аюултай болоод байна.

Жишээ хэлье: 2008 онд Өмнөд Солонгост Америкийн үхэр, гахайн махыг чөлөөтэй оруулах шахалтыг АНУ И Ман Бак ерөнхийлөгчид тулгаж бараг , зөвшөөрүүлсэн. 2011 оны өвөл Солонгосын нэг сая гаруй үхэрт үхрийн шүлхий өвчин гарсан гэдэг нэрийн дор газар ухаж гялгар цаасанд боож булсан. Өнөөгийн далд колончлолын шинэ зэвсэг болсон генийн өөрчлөлттэй / ГӨ/ амьтан, ургамлын үрийг Солонгост хүчээр шахахын тулд Солонгосын үндэсний үхэр, хонь болон гахайг устгах зохион байгуулалттай, санаатай үйл ажиллагааг явуулж буй нь энэ болой.

Дэлхийн 2 дугаар дайны дараа АНУ-ыг бүхэлдээ хяналтандаа авсан ах дүү Рокфеллерын хүчирхэг дөрвөн гэр бүл энэ аймшигт төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

2003 онд Багдадыг бөмбөгдөж дуусаагүй байхдаа ГӨАБ төслийг шууд сонгож авсан. Европын улсууд Герман, Франц, Австри энэ төслийг эсэргүүцсэн боловч 2006 онд Дэлхийн худалдааны байгууллага, Европт нэвтрүүлэх ногоон гэрлийг асаасан. Рокфеллерийн гэр бүлүүд АНУ-ын цэрэг тагнуултай нийлж 1990 онд Аргентинаас ажлаа эхэлсэн.

ГӨАБ буюу энэхүү генийн өөрчлөлт дээр суурилсан аймшигт зэвсгийг ашиглан 10, 20 жилийн дотор манай гаригийн хүнсний үйлдвэрлэлийн бүхий л салбарт ноёрхлоо тогтоохоор эрчимтэй ажилласан. Үүний сүйрлийн үр дагаврууд Солонгосын хойг болон

Монгол нутагт мөсөн өвөл, цасан зуд, усан бороо, цасан шуурга, халдварт өвчин шувууны болон гахайн ханиад болж дэлгэрч эхэлсэн. Шувууны болон гахайн ханиад тархсан байдал нь нисдэггүй, явдаггүй замаар сөрж тархсан болохыг Германы лабораториуд, эрдэмтэд баталсан байна. Шувууны болон гахайн ханиад нэрийн дор манай дэлхийн өнцөг булан бүрт ард түмнүүдийн амин зуулгыг устгах ажиллагаа явагдсан. Ногоон цөлжилт хэмээх нь мөн тэдний тарьж буй сүйрлийн үр дүн юм. Рокфеллерийн хүчирхэг бөгөөд тоглоомын гэр бүлүүд дэлхийн бүх банк санхүүгийн байгууллага, бүх алт, эрдэнэс баялгийг хянаж байсан шиг мэдээллийн бүх хэрэгслүүд, тагнуулын байгууллагууд тойруу замаар тэдний тоглоом болж хүн ардын тархийг угаахад зориулагдаж байна.

1986 онд АНУ-ын Цагаан ордонд нэг нууц уулзалт болсныг хожуу хэвлэлээр мэдээлсэн. Учир нь дэд ерөнхийлөгч Буш химийн үйлдвэрлэлийн асар том компани "Монсанто корпорейшн"-ы ноёдтой нууц уулзалт хийсэн явдал байв. Энэ компани АНУ-н бүхий л үеийн засгийн газрууд болон ТТГ-тай нягт хамтын ажиллагаатай явж ирсэн. Энэ компани 1960 онд Вьетнамын өргөн ногоон ширэнгэн ойг устгахад зориулж "Улбар шар агент" хэмээх нэртэй үхрийн гербицид буюу дүнст хэмээх химийн хорыг боловсруулж амжилттай туршсан. Энэ компани дэлхийн олон газар онгон байгалийн ой мод, газар шороо, ургамал амьтныг устгасан аймшигт түүхтэй. Энэ компани залилан мэхлэх, шоудах, шуугиан дэгдээх, далд тэмцэл явуулах, хахуульдан худалдаж авах талаар ихээхэн туршлага хуримтлуулсан ноцтой компани даа. 1988 онд эцэг Буш ерөнхийлөгч болсныхоо дараа энэ компанид онцгой эрх өгч одоо дэлхий даяар дураараа дургиж ГӨАБ зэвсгийг санаснаараа хэрэглэж байгаа. Үүний үр дүнд дэлхийн хүн ард генийн өөрчлөлттэй амьтан ургамал, үр тариа, мах идэж сүү уух боллоо. ГӨАБ-ыг 1992 онд "Байгалийн гаралтай хүнсний нэмэгдлүүд" гэж үзэж ямар ч туршилт судалгаагүйгээр хүнсэнд нэвтрүүлж эхэлсэн. ГӨАБ-тай үхрийн тугал төрөнгүүтээ том үхэр болж, сүү нь ус гол шиг урсах болсон. Мөн бүхий л эм бэлдмэлийг ч ийм аргаар бэлдэх болсон. Солонгосын газарт булагдсан 1 сая хану үхрийн нэг кг мах 30 мянган доллар, 350 кг жинтэй үхэр 10 сая доллар болох жишээтэй.

Монгол Улсад 2010 онд ХААРП-ын зуд болж 9 сая мал газарт булагдсан. Солонгост болсон шиг үйл явдал Монголын хүнсний үхрийн хамгийн шимтэй хэсэг оршдог Сүхбаатар аймагт тахал гарсан нэрийдлээр маш олон Монгол малыг амьдаар нь булсан, гэдэс дотрыг нь гаргалгүй амьдаар нь булснаас болж тэсрэлт гарсан шүү дээ. Тэгвэл Солонгост 2 сая гахай, сор болсон 2 сая Солонгос үхрийг газарт амьдаар нь булсан жигшүүрт үйл явдлыг ердийн үзэгдэл гэж ойлгох уу даа.

2011 оны 4-р сард манай улстай хил залгаа Хятадын Ганьсу мужид олон хүн сүүний хордлого авч 35 хүн эмнэлэгт хүргэгдэж 3 хүүхэд амиа алдсаныг Синьхуа мэдээлсэн. Сүүнд азот хүчлийн давс буюу нитрит хэт их байсны улмаас ийнхүү олон хүн хордлого авчээ. Монголчууд бид сүүнийхээ жилийн хэрэгцээний дөнгөж 30%-ийг өөрсдөө хангадаг үлдсэн 70%-ийг Хятадаас авч байгаа. Гэтэл Говь-Алтай Баянхонгортой залгаа Ганьсу мужид аюул гамшиг дэгдэж байв. Нитрит, натрийг сүү, хиамны өнгө зүсийг сайжруулах, хадгалах хугацааг нь уртасгахад хүнсний үйлдвэрүүд өргөн ашигладаг байна. Түүнийг хэт ихдүүлж ашигласны улмаас ийнхүү олныг хамарсан гамшиг Ганьсу мужийн Пинлян хотод илэрчээ.

Нитрит нь цусны улаан цогцост нөлөөлж хүчилтөрөгчөөр цус хангагдах боломжгүй болгож үхэлд хүргэдэг аюултай аж.

2008 онд Хятадад 300 мянган гаруй хүн меламинтай сүүний хордлого авч, цөөнгүй хүүхэд эндсэн. Сүүгээ өтгөрүүлж арвижуулах гэж меламин нэмж гэмт хэрэг үйлдсэн цөөнгүй хүмүүсийг цаазалсан гэж Хятадын хэвлэлээр мэдээлсэн. Хятад Улс сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нийт 1176 компаниас 553-г нь хаасан гэж Синьхуа зарлаж л байсан. Ийнхүү сүүний үйлдвэрлүүдийг хаасантай холбоотойгоор эздүүд нь нөөцөд байгаа чанар муутай хэдэн сая тн хуурай сүү буюу түүхий эдээ гуравдагч орнууд руу гаргаж эхэлсэн тухай мэдээлж байсан.

Монгол Улс сүүний импортод жил бүр 25.6 сая ам доллар 32 тэрбум төгрөг зарцуулдаг тооцоо бий. Жижиг том гэлтгүй манай хэдэн үйлдвэрүүд бүгд л Хятад хуурай сүүг найруулаад, гоё сайхнаар савлаад зарж байгаа нь нууц биш.

Гэхдээ цөөхөн Монголчуудаа илт мэхлэн Монгол үнээний цэвэр сүү гэж рекламдсан. Монголын 30 гаруй тэрбум төгрөгөөр орж ирж буй энэ хуурай сүү нь сайтар нягталбал "Цагаан хор" байж мэдэхээр урд хөршид харанга дэлдэж буй учир ҮАБЗ, Гааль, МХЕГ, Ариун цэвэр, хорио цээрийн албад мэт 80-аад байгууллага нэн яаралтай шалгаж нягтлах цаг болсон. Хятадаас ирсэн хуурай сүүнд 2009 онд шалгалт хийхэд меламин илэрсэн тухай мэдээлж байсан ч манай сүүний үйлдвэрүүд хав дарж нуугаад л өнгөрсөн.

Авилгад автамтгай ариун цэврийн албад үүний мөрөөр дорвитой арга хэмжээ аваагүй л өдий хүрсэн. Эдүүгээ харанга дэлдээд байгаа Ганьсу мужтай ойр хилийн боомтуудаар орж ирж буй сүүн бүтээгдэхүүнийг онцгойлон үзэж баруун аймгуудын хилийн боомтуудад хяналт шалгалтаа эрчимжүүлээч гэж хүсмээр байна.

2008-2010 онд Хятадад илэрсэн меламинтай хуурай сүүг устгалд оруулалгүй Монголчууд оруулж ирэн урд онуудын меламин гэгч хорон дээр нэмэгдээд нитриттэй сүүг "Монгол үнээний сүү" гэсэн эрээн хайрцагт нь хууртаад бид уугаад хордоод байгаа юм биш биз гэдгийг хяналт шалгалтын холбогдох байгууллагуудад сануулах гэсэн юм.

Даяаршлын үеийн хилийн харилцаанд анхаарах асуудлын нэг нь өнөөгийн Монгол орны эрдэс баялгийг тойрсон геополитикийн хүрээнд газрын гүний асуудал юм. Манай улсад газрын гүний хилийг огт хөндөж ярихгүй байгаа. Газрын гүний хил хамгаалалт, хяналт, шалгалтгүй байсаар л байна. Энэ талаар мэргэжлийн холбогдох байгууллагууд огт санаа тавихгүй өдий хүрсэн. Манай орны ашигт малтмалын ихэнх ордууд хилийн бүс, зарим нь хил дээр байгаа. Эдгээр ордуудыг яаж ашиглаж байгааг мэдэх ч үгүй, мэдэхийг ч хүсэхгүй байна. Газрын гүний хилийг шалгадаг тогтолцоо, техник, түүний хариуцдаг эзэн ч алга байна.

Нэг жишээ хэлэхэд дэлхийд байдаг хоёрхон өрөмний нэгийг Таван толгойд байрлуулсан тухай Түдэв гуай "Дал" сониндоо мэдээлсэн. Бүх өрөм газрыг дээрээс нь доош өрөмдөж цоолдог бол энэ өрөм газрыг доош нь ухаад бас хажуу тийш нь яргаж ухдаг өрөм юм гэсэн. Энэ өрөм хэний мэдэлд, хэн ажиллуулж, юу илрүүлж байгаа талаар ямар ч мэдээлэл байхгүй.

Монгол оронд геологийн судалгаа хийж эхэлснээс хойших хугацаанд үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий ашигт малтмалын олон тооны орд, нээн илрүүлж, нэлээд хэсгийг нь олборлож аж ахуйн эргэлтэнд оруулсаар ирсэн бөгөөд мөн нэлээд хэсгийг хувийн хэвшлийнхэн лицензээр ээзэмшиж аж ахуйн эргэлтэнд

оруулахгүй дарагдуулан, банкны зээл авах, цааш нь бусдад арилжих зэргээр улсын эдийн засагт өгөөжгүй үйл ажиллагаа явуулсаар байгаа. 1990 оноос хойш үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий томоохон орд объект үндсэндээ шинээр нээгдээгүй гэдэг. Энэ нь нутаг дэвсгэрийн хэмжээнд гадаргуугаас харагдах ямар нэг шинж тэмдгээрээ хялбархан олж илрүүлж болох тийм объект эрс ховордсоныг харуулахын зэрэгцээ геологийн судалгаанд гүний судалгааны арга тухайлбал геофизикийн цогц судалгааны арга, аргачлалуудыг үндсэндээ орхигдуулж ирсэнтэй холбоотой. Эрдэс баялгийн гүн дэх хэлбэр, хэмжээ байршлыг тогтоохын тулд гүний судалгааны аргачлалуудыг цогцоор хэрэглэх шаардлагатай байна. Монгол орны цаашдын хөгжил, эдийн засгийн өсөлтөд ихээхэн түлхэц өгөх эрдэс баялгийг нээн илрүүлэх, геологийн салбарт алс хэтийг харсан, эх орныхоо онцпогг тохирсон цэгцтэй бодлого үгүйлэгдсээр байна. Геологийн судалгааг иж бүрэн системтэй, стандартын дагуу, мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх, хянан зохицуулах тогтолцоог оновчтой хийх нь зүйтэй гзж үзэж байна.

Миний энд хөндөж тавьсан асуудлууд бол зөвхөн судлаач миний хувийн дүгнэлт, бодол гэдгийг хэлэхийг хүсч байна. Анхаарч уншсан та нарт баярласнаа илэрхийлэхийн ялдамд алтан цагаас тань хумсалсандаа хүлцэл өчие.

ЛИМОЛОГИ НЬ ШИНЖЛЭХ УХААНЫ БИЕ ДААСАН САЛБАР МӨН



А.Муратхан

Монголын Хил Судлалын Академийн тэргүүлэгч гишүүн, доктор, профессор

Монгол Улсынхаа хилийг халдашгүй дархан байлгахын тулд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт болж буй үзэгдэл, үйл явц, тэдгээрийн өрнөлтийн төлөв байдалд судалгаа хийж, дүгнэлт гарган, цаашид төр, засаг, хил хамгаалах байгууллагаас энэ чиглэлээр баримтлах бодлогыг тодорхойлох, тодотгох замаар улсын хилийн хамгаалалтын арга, хэлбэрийг сонгож, түүнд тохирсон арга хэмжээг авах нь бидний үндсэн үүрэг билээ.

Үүнийг тодорхой шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан хэрэгжүүлбэл бодит үр дүнд хүрдгийг тэмдэглээд хилийн шинжлэх ухаан буюу лимологийн үүсэл хөгжил, хилийн үүрэг, хэв шинжийн талаарх өгүүллийг толилуулж байна.

Лимологи, эсвэл хилийн тухай шинжлэх ухаан (Lines-хил, logos-сургаал, ухаан эсвэл шинжлэх ухаан / түүний салбар/ гэсэн грек үгнээс гаралтай) нь газарзүй, түүх, улс төр судлал, социологи, онол улсын харилцаа зэрэг олон тооны шинжлэх ухааны сонирхол нийцсэн шинжилгээ судалгааны талбар юм.

Лимологи нь хил орчмын нутаг дэвсгэр, түүнд болж буй үзэгдэл, үйл ажиллагаа, түүнтэй холбоотой хууль эрх зүйн орчинг судалдаг бие даасан салбар шинжлэх ухаан мөн. Шижлэх ухааны энэхүү салбар нь XIX зууны төгсгөлд бий болсон бөгөөд АНУ, Европын томоохон улс орнуудад нэлээд дэлгэрсэн байна.

Хилтэй холбоо бүхий сүүлийн үеийн судалгаа, шинжилгээний ажилд Border (Boundary), Studies гэдэг ойлголт ихээхэн хэрэглэгдэх болсон. Энэхүү нэр томьёо нь ломологи гэсэн ойлголттой ижил төстэй боловч улс төрийн газарзүй, түүх, улс төр судлал, эдийн засаг, социологи, соёл судлал, экологи зэрэг шинжлэх ухааны салбаруудад хийгдэх судалгаануудад түлхүү ашиглах болсноороо дээрхээс арай ялгаатай юм.

Харин хил судлал (*погранология*) нь тухайн улсын хилийн талаар баримтлах бодлогыг шинжлэх ухаанаар хангах, түүнээс эхний ээлжинд хил хамгаалах субъектүүдийн хилийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг тогтоох талаарх салбар шинжлэх ухаан мөн.

Хил судлалын салбар шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл нь:

- хилийн аюулгүй байдлыг хангахад шийдвэрлэх асуудлууд;
- хил хамгаалалтын онол ба практик;

• хилийн орон зайд үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, түүнийг хэрэгжүүлэхэд геополитикийн нөхцөл байдлын нөлөөлөл;

• хилийн асуудлыг энхийн аргаар шийдвэрлэх арга зам;

• нийгэм эдийн засаг, цэргийн болон хилтэй холбоо бүхий асуудлыг судлах;

• хилийн орон зайд болж буй үзэгдэл, үйл явцад шилжилт хөдөлгөөн, суурьшилтын үзүүлэх нөлөөлөл г.м.

В.П.Семенов-Тян-Шань "Бүс ба улс орон" нэртэй 1928 онд хэвлэгдсэн номондоо "Хилийг газарзүйн үзэгдлүүдийг халах тусгай хэрэгсэл" гэж тодорхойлсноор ОХУ-д лимологи буюу хил шинжлэлийн эхлэл нь тавигдсан гэж үздэг байна. Хил нь газарзүйн нэг үзэгдлийг нөгөөгөөр төгс хувирган халахыг илэрхийлдэг. Хэрэв энэхүү хувирган халах явц маш түргэн явагдвал (улсын болон засаг захиргааны хил болон хурдан өөрчлөгдөх) хил нь *шугаман хэлбэртэй* байна. Харин хувиргах, өөрчлөх явц удаан үргэлжлэвэл хил нь *зурвас хэлбэртэй* байх болно.

Тус шинжлэх ухааны салбарын үүсэл, хөгжил нь хүний нийгмийн түүхтэй шууд холбоотой, ялангуяа газар нутгийн талаар явагдсан дайн, тэмцлийн гол шалтаг нь хил байв, одоо ч байсаар байна. Тэмцлийн үр дүнд эзэлж авсан эсвэл хэлэлцээрийн журмаар өөрийн эзэмшлийн болгосон газар нутгийн хилийг албан ёсоор хууль эрх зүйн хүрээнд тогтоох шаардлагатай байв. Тиймээс эхний ээлжинд мэргэжлийн газарзүйч нарт ханддаг байжээ. Үүнээс үндэслээд лимологи нь газар зүйгээс үүдэлтэй гэж үздэг байна.

Дээрх шалтгааны улмаас зөвхөн хилийн хаагуур явахыг тодорхойлон бичих хэлбэртэй байж, хийгдсэн судалгаа шинжилгээг онолын үүднээс учрыг нь олж мэдэх явдал ихээхэн дутагдалтай байгаа нь саяхан хүртэл мэдрэгдэж ирсэн юм. Гэлээ ч гэсэн хилийг судлахын тулд хэд хэдэн удаа онолын суурь тавих алхмыг амжилттай хийсэн байдаг. Газарзүйн хилийг судалж мэдэхийн тулд дараах уламжлалт хандлагыг ашиглаж иржээ. Үүнд:

• Түүх-газрын зургийн;

• Ангиллын;

• Үйл ажиллагааны;

• Газарзүй- улс төр судлалын;

Түүх –газрын зургийн судалгааны хандлагын үндэсэд дараах зарчмууд ордог:

• түүхийн үүднээс судалгаа хийх зарчим (хилийн тогтвортой байдалд нь үнэлгээ өгөхийн тулд түүний бүрэлдэн тогтсон түүхийг судлах);

• төрийн байгуулалт ба хилийн үүрэг зориулалт хоорондын, улс төрийн дэглэм ба улсын гадаад бодлого хооронд зохицуулах зарчим;

• хөрш зэргэлдээ улсын хүчин чадлаас улсын хилийн дэглэм ба хилийн үйл ажиллагаа хамаарах зарчим;

• "байгалийн хил"-ийг давшгүй зарчим (өөрөөр хэлбэл хил нь байгалийн саад бэрхшээл, уулын нуруу, гол мөрөн, далай тэнгис, элсэн цөлөөр тусгаарлагдсан);

• тухайн нутаг дэвсгэрт амьдардаг угсаатны бүрэлдэхүүнийг судлах, дүр зургийг гаргах, ард иргэдийн хуучныг санагалзсан үзэл, соёлын онцлог, байгалийн баялаг, хил орчимд аж ахуй эрхлэх онцлог зэргийг харгалзах зарчим. Дээрх хандлагын томоохон төлөөлөгчидэд Ж.Аналь, Дж.Минги, П.Салинс нар ордог байна.

Ангилан судлах хандлага нь хилийг төрөл бүрийн шинжээр нь ангилахаас гадна хилийн гүйцэтгэх үүргийг [заглан халхлах (*барьерность*), залган дамжуулах (*контактность*), шүүн тунгаах (*фильтрующая*), тусгал

эсвэл толь байх (*отражательность*), жишин харьцуулах (*сопоставляющая*)] тодорхой авч үздэг байна. Түүнээс гадна хилийн гүйцэтгэх үндсэн үүрэг болох зааглан халхлах, залган дамжуулах хоёрын тэнцвэртэй байдалд нь нөлөөлөх хүчин зүйлүүдийг ялган салгах асуудалд нэлээд ач холбогдол өгдөг. Тийм хүчин зүйлүүдэд:

- Улсын нутаг дэвсгэрийн өргөн уудам, авсаархан байдал;
- Хилээс холдох дундаж зай хэмжээ;
- Хил орчмын нутаг дэвсгэрийн газар зүйн онцлог ;
- Байгалийн нөөц баялгаар хангагдсан байдал зэрэг орно.

Харин үүсгэгдмэл хүчин зүйлүүдэд:

- Эдийн засгийн хөгжлийн төвшин;
- Аж ахуйн салбарын бүтэц, тэдгээрийн бие биенээ харилцан нөхөх чадвар;
- Хүн амын угсаатны бүтэц, тэдгээрийн нийгэм-сэтгэл зүйн онцлог.

Энэхүү хандлагын чиглэлээр францын нэрт дипломатч, газар зүйч М.Фуше олон жил судалгаа хийсэн байдаг.

Үйл ажиллагааны судалгааны хандлага нь үндсэндээ хоёрдугаар дайны дараа хөгжсөн түүхтэй. Хил шинжлэлээр дэлхийд танигдсан нэрт судлаач, Австралийн газарзүйч Дж.Прескотт энэ хандлагын чиглэлээр ихээхэн судалгаа шинжилгээний ажил хийсэн бөгөөд хилийн зөвхөн газарзүйн төрх байдлыг судлах биш харин түүний бүх элементүүд хилд яаж нөлөөлдгийг давхар судлах ёстой гэдэг байр суурьтай байв.

Английн улс төр судлаач, газарзүйч Дж.Хауз өөрийн амьдралын ихэнх хугацааг Америк-Мексикийн хилийг судлахад зориулсан бөгөөд олон жилийн судалгааныхаа үндсэн дээр хил орчмын харилцан ажиллагааны арга зүйн бүдүүвчийг боловсруулснаас гадна, хил дамнасан цуваа, урсгалын ангиллыг санал болгосон байна.

Газарзүй-улс төр судлалын хандлага нь голдуу олон улсын харилцааны байдалд хил нь яаж нөлөөлдгийг судалдаг байна. Энэ хандлагыг барин судалгаа хийсэн төлөөлөгчид нь Америкийн улс төр судлаач Дж.Герца ба П.Диля нар юм. Тэд 1815 оноос 1990 он хүртэлх хугацаанд болж байсан 870 гаруй улс төрийн сөргөлдөөний талаар бүх мэдээллийг цуглуулан газар нутгийн төлөөх маргааныг хязгаарлах, бий болсон давтамжийг тайлбарлаж болох, тэдгээрийг мөн бууруулж болох загварыг байгуулсан байдаг.

Дээрх судлаачдын нутаг нэгт эрдэмтэд Г.Старр, Б.Мост нар "...улс орон *олон хөрштэй* хил залгах тусам төдий чинээ дайнд татагдах болно" гэсэн зарчмын дүгнэлтийг хийсэн байна.

Уламжлал болсон дээрх хандлагын хүрээнд судлаачдын хийсэн дүгнэлтүүд тухайн үед маш хэрэгтэй, цаг үед нь тохирч байжээ. Гэвч дээр бидний үзсэн судалгааны хандлагууд нь нутаг дэвсгэр ба хүн амын хоорондох уялдаа холбоо, улс орны мөн чанар ба хилийн төлөв байдлын хоорондох харилцан шүтэлцээг тооцож үзээгүй юм. Үүнээс гадна улсын болон дотоодын засаг захиргааны, улс төрийн ба соёлын хил хязгаар зэргийг нэгдмэл, тогтолцоотой байх ёстойг мөн л тооцоогүй байна.

Тийм учир 1980-аад оноос эхлэн хилийн ийм чухал үзэгдлүүдийг судлах шинэ онол шаардлагатай болов.

ОХУ-ын эдийн засаг, газарзүйн нэрт эрдэмтэн, газарзүйн ухааны доктор В.А.Колосов хил шинжлэлийн онолын шинэ хандлагын ангиллыг боловсруулан санал болгосон байна. Бид уг ангиллыг үндсэн онцлог шинж, холбогдох зохиогч нарын хамт доор хүснэгтлэн үзүүлэв.

В.А.Колосовын хил судлах шинэ (шинэчилэхээс өмнөх) хандлагын ангилал

Зонхилах арга ба хандлага	1990-оны үеийн мөн чанар	Үндсэн үзэл баримтлал ба хүрсэн амжилт	Голлох зохиогчид	Практик хэрэглээ
а. "Энхийн тогтолцоотой-ижил байх" хандлага	Хилийг судлахдаа нутаг дэвсгэрийн хувьслын өөрчлөлттэй ижил байх, хилийн уламжлагдан ирсэн байдлын хоорондын хамаарлын төвшинтэй харьцуулан үзэх	Хилийн болон нутаг дэвсгэрийн уламжлагдан ирсэн шатлан захирах харьцааны загвар	А.Пааси (Финлянд), Д.Ньюмен (Израиль), Дж.Олоклин (АНУ), П.Тейлор (Их британи), Т.Лунден (Швеци), Дж.Уотерберри, Дж.Экклсон (Их британи)	Хил орчмын маргааныг үндэсний болон төрийн байгуулалтын хүрээнд шийдвэрлэхэд хилийн асуудлыг ашиглах
б.Геополитикийн хандлага	Даяаршлын болон интеграцчлалын үйл явц улс төрийн хилд үзүүлэх нөлөөлөл	Дараах үйл ажиллагаануудад ойлголт өгөх: -газар нутгаа бататгах *(De territoriализации)* -Газар нутгаа шинэчилэх- *(ретерриториализации)* -Улс төрийн болон засаг захиргааны хилийн нэгдмэл үүргийн хувиралт		Хилийн талаар баримтлах бодлого болон хил орчмын ажиллагааны зарчим боловсруулах, хил дамнасан бүс нутгийн байгууллага байгуулах
в. Хил бол нийтийн үзэгдэл	Хилийг нийгмийн бүтэц талаас нь судлах, хил нь нийгмийн харилцааны өнөөгийн болон өнгөрсөн байдлыг харуулдаг толь мөн байх, улс төрийн маргаанд хилийн үүрэг нийгмийн бэлэг тэмдэг, утга учир байх	Хилийн асуудлыг судлахад угсаатны, үндэсний болон газар нутгийн хувьд ижил байх хандлага		
г."улс төр, ойлгох (ухамсарлах), практик (туршлага)" "УОП"-хандлага	Хилийн нэвтрэх чанарыг тодорхойлдог улс төр ба түүнийг ойлгодог хүмүүс, түүнчлэн хилтэй хобоотой практик үйл ажиллагааны төрийн хоорондын холбоог судлах	Улс төр ба хилийн үүргийн зохицуулалтын хоорондын харилцаанд дүн шинжилгээ хийх, түүнийг ойлгох, хүмүүсийн ижил төстэй байдал, нутаг дэвсгэрийн хүрээний үйл ажиллагаа бүс нутгийн хил дамнасан ажиллагааг удирдахад нөлөөлөх	Х.Ван Хотум О.Крамш (Нидерланд), Дж.Скотт (Герман)	Хил орчмын харилцааг зохицуулах, хил дамнасан бүс нутгийг удирдах, олон улсын дүрвэгсэдийг зохицуулах, бүс нутгийн бодлого. г.м
д. Байгалийн газарзүйн	Улс төрийн болон байгалийн хилийн хоорондын харилцааг судлах	Улс төрийн болон байгалийн хилийг нэгдмэл тогтолцоо талаас нь дүн шинжилгээ хийх, хил дамнасан хөдөлгөөнийг удирдах арга замыг тодорхойлох	О.Янг, А.Уэстинг, Г.Уайт (АНУ), Н.Килот (Израиль), С.Долби (Канад), Дж.Блейк (Их британи), Н.Ф.Глазовский, С.П.Горшков, Л.М.Корытный (ОХУ)	Байгаль хамгааллын талаар бүх нийтийг хамарсан болон бүс нутгийн асуудлыг шийдэх, олон улсын гол мөрний сав газрын асуудлыг удирдах

Энэхүү шинэ хандлага нь XX зууны сүүлийн арваад жилд мухардалд ороод байсан судалгааны арга зүйд зүй ёсны хариу болов.

Мэдээж хэрэг хуримтлагдсан маш олон асуудлыг шийдэх зорилт тавиагүй байна. Харин шинэ хандлагын гол үр дүн нь судалгаа шинжилгээ хийх хүрээг өргөтгөсөн, анхаарлаа хандуулах ёстой байсан уламжлалт газарзүйн лимологийн, заавал судлах ёстой, орхигдуулсан зүйлийг үүнд хамруулан оруулсанд оршино.

Тиймээс лимологи нь хоёр зууны зааг дээр судалгааны олон төрлийн арга зүйг ашигладаг, шинжлэх ухаан жинхэнэ нийлмэл салбар болж чадсан юм.

(үргэлжлэл дараагийн дугаарт)

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

ХӨРШ ЗЭРГЭЛДЭЭХ УЛСУУДЫН ХИЛИЙН ХАРИЛЦААНЫ ЗАГВАР, ГАДААДЫН ЖИШЭЭН ДЭЭР

ГОЛУНОВ СЕРГЕЙ ВАЛЕРЬЕВИЧ

Мэдээлэлжүүлэлтийн Олон Улсын Академийн академич, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор

Хил болон түүний урт, тэндэхийн газар орон, хөдөлгөөний эрчим, хил орчмын нийгэм-эдийн засаг, соёлын хэмжээ, аюулгүй байдалд үзүүлэх сорилт зэрэг өвөрмөц онцлогуудаар төрийн хилийн бодлого тодорхойлогддог. Аливаа загварыг Оросын хөрсөн дээр автоматаар буулгах нь зохистой ч юм уу, үгүй ч юм уу. Ямартай ч, ийм туршлагуудыг мэдэж байх нь төрийн хилийн бодлого боловсруулахад нэмэр болох нь дамжиггүй. Хилийн аюулгүй байдлаа хангахын зэрэгцээ, улам бүр эрчимжсээр байгаа хил дамжсан хөдөлгөөний урсгалыг зөв зохицуулах асуудал олонх улсуудын хувьд тулгамдсан асуудал болоод байна.

Сүүлийн арваад жилд улс төрчид хийгээд шинжээчид хилийн аюулгүй байдлын янз бүрийн хүчин зүйлүүдийг ихээхэн сонирхох болсон нь тохиолдлын хэрэг биш юм. Гэхдээ эдгээр нь онолын шинжилгээ, баталгаа, нотолгоо багатай, гарсан бүтээлүүдийн тоо харьцангуй цөөхөн, салангид асуудлуудыг хөндсөн байдалтай байна. Хил судлал (<<border studies>>)-ын мэргэжилтнүүд ч, янз бүрийн улс орнуудын хилийн аюулгүй байдлыг хангах бодлогын харьцуулсан шинжилгээнд бага анхаарч байна. Хятад, Иран бусад улсуудын туршлагыг судлах гэхлээр хэлний бэрхшээл, бас бус хүчин зүйлүүд мэдээлэл цуглуулахад бэрхшээл учруулдгаас ийм бүтээлүүдийн тоо нэмэгдэхгүй байна.

Хилийн аюулгүй байдлаа хангах хүрээнд тэргүүн туршлага хуримтлуулсан улсуудыг бид тэр бүр хамруулж, нэг бүрчлэн судлах гээгүй юм. Энэ үгүүллээрээ бид, бие биеэс <<тусгаарлах>>, улсын хилийн хамтарсан хамгаалалтын тогтолцоо бүрдүүлэх, дотоодын заагуудаа гадагш <<гаргаж>> хилийн нэгдмэл орон зай үүсгэх гэх мэтээр санаачлагч-орнуудын зэргэлдээх улсуудтайгаа авч хэрэгжүүлж байгаа харилцан ажиллагааны үндсэн загваруудыг задлан шинжлэх юм. Үгүүллийн төгсгөлийн хэсэгт, эдгээр загваруудаас Оросын хилийн бодлогод ашиглах боломжид шинжилгээ хийв.

ХААЛТ БОСГОХ. <<ХИЛИЙН ХАНА>>

Аливаа улс дангаараа хилээ бэхэлж, хилийн хана, бусад хаалт, саад байгуулахад зэргэлдээх улсын дайсагнасан юмуу сул дорой байдал, түншийн хувьд эдийн засаг, улс төрийн ач холбогдол багатай тал, хилийн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд өргөн хүрээтэй хамтран ажиллахад бэлэн бус байгаа зэрэг түлхэц болдог байна. Ийм байгууламжууд маш өндөр өртөгтэй босч, хилийн дэд бүтцийн арчилгаанд их зардал шаарддагаас гадна, зэргэлдээх улстайгаа хилийн харилцаагаа муутгахад хүргэдгээс энэ арга хэмжээ үр дүнтэй биш. Хана, хаалт босгож халхлахгүй бол, учрах хохирлоосоо гарах зардал нь их биш тэр тохиолдолд л ийм арга хэмжээ авдаг аж. Энэ арга хэмжээг хууль бус цагаачид болон террористууд орж ирэх, зэвсэгт халдлага үйлдэгдэхээс

сэргийлэх зорилгоор авч хэрэгжүүлдэг.

Хэн хэнийхээ халдлага довтолгооноос сэргийлж, хоёр талаасаа бэхэлсэн, дэлхий дээр хамгийн хатуу чанд хамгаалалттай хил бол, 2 сая орчим цэргийн албан хаагчид нэг дор цугларсан өмнөд, хойт Солонгосыг заглан 248 км үргэлжилсэн хил юм. Хилийн бүсэд тус бүр нэг тосгон байх бөгөөд хамтын аюулгүй байдлын район Панмынчжоноор дамжуулан хоёр талын харилцаагаа зохицуулдаг байна. 1974-1990 онд хойд Солонгосын цэргийн албан хаагчид дөрвөн ч удаа газар доогуур хонгил ухаж хил нэвтрэхийг оролзсоны дотор, нэг хонгилоор нь төмөр зам тавьж, цахилгаан татсан байжээ.

Энэ бүх оролдлогуудыг өмнөд Солонгосын тал [Korea Demilitarized Zone Incidents 2003] амжилттай таслан зогсоож байв. Одоо болтол хоёр Солонгосын хоорондын хил хяналтгүй халдах аливаа оролдлогод нэвтэршгүй саад хэвээрээ л байна. 1990-ээд оноос аваад 2000 оны эхэн хүртэл хилийн хаалт, хашаа барьж байгуулах болсон бас нэгэн шалтгаан бол террористуудын халдлагаас хамгаалах явдал байсан юм. Хууль ёсны болон хууль бус сувгаар ганц нэг террористыг нэвтрүүлэхгүй байх тийм боломж бараг байхгүй болохоор зэргэлдээ улсын нутаг дэвсгэрээс үе үе хийгдэх дайралтаас хамгаалж хаалт, саад байгуулж эхэлсэн байна.

Энд Египет, Палестинтай хиллэдэг Израилийн, Энэтхэг, Пакистан хоёрын хилийн асуудал эн түрүүнд яригдана. Хилийн хана барьж байгуулах ажил, алан хядагчдын идэвхтэй тэмцэл, зэргэлдээх улсуудын засаг, захиргааны эсэргүүцэл, Израилийн хувьд Палестины хил орчим оршин суугчид, олон улсын нийгэмлэг [2]-ийн шахалтаас болж 2000-аад оны [1] эхний арван жил хүртэл сунжирсан юм. Саад байгуулагдаж дууссанаар террорист халдлагын тоо мэдэгдэхүйц хэмжээгээр буурав. Энэтхэгийн цэргийнхний тооцоолсноор Пакистаны хилийн хэсгээр гарч байсан террорист халдлагын тоо 80 хувь [Gilani 2005] буурсан бол, 1994-2004 онд Израильд ердөө л ганц удаа (анх эхэлж саад байгуулагдсан Газын зурваст амьдарч байсан хүн) халдлага гарсан байна.

Гол нь, Энэтхэг, Израилийн саадын системүүд, хил зөрчигчдийг саатуулах биш шууд устгах зориулалттай төхөөрөмжлөгдсөн байдаг. Эдгээр саадууд, хянах төхөөрөмж, мэдрэгч элементүүдээр төхөөрөмжлөгдсөний зэрэгцээ, цахилгаанжуулагдаж, минжүүлэгдсэн. Израйль хилчиддээ шөнийн цагаар хил зөрчигчдийг урьдчилан анхааруулахгүйгээр буудах эрх олгосон нь олон хүний аминд хүрсний дотор, магадгүй юм тэр дотроо Израильд очиж ажил олохоор явж байсан хүмүүс ч бас өртсөн л байх. Гэвч ийнхүү, хилийн хана төхөөрөмжлөгдсөнөөр хил дамнасан терроризмын асуудал бүрэн шийдвэрлэгдэж чадсангүй. Террористууд хилийн тааруухан хамгаалалттай хэсгээр нэвтрэх оролдлого хийгээд зогсохгүй, Энэтхэг, Израильд илээр очиж, дайсны нутаг дэвсгэрийг тийрэлтэт пуужингаар харвах, ханан доогуур хонгил ухах аргуудыг хэрэглэж байна.

2006 оны 7 дугаар сард, Газын зурвасын салан тусгаарлагчид тийм хонгилоор нэвтэрч ороод, Израилийн цэргийн харуулынхныг гэнэт довтолж, хоёр цэргийг устган, капрал Г.Шалитаг олзлон авчээ. Эндээс үзвэл хилийн саадууд террористуудын боломжийг хязгаарладаг ч, таслан зогсоож чаддаггүй нь харагдана. Олонх улсууд, юун түрүүнд олон тооны хүмүүс хяналтгүй цагаачилж орохоос сэргийлж, хил дээрээ саад, хаалт төхөөрөмжилж байна. Чухам энэ зорилгоор Америк,

Мексиктэй, Энэтхэг, Бангладеш, Бирм хоёртой, Саудын Араб, Ирак, Иементэй, Ботсван, Зимбабветэй, Испани хуурай газраар хиллэдэг хэсгээрээ Мароккотой болон Скута, Мелилья анклавуудтай хил заагаа хаалт, саадаар төхөөрөмжилсөн байдаг.

Бараг бүх (сүүлчийнхээс нь бусад) тохиолдолд хилийн аль их зөрчилтэй хэсэгт саад төхөөрөмжилснийг харж болно. Олон тооны хүмүүсийн хууль бус цагаачлалаас хамгаалсан хилийн саадууд (өндрөөрөө хэд хэдэн метр, хоёр, гурван давхар хашаа, саадтай зурвас, мэдрэгчүүд, хяналтын камерууд г.м.)-ын гаднын дайсан, террорист этгээдүүдээс хамгаалж босгосон хашаанаас ялгаатай нь, хил зөрчигчдийг шууд устгах зориулалтгүй, тэдгээрийг саатуулах, тогтоон барих зориулалттай төхөөрөмжлөгддөгөөрөө үлэмж хүнлэг гэж хэлж болно. Үүний зэрэгцээ, дээр дурдагдсан олонх улсуудын хооронд хилийн харилцаа [3] ихээхэн эрчимтэй явагддагаас цагаачлах сонирхолтой хүмүүс хүссэн орондоо хууль ёсоор ороод очих бололцоотой юм. Хилийн саадуудыг хууль бус цагаачлалын эсрэг ашиглах нь төдий л ашигтай бус.

Тэгээд ч 1980-аад онд Дж.Бхагватти Энэтхэгийн засгийн газраас гаргасан, Бангладештэй хиллэдэг хил дээрээ давхар хашаа барих санаачлагыг олон түмний нүдэн дээр [Andreas 1999: 230-ыг үз] <<юу ч хийхгүй, тэгсэн атлаа хийсэн болж харагдах гэсэн явуургүй арга>> гэсэн юм. Хил зөрчигчдийн олонх зэргэлдээ улсдаа очиж ажил олж ядуу тарчиг амьдралаас ангижрахын тулд эрх чөлөөгөө хязгаарлуулах байтугай, амь насаа алдахыг ч юман чинээ боддоггүй байна. Хууль бус цагаачлагчдыг хүлээн авч буй улсын нь хорих байгууллагуудын хүч чадал олон тооны хүмүүсийг хорьж хүч хүрдэггүй болохоор тэдгээрийг суллад тавьчихдагаас тэд нар хашрахгүй хил зөрчих оролдлогоо хийсээр л байдаг аж. Хууль бус цагаачид хашаа, хаалт бариагүй хэсгээр гарахын зэрэгцээ саадуудыг давах, ажилгүй болгох, нүхэн гарц гаргах зэргээр хил давдаг байна.

Хил зөрчигчдийн хувьд ашиглаж болох нэг боломж байгаа нь, Энэтхэг-Бангладешийн хил [Lakshman] гээд бас бус хэсгүүдээр газар аваад байгаа хилчдийг хахуульдах явдал юм. Хэт улаан туяаны болоод газар хөдлөлийн датчикууд, хянах камер (Америк-Мексикийн хил дээр 1970-аад оноос ашиглагдаж байгаа) ашиглах, агаарын эргүүл хийх аль аль нь хүсэн хүлээсэн үр дүнд хүрсэнгүй. Албан ёсны мэдээгээр америкийн хилчид, 2000-аад оны эхний 10 жилд нийт хил зөрчигчдийн [A Line in the Sand 2005: 3] 10 хувиас, гуравны нэгийг л саатуулсан байдаг. Иргэд нь тавьсан саадуудыг давах гэж аргаа бараад байгаа донор орнууд, хана, хаалт босгоод байгаа улсуудтай хууль бус цагаачлалыг зогсооход хамтран ажиллах талаар санаа зовдоггүй атлаа, хил зөрчих гэсэн хүмүүсийн амь насанд аюул занал учруулж байгаа авсан арга хэмжээнийх нь талаар айхтар ширүүн шүүмжлэл өрнүүлдэг.

Бидний авч үзсэн жишээн дотроос, хамгийн урт удаан үргэлжилж буй Америк, Мексикийн хилийн хамгаалалтын туршлагаас үзвэл хилийн шалгалтыг огцом чангатгах нь урьдчилан таах боломжгүй ихээхэн муу үр дагавартай болох нь харагдаж байна. 1990-ээд он, 2000-аад оны эхээр Америкийн засаг захиргаанаас авч хэрэгжүүлсэн өргөн хүрээтэй арга хэмжээ (шинээр саад барих, байгааг нь хүчжүүлэх)-ний үр дүнд, Мексик рүү эргэж ирээд байдаг байсан хууль бус цагаачид АНУ-д олноороо суурьшиж эхэлжээ. Нэр хүнд бүхий судалгааны байгууллага <<Центр Пью>> (<<The Pew Research Center for the people & the Press>>)-ын тооцоолсноор тэдний тоо

2.2 саяас 6.2 сая [Passel 2006] болтлоо нэмэгджээ.

Түүний зэрэгцээ, хууль бус цагаачдыг хил гаргж өгөх ажиллагаа их ашигтай бизнес болсон нь хилийн саад давуулах [Голунов 2008] талдаа мэргэшсэн, Мексикийн мафийн бүлэглэлүүдийн үйл ажиллагааг урьд хожид байгаагүйгээр идэвхжүүлэв. Хар тамхи зөөвөрлөх явдалтай тэмцэх зорилгоор хаалт саад барина гэдэг бүр ч ирээдүй муутай ажил. Овор багатай контрбандын бүтээгдэхүүнийг түм түжигнэсэн тэр их урсгал дотроос илрүүлэхэд хялбаргүй, тэгээд ч хар тамхи зөөвөрлөдөг ганц нэг хүн баригдах нь тийм ч хохиролтой биш учраас зохион байгуулалттай хар тамхины наймаачид ихэвчлэн шалган нэвтрүүлэх боомтуудаар хар тамхи зөөвөрлөдөг байна. Хар тамхины мафи саадыг давахын тулд хууль бус цагаачид, шууданчин шувууд ашиглах, хонгил ухах, хар тамхиа саад давуулж хаях гээд боломжтой бүх аргыг хэрэглэж байна.

Ийм болохоор түүнтэй тэмцэх гэж хил дээрээ саад төхөөрөмжлөх нь хэт их үнэтэй, хэрэгцээ маш багатай арга хэмжээ болох нь хэн хүнд тодорхой. Хилийн ихэнх хэсгүүд дээр хар тамхины (жишээлбэл, америк-мексикийн хил дээр, хилчдийн өөрсдийнх нь тооцоолсноор хилээр нэвтэрч байгаа кокайны 1.5-3.0 хувь [A Line in the Sand 2005: 4]) тун ч багаахан хэсэг л илэрч байгаа юм. Хил дээрээ хана, хаалт бусад саад барьж байгуулсан улс болгоны туршлагыг ижилхэн үнэлж болохгүй л дээ. Зарим тохиолдолд эмх замбараагүй байдал үүсэж, террористууд хийгээд хууль бус цагаачид орж ирэх оролдлогыг багасгахын тулд аргагүйдэж авагдсан арга хэмжээнүүд ч байгаа л байх. Гэхдээ л хил зөрчигчид шинэ нөхцөл байдалд зохицдог нь авч байгаа арга хэмжээний үр өгөөжийг бууруулаад байгаа юм.

Түүний зэрэгцээ ийм санаачилга гаргасан хүмүүс, хөрш улсуудтайгаа харилцаагаа муутгах, хилчид, гаальчдын дунд авлигын төвшин нэмэгдэх, хүний эрхийг зөрчиж байна гэдгээр улс орны нэр хүнд муудах гээд олон тооны сөрөг үр дагаврыг амсах болдог. Энэ бүгдийг бодолцох юм бол хилээ хаалт, саадаар хаана гэдэг хилтэй холбоотой асуудлыг бүрэн арилгах бэлэн жор биш юм. Хил дээрээ хана хаалт босгох нь Америкийн хувьд л гэхэд ихэнхдээ нутаг дээрээ террорист үйлдэл гаргахгүй байлгаж, хилтэй холбоотой бусад асуудлаа бүрэн шийдэхэд, дүүрэн хангалттай нөхцөл болж чадаагүй юм.

ХАМТЫН ХҮЧИН ЧАРМАЙЛТААР АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ НЬ: АМЕРИК, КАНАДЫН ХИЛ

Хөрш зэргэлдээ улстайгаа аюулгүй байдлын хүрээнд хамтран ажиллаж, хил, хязгаараа хоёр талаасаа хамтран хамгаалах нь дээр бидний үзсэн загвартай харьцуулшгүй үр дүнтэй нь хэнд ч гэсэн тодорхой. Ийм стратеги баримтлах нь зэргэлдээх улстайгаа сайн хөршийн харилцаагаа хадгалж, цаашлаад хялбаршуулж, хил, гаалийн хяналтын хэрэггүй давхардлыг арилган үр дүнд нь үлэмж төсөв хэмнэж, хилээр нэвтрэх саад хоригийг багасгах юм. Гэхдээ ийм хувилбар, хөршүүд хоорондоо харилцан итгэлцэж, хоёр талын харилцааг хөгжүүлэхэд онцгой анхааран, төрийн хилийн бодлого боловсруулах явцдаа буулт хийхэд бэлэн байж, энэ бодлогынхоо стандарт зарчмуудыг зохицуулж ажилласан нөхцөлд үр дүн гарна.

Хөрш зэргэлдээ улсууд нягт хамтын ажиллагаагаар хилийн аюулгүй байдлаа хангаж байгаа тодорхой жишээ бол Америк, Канадын хилийн хамгаалалт юм. Энэ бол хөгжингүй эдийн засагтай, гадаад худалдааны түнш нөхөрсөг хоёр орныг зааглаж байгаа хуурай хэсгийн урт нь 8900 км

[The International Boundary Commission] дэлхий дээрх хамгийн урт хил юм. АНУ, Канадын хооронд бараа эргэлт 2006 онд 534 миллиард доллар, АНУ-ын хязгаар нутгаас Канад руу экспортолсон бараа 78.9 миллиард доллар (Үндэсний хэмжээнд 34.2 хувь) [Top Trading Partners 2006] байсан байна.

Америк-Канадын хилийн харилцааны эрчмийн үзүүлэлтүүдээс харвал Америк-Мексикийнхээс бага, гэхдээ Америк-Канадын хил дээрх хилийн харилцааны 90 хувь явагддаг 11 ШНБ-оор нэг секундэд нэг тээврийн хэрэгсэл, 6 секундэд нэг ачааны автомашин нэвтэрч байгаа нь бас л том үзүүлэлт [Bureau of Transportation Statistics]. 1930-аад онд Канадын Ерөнхий сайд байсан Р.Беннетийн хэлснээр Америк-Канадын хил XX зууны туршид хоёр талын худалдаа хөгжсөн <<дэлхийн хамгийн урт хамгаалалтгүй хил>> байсан юм (Безопасность и международное сотрудничество...2002: 44). Шалган нэвтрүүлэх боомтуудаар хийгдэж байсан шалгалт нь хялбаршуулсан шинжтэй, шалгалтыг зохих албадын цөөн тооны хүмүүс АНУ, Канад руу зөвхөн ороход хийдэг байв. 1995 онд Америкийн талаас хилийн эргүүлийн 291 агент ШНБ-уудын хоорондох зай завсрыг хянаж бараг хамгаалалтгүй байсан бол Мексикийн хил дээр 7409 агент үүрэг гүйцэтгэж байсан байна. [Phillips 1998: 30].

Хил нэвтрүүлэн хар тамхи, контрбандын эд зүйлс наймаалах, цагаачдыг зөөвөрлөх маршрутыг үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүд эзэгнэсэн 1990-ээд онуудад нөхцөл байдал өөрчлөгдөв. Канадад эмхлэгдэн байгуулагдсан <<Хэзболла>>-гийн болон бусад экстремист бүлэглэлүүд зарим операцид оролцжээ [Testimony of Janice L.Kephart 2006: 22-23]. Энэ улсын цагаачлалын хууль тогтоомжийн чөлөөт байдал нь Исламын дайчдад суурьшил олж аваад, зохион байгуулалтад орж АНУ-ын нутаг дэвсгэрт террорист ажиллагаа төлөвлөн явуулах боломж бүрдүүлээд байгаа юм. 1999 оны 12 дугаар сард, Лос-Анжелесийн нисэх буудал дээр террорист ажиллагаа зохион байгуулах зорилгоор тэсрэх бодис ачсан машинтай АНУ-д нэвтрэх гэсэн Алжир гаралтай А.Рессам гээч хил дээр саатуулагдсан байна. 2000-2001 онуудад өөр хэд хэдэн Исламын хэт үзэлт бүлэглэлүүдийн төлөөлөгчид хил дээр баривчлагдсан юм. Америкийн тал хилийн дээрх будлианууудад хариу арга хэмжээ болгож цагаачлалын хяналтаа чангатгасан нь хилээр нэвтрэх хүмүүсийн урсгал татарч дахин 1995 оны төвшнөөс дээшлээгүй юм (105.8 сая хүн) [Bureau of Transportation Statistics-ийн тооцоолсноор].

Энэхүү сөрөг үр дагаврыг арилгахын тулд Оттава, Вашингтонд <<аюулгүй байдлын ерөнхий хүрээн>>-ний үзэл баримтлалыг санал болгож, Канад, АНУ хил нэвтрэх журмаа сулруулбал, өөрийнхөө цагаачлалын бодлогыг чангатгахаа амлав [Walker 2000: 7]. Гэвч 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист үйлдлийн дараа АНУ-ын засаг захиргаа хойд хилээ террористууд орж ирж болзошгүй гол чиглэлүүдийн нэг гэж үзэж эхлэв. 9 дүгээр сарын үйл явдлын дараа Вашингтоны авч хэрэгжүүлсэн хилийн хяналтыг чангатгах арга хэмжээ хилийн харилцаанд, таван жил өнгөрөөд байхад хуучин хэмжээндээ орж чадахааргүй тийм ноцтой хохирол учруулсан юм. 2006 онд хилээр нэвтэрсэн жуулчдын тоог 2000 онтой харьцуулахад 30 гаруй хувь, ачааны авто машины тоо 18.6 [4] хувиар буурсан байна [Bureau of Transportation Statistics-ийн тооцоолсноор].

Хоёр талын бараа эргэлт огцом буурсан нь хоёр улсын, тэр дундаа Канадын эдийн засагт ихээхэн хор

хохирол учруулсан юм. Ийм нөхцөл байдал үүссэн тул хоёр тал хилийн хөдөлгөөнд тавих хамтарсан хяналтын тогтолцоо бүрдүүлж, 2001 оны 12 дугаар сарын 12-нд итгэл хүлээсэн жуулчид болон худалдааны байгууллагуудад тааламжтай нөхцөл бүрдүүлэх, тэдгээр байгууллагуудын бараа таваарт тавих хяналтыг ачилтын шатанд нь шилжүүлэх, хил дээр бөөгнөрөл үүсгэхгүйн тулд ШНБ-уудыг өөрчлөн сайжруулах журмыг мөрдөх, шинэ стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тунхагласан <<Ухаалаг хил>>-ийн тухай тунхагт Оттава хотноо гарын үсэг зурсан [Smart Border Declaratio 2001] юм. <<Ухаалаг хил>>-ийн үзэл баримтлалын чухал механизм нь ФАСТ хөтөлбөр болсон юм.

Энэ бол гадаадаас бараа оруулагчид, тэдгээрийг тээвэрлэгчдийг гэрчилгээжүүлэх, жолооч нарыг бүртгэлжүүлэх (тэд бүртгүүлснийхээ дараа тусгайлан гаргасан зурвасаар дамжин, хилийг хялбаршуулсан журмаар нэвтэрч болно)-ээр урьдчилан бэлтгэсэн тэдний тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх ажлыг түргэтгэхэд зориулагдсан электрон хөтөлбөр юм. Үүнтэй төстэй өөр нэг хөтөлбөр бол АНУ, Канадын хооронд жуулчлагч нарт зориулагдсан НЕКСУС хөтөлбөр юм. 2006 онд л гэхэд АНУ, Канадын аюулгүй байдлыг оролцуулаад бусад салбарт төслийн дагуу 120 гаруй итгэмжлэгдсэн харилцаа тогтоогдсон байх юм. <<Ухаалаг хил>> үзэл баримтлалын хэрэгжилт янз бүр. Зарим бизнес эрхлэгчдийн үзэж байгаагаар 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараа авсан арга хэмжээний үр дүнд хил нэвтрэх асуудал урьд урьдынхаас [Dante 2002: 2] хялбар болсон байна. 2000-аад оны эхэнд АНУ, Канадын [Kergin 2001: 518] хил орчмын бараа эргэлтийн 40 орчим хувь дээр ажиллаж байсан 100 орчим компани (жишээ нь, <<Даймер-Крайслер>>, <<Дженерал Моторз>>, <<Форд>> мэтийн автомашины аврага компаниуд оролцоод) эдгээр арга хэмжээнүүдэд юун түрүүнд хамрагдав. Хоёр улсын авч хэрэгжүүлсэн энэхүү арга хэмжээнүүд, таатай боломж тальбуулсан тоотой компаниудын алдагдлыг асар багасгасан нь мэдээж.

Гэхдээ эдгээр арга хэмжээнүүд цөөн тооны тээвэр эрхлэгчид, жуулчдыг хамарснаар, 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагын өмнө байсан хил даснасан хөдөлгөөний эрчмийг сэргээж чадаагүй юм. Дээр дурьдсанаар, жуулчдын урсгал барагцаалбал, гуравны нэгээр буурч, НАФТА (Хойд Америкийн чөлөөт худалдааны бүс)-г байгуулагдсаны дараах 1990-ээд онд хүрсэн худалдааны ачаа тээврийн эргэлт эрс буурав. Америкийн хилчид жилдээ 10000 орчим хүнийг саатуулж байгаагаас үзвэл, хилийг ингэж бэхэлснээр гэмт хэргийн бүлэглэл болоод хил зөрчигчдийн хувьд нэвтэршгүй болгож чадахгүй байгаа нь энэ урт хилийг хамгаалж, түүнийг бүрэн хяналтандаа аваагүй цагт, хил нэвтрэх журмыг чангатгаад, чангатгаад хилийн аюулгүй байдлын 100 хувийн баталгаа болж чадахгүй байгаа нь эндээс ийнхүү харагдаж байна.

САЛД, ХААЛТЫГ АРИЛГАЖ, ХИЛИЙН НЭГДМЭЛ ОРОН ЗАЙ БҮРДҮҮЛЭХ НЬ

Ямарваа хилийн хаалт, хил дамнасан харилцаанд шууд болон шууд бусаар саад учруулж байдаг бол, хил, гаалийн хяналт суларснаар хилийн харилцааны хөгжилд таатай нөлөөлдөг байна. Түүний зэрэгцээ, хилийн дэглэмийг заавал чангатгаж журамлах шаардлагагүй харьцангуй <<жирийн>> ангиллын хил зөрчигчид дамын наймаачидтай хөөцөлдөөд байх хэрэгцээ ч багасдаг. Гэхдээ хилийг нээлттэй болгосноор, эдийн засаг, гаалийн бодлого, зэргэлдээх улсуудын хууль сахиулах байгууллагуудтай үйл

ажиллагаагаа зохицуулах, хилийн нэгдмэл орон зай үүсгэх, тодорхой стандарт (хяналт урьд урьдынхаас улам ч чангарах нь бий) тогтоон мөрдсөнөөр гадаад хилээ хяналтандаа авах гээд хэд хэдэн хялбаргүй болзлыг биелүүлэх хэрэгтэй болдог байна.

Эдгээр урьдчилсан нөхцлүүдийг хангахад ихээхэн цаг хугацаа өнгөрч, энэ зуур зэргэлдээ улсуудын харилцаанд итгэлцсэн уур амьсгал, улс төрийн аятай таатай байдал хадгалагдаж байх учиртай байдаг. Ийм загварын сонгодог жишээ нь Европын холбоо юм. Европын холбоо тогтвортой хил, түүнийг хамгаалах боловсронгуй төвлөрсөн тогтолцоо байхгүй. Тэглээ ч гэсэн, Европын холбооны гишүүн болон гишүүнээр элсэхээр бэлтгэж байгаа улсуудын хилийн бодлого нь ихэнхдээ заавал биелүүлэх учиртай нийтлэг зарчим, журмуудад тулгуурладаг байна. Европын холбооны хилийн бодлого юун түрүүнд, Европын холбооны дотоод, тэр дундаа Шенгений бүсийн улс орнуудын хилийг шалгалтгүй болгосон Шенгений журманд үндэслэгдэж байгаа юм. Хууль бус цагаачлал, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд, Европын холбооны улсууд хамтын ажиллагаагаа өргөжүүлж байгаатай нийцүүлэн гадаад хилийнхээ хяналтыг чангатгаснаар энэ асуудал шийдэгдэх аж.

Гэхдээ Европын холбооны гадаад хилийн хяналтын тогтолцоог бүрдүүлэгчид гол зорилгоо, эрх зүйн нийтлэг тогтолцоотой болох (ойрын ирээдүйд тийм боломж байхгүй)-д биш, хилийн бодлого (Hobbing 2003: 6)-оо оновчтой болгоход чиглэл болохуйц стандарт боловсруулж, туршлага, мэдээлэл солилцох явдал юм гэж үзэж байна. Европын холбооны гишүүн, ялангуяа шинээр элсэхээр бэлтгэж байгаа улсуудын гадаад хил (эсвэл хамгийн сүүлд гишүүнээр элссэн улсын хил)-ийн хамгаалалтын стандартад техникийн шалган байцаах тусгай газар хяналт тавьж байдаг. Европын холбооны гадаад хилийг хамгаалах, хил дамнасан хууль бус үйлдэлтэй тэмцэх тогтолцоонд уг холбооны дундын бүтэц, механизмууд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тийм бүтцүүдийн нэг нь Шенгенийн мэдээллийн систем бөгөөд виз мэдүүлсэн болон хил нэвтрүүлэхгүй, хэрэг төвөгт орж байсан хүмүүс, хулгайлагдсан эд зүйлсийн талаар хилчдэд мэдээлэл өгдөг.

Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Европол зохицуулах үүрэгтэй ажиллаж, хууль сахиулах байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох, тагнуулын мэдээг шинжлэх, зөвлөмж боловсруулах ажлуудыг голчлон эрхэлж байна. Европын холбооны гишүүн улсуудын хилийн бодлогыг зохицуулах, мэдээлэл туршлага солилцох ажлыг зохион байгуулах зорилгоор, Европын холбооны улсуудын гадаад хил дээрх шуурхай хамтын ажиллагааны удирдлагын агентлаг <<ФРОНТЕКС>> байгуулагдав. ФРОНТЕКС бол Европолын нэгэн адил гүйцэтгэх засаглалын бүрэн эрх байхгүй, зохицуулагч байгууллага.

Европын холбооны гадаад хилийн хяналтын ерөнхий механизм бүрдүүлэх үйл явц үргэлжилж байгаа бөгөөд дуустал өдий байна. Европын холбооны зарим улсуудын олон нийтийн үзэж байгаагаар, энэ талын [Anderson 2000: 15] <<туршлага багатай>> улсуудад хилийнхээ хамгаалалтыг даатгана гэхэд итгэл муутай байгаагаас гишүүн орнуудын хооронд санал зөрөлдөх нь олонтаа. Түүнчлэн, Европын холбооны <<асуудалтай>> хилийг арга буюу хамгаалах болж байгаа болон тийм хилгүй улсуудын хооронд зарах зардлыг тэнцвэргүй хуваариллаа гэж тэмцэл маргаан гарх нь бий. Гэхдээ хилийн бодлогын үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлоход нэгдмэл байр суурь баримтлахад Европын холбооны

улсуудын эрх зүйн тогтолцооны ялгаатай байдал хамгийн ноцтой саад болж байгаа юм. Хуучин социалист лагерын орнуудын иргэдийн хяналтгүй цагаачлал, хилийн аюулгүй байдлын гол сорилт болсон нь Европын холбоо 1990-ээд онд хамтын хилийн бодлого боловсруулахад нөлөөлсөн юм.

Социалист гэгдэж байсан улсуудтай хамгийн олон км хиллэж байсан Герман, Австри улсуудад ихээхэн ачаалал ноогдов. <<Төмөр хөшиг>> нуран унасны дараах БНГУ, БНПУ-ын хоорондох хил, хилийн харилцааны эрчим (хууль бус цагаачлалыг оруулаад)-ээрээ ч, хоёр орны нийгэм-эдийн засгийн тэгш бус хөгжлөөрөө ч америк-мексикийн хилийн өвөрмөц <<европын эквивалент (тэнцүүр)>> болон хувирав. 1994 онд л гэхэд 147 сая хүн, 60 сая тээврийн хэрэгсэл хил нэвтэрсэн мэдээ байна [Andreas 1999: 935]. Ийнхүү хоёр орны хоёулангийнх нь хүн ам, америк-канадын хүн амыг нэгтгэснээс хэд дахин цөөхөн атлаа, 1990-ээд онд Польш, Германы хоорон дахь хилийн харилцааны хэмжээ америк-канадын хилийнхээс ойролцоогоор 1.5 дахин их байв. Хууль ёсны төдийгүй, хууль бус (сүүдрийн) үйл ажиллагаа ч идэвхжиж, 1991 онд ХБНГУ-д байсан хууль бус цагаачдын тоо албан ёсны мэдээгээр 500 мянгад хүрч байв [Andreas 1999: 6].

Ийнхүү хил дамнасан хууль бус үйл ажиллагаа идэвхжмэгц Германы тал маш хатуу арга хэмжээ авсан нь, АНУ, өмнөд хилээ бэхжүүлэхээр авсан иймэрхүү арга хэмжээнээс зарим талаараа чанга байлаа. 1990-ээд оны эцэс гэхэд Герман-Польшийн хилийн километр тутамд, америк-мексикийн хилийнхээс 10 дахин илүү хилийн цагдаагийн агентууд оногдож байв. Германы хилчид 30 км-ийн бүсийн дотор, шалтгаан тайлбарлахгүйгээр хүмүүсийн бичиг баримтыг шалгах, мөрдөх, утас чагнах, нэгжлэг хийх эрхтэй болов. Хууль бус цагаачид байгааг мэдээлэхгүй нуун дарагдуулсан бол шоронд хорих хүртэл арга хэмжээ авах хатуу хуультай [Буршель 1999: 65-68]. Хэдий ийм хатуу арга хэмжээ авсан ч гэсэн Германы засаг захиргаа, баримталж байгаа бодлогыг нь <<берлиний хана>>-тай жишихээс жийрхэж, хил дээрээ хана хаалт босгоогүй юм [Andreas 19995 235]. Гэвч, хилийн цагдаагийн мэдээлснээр 1990-ээд оны хоёрдугаар хагаст дунджаар таван хил зөрчигчийн нэгийг саатуулж байснаас үзвэл, Германы засаг захиргаа нөхцөл байдлыг хяналтандаа авч чадаагүй байна.

Үүний хажуугаар хилийн цагдаа нар (голдуу социалист Германы хилчид байсан) цагаачлагчдын эрхийг байнга зөрчдөг байв [Andrea 1999: 233]. АНУ-аас ялгаатай нь Герман анхнаасаа л эдийн засгийн тусламж үзүүлэх, ажлын байр буй болгох, Европын холбоонд элсэх сонирхол төрүүлэх, эдийн засгийн өөрчлөлт хийх, хууль сахиулах үйл ажиллагааны стандартыг адил болгох чиглэлээр нягт харилцан ажиллах зэргээр Дорнод Европын хөршүүдтэйгээ ойртон нягтрах бодлого баримталсан юм. Эцсийн эцэст, Польш, Чех хоёр ихээхэн хэмжээний бэлтгэл ажлыг гүйцэтгэж байж, 2004 оны 5 дугаар сарын 1-нээс Европын холбооны бүрэн эрхт гишүүн болсон боловч 2007 оны сүүлчээр л тэдгээр улсын иргэдийг Европын холбооны дотор хөдөлгөөн үйлдэх хязгаарлалтыг цуцалсан байна. Герман-Польш, Герман-Чехийн хил дорно зүг тэлж, Польш улс Орос, Украйн, Белорусстэй хиллэх болсон тул тэдгээр хил Европын холбооны гадаад хил байхаа болив.

Ийнхүү Европын холбоо, 1990-ээд оны эхний хагаст боломжгүй мэт санагдаж байсан, <<асуудалтайгаараа>> америк-мексикийн хилтэй зүйрлэж болохоор тэдгээр хил заагуудыг <<уусгаж>> чадсан юм. Европын холбоог дорно зүгт өргөтгөсний дараа,

Газар дундын тэнгисийн бүс нутгийн хуурай газрын болон усан хилийн асуудал үлэмж төвөгтэй болов. Хууль бус цагаачлал, хар тамхины худалдааны маршрут чухамдаа энэ бүс нутгаар дамжин (ТУХН-ийн улсуудын хилээр биш) өнгөрч байсан юм. Шинжээчдийн үнэлгээгээр, хууль бусаар цагаачлагчдын 2/3-оос 80 хувь, хар тамхины ихэнх хувь нь хүрдэг газраа хүрээд байсан байна [Kolakovic, Martens, Long 2002: 119, 126-г үз]. Аюулгүй байдлын асуудал хурцадсантай холбогдуулан, Европын холбоо гадаад хилийнхээ хил, визийн хяналтыг чангатгаад зогсохгүй, гишүүнээр элсэхээр бэлтгэж байгаа болон Европын хобоотой онцгой харилцаа (санхүүгийн дэмжлэг авах, визийн журмыг либеральчлах) тогтоохыг хүсэж буй улсуудыг хилийн журмаа чангатгахыг шаардаж байгаа юм.

Үүний үр дүнд, Европын холбоонд элсэхээр бэлтгэж байгаа улсууд зүүн гарын хөршүүд болон бусад олон улсууд (Оросыг оролцуулаад) хоёр талаас байгуулсан гэрээнээс гарч, тус улсуудын зүгээс хууль бусаар Европын холбооны нутаг дэвсгэрт нэвтэрсэн цагаачдаа буцааж авахаар Брюссельтэй байгуулсан гэрээнд гарын үсэг зурахаас аргагүй болов. <<Шенгений хөшиг>>-ийн бүс өргөжсөнөөр эдгээр улсууд тэдний зүүн болон өмнөд хөршүүдэд учруулсан хохирлыг багасгахад, визийн журам үйлдчилдэг улсуудын нутаг дэвсгэрийг оролцуулаад, Евробүсийн хэмжээнд хил дамнасан хамтын ажиллагааны хөтөлбөр туслах ёстой байв. Хамтрагч улсуудын эдийн засгийн ядмаг боломж, хэт төвлөрсөн шийдвэр гаргах тогтолцооноосоо болоод улс хоорондын хамтын ажиллагаа төдийлөн үр дүнтэй биш байлаа. Гэвч энэхүү хамтын ажиллагаа <<Шенгений хөшиг>>-ийн хүрээнд <<сайн хөршүүдийн бүс>> үүсч, Европын холбоотой хил залгаа бүс нутгуудад европод таатай хандах уур амьсгал тогтон, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа гүнзгийрэхэд нэмэр болсон нь мэдээж.

Европын холбоонд шинээр элсэж байгаа болон элсэхээр бэлтгэж, элсэх бодолтой байгаа улсуудын хил, гаалийн албадад, эдгээр албадыг цэргийн бус байлгах, шалган нэвтрүүлэх боомтуудыг компьютержүүлэх, хил дээр орчин үеийн техник хэрэгсэл ашиглах, хүний эрхийг хангах гэх мэтийн стандарт шаардлагууд тавьдаг. Эдгээр стандартууд хэдийгээр, зөвлөсөн өнгө аястай байдаг ч Европын холбооны гишүүн, тэр дундаа гишүүн болохоор бэлтгэж байгаа улсууд зайлшгүй биелүүлэх шаардлага болж, эдгээрийг эс биелүүлбэл, элсүүлэхээс татгалзах шалтгаан болох нь бий [Hills 2004: 61-81]. Европын холбооны гадаад хилийн хамгаалалтыг хуучны социалист лагерын орнуудад шилжүүлснээр, Европын холбоо дотроо бяд муутайхан, энэ талын туршлага багатайхан улсууд хилийн аюулгүй байдлыг хангах хүнд ачааг үүрэх болов. Хэрэв сүүлийн асуудлыг бусад улсуудын хууль сахиулах байгууллагуудтай солилцох механизмыг хөгжүүлэх замаар шийдвэрлэсэн бол Европын холбооны шугамаар гишүүн зарим орнуудын материалын дарамтыг хөнгөвчлөхийн тулд тэдэнд техникийн тусламж үзүүлэн, хилийн дэд бүтцийг хөгжүүлэхэд гаалийн татварын 25 хувийг (2002 он хүртэл 10 хувь) үлдээх эрх олгох зэргээр хөнгөлөлтийг хөхиүлэх зорилтот тусламжинд хамааруулах арга хэмжээ авч байв [Hobbing 2003: 8].

Гэвч, дээр тэмдэглэсэнчлэн, гадаад хилийн хамгаалалтын ачаалал Европын холбооны улсуудын хооронд шударга хуваарилагдаж хараахан чадаагүй л байна. Ийнхүү Европын холбоо өргөжих явцдаа эдийн засаг, хууль сахиулах салбар болоод бусад хүрээнд шинэтгэл хийх Европын нийтлэг стандартыг <<тулган хүлээлгэсэн>> социалист лагерын орнуудтай эн тэнцүү биш ч гэсэн нягт хамтран ажилласнаар хилийн

асуудлыг <<арилгаж>> чадсан байна. Эдгээр улсууд удаан үргэлжилсэн шилжилтийн үеийг туулж байж, Европын холбооны хилийн орон зайд нэгдэж түүний гадаад хилийг хамгаалах болжээ. Эндээс үзвэл, одоохондоо Европын холбооны гадна байгаа Балканы улсуудын хувьд ч иймэрхүү стратеги баримтлах нь тодорхой байна.

Европын холбоо эдгээр болон хууль бус цагаачид нэвтрэх, хар тамхи зөөвөрлөх зам дээр оршиж буй улсуудтай хамтран ажилласнаар тэдний хилээ бэхжүүлсний хариу болгож сэтгэл татмаар (визийн журмыг либеральчлах ч гэдэг юм уу) санал тавих, болохгүй бол даралт шахалт үзүүлэх зэргээр хүчтэй хөшүүрэг хэрэглэж байна. Европын холбооноос авч хэрэгжүүлсэн эдгээр арга хэмжээнүүд хууль бус цагаачлалыг хязгаарлаж, хар тамхи зөөвөрлөх явдалтай тэмцэхэд мэдэгдэхүйц ахиц гаргаж чадсангүй, хил зөрчих боломж хязгаарлагдсаар үлдэв. Европын холбооны хилийн бодлого үр дүнгээрээ АНУ-ын Мексикийн талаар баримталж байгаа бодлогоос ялгаатай байгаа юм.

ТӨГСГӨЛИЙН ОРОНД: ГАДНЫН ТУРШЛАГЫГ ОРОСЫН НӨХЦӨЛД ХЭРЭГЛЭЖ БОЛОХ УУ?

Орос улс бол хуурай газрын хэсэг нь л гэхэд 20 гаран мянган км үргэлжилсэн дэлхийд хамгийн урт хилтэй улс. Ихээхэн <<хөл хөдөлгөөнтэй>>-д тооцогддог Орос-Украйны хилээр жилдээ 20 орчим сая зорчигч, 1.5 сая автомашин [Кройчик 2006] бүртгэгдсэнээс үзвэл, Оросын хилээр хил нэвтрэх хөдөлгөөн АНУ болон Европын холбооны хилээр нэвтрэх хөдөлгөөнөөс бага эрчимтэй байгаа юм. 2007 онд 7000 орчим хүн саатуулагдсанаас үзвэл, Оросын хил дээр саатуулагдаж байгаа хууль бус цагаачдын тоо ч харьцангуй цөөхөн. Иймм учраас хэдийгээр зарим улс төрчид, хэвлэн нийтлэгчид [Жишээ нь: Павлов 2006] иймэрхүү санаа хэлж байгаа ч, АНУ, Мексиктэй хиллэдэг хилээ хаалт хашаагаар яаж бэхжүүлж байгаа туршлагыг шууд хуулбарлах нь төдий л зохимжтой биш юм. Хар тамхи наймаалагчид болоод террористуудын ихэнх нь Оросын нутаг дэвсгэрт байршиж, үлдсэн хэсэг нь, хэсэг бүлгээрээ (Израйль, Энэтхэг шиг) биш,ганц нэгээрээ орж ирдэг тул хилийн хаалт, хашаа тэдний замд өөдтэй тээг болохгүй байгааг гадаадын туршлага харуулж байна. Гэвч энэ бол Орос улсын хилийн зарим хэсэг (тухайлбал Кавказын улсууд, Хятад)-т хатуу чанд хамгаалалт хэрэггүй, хойд Солонгост л гэхэд хяналтгүй нөхцөл байдал үүссэн үед хилийн хана, хаалт босгох шаардлагагүй гэсэн үг бас биш юм. Хилийн болоод гаалийн нэгдсэн систем бүрдүүлэх асуудал (эн түрүүнд шалган нэвтрүүлэх боомттой газруудаар)-ыг юун түрүүнд Казакстан, Украйнтай шийдвэрлэж болох юм. Орос улс Казакстантай зохих албадынхаа үйл ажиллагааны стандартыг ижил болгох асуудлыг бусад улсуудаас хялбар тохиролцож чадна.

Шалгалтыг сайжруулах, давхардлыг арилгах хамтын хүчин чармайлт хилийн шалгалтын хугацааг ихээхэн бууруулах нь мэдээж. Өнөөдөр тээврийн хэрэгслийн үзлэг явуулахад хагас цагаас хэд хэдэн цаг заримдаа хэд хэдэн хоног зарцуулж байгаа нь олон улсын стандарттай яав ч тохирохгүй байна. Хэрэв АНУ-Мексикийн юмуу АНУ-Канадын хил дээр иймэрхүү нөхцөл байдал үүссэн бол түүгээр нэвтэрч байгаа хил дамнасан урсгал олон арав дахин багасч, хил орчмын худалдаа тухай бүр 100 миллиард доллараар буурах байлаа. АНУ-аас ялгаатай нь Орос болоод ТУХН-д ордог томоохон хөршүүдийнх нь хоорондох бараа солилцооны бүтэц нь, төмөр

замаар тээвэрлэгдэж байгаа түүхий эдийн нөөц, анхан шатны боловсруулалт хийгдсэн бүтээгдэхүүнүүд голлож байна. Магадгүй, чухам энэ бүтцээс болоод Гаалийн шалгалтын нүсэр систем, хил дамнасан автозамын чанар муутай байдлаас болоод хохирч байгаа автотээврийнхэн тэрчлэн, Украйн, Казакстаны хилээр нэвтэрч буй сая сая иргэдийн эрэлт хэрэгцээ сүүдэрлэгдээд үлдэж байж ч болох.

Хөрш зэргэлдээ улсуудтайгаа хилээ хамтран хамгаалдаг тогтолцоо бүрдүүлбэл, хилийн шалгалтыг машид түргэтгэж, <<найдвартай зорчигчид>> жуулчдыг хөнгөлөлттэй нэвтрүүлж ч болох юм. Гадаад хилээ хамгаалах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэхийн сацуу хил, гаалийн саад хаалтыг арилгана гэдэг бага бус улс төрийн эр зориг, шилжилтийн урт удаан хугацаа шаарддаг ажил юм байна. 1990-ээд онд энэ загвар Белоруссь, Оросын харилцаанд амжилттай хэрэгжсэн нь, ЗХУ задарснаас хойш нэг их хугацаа өнгөрөөгүй байсантай холбоотой юм. Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, дундаж цалингийн хэмжээгээрээ ойролцоо хоёр улсыг таслан буй Орос-Казакстаны хилд энэ стратегийг хэрэглэх нь онолын хувьд боломжтой. Бидний үзэж байгаагаар, жил бүр орж ирж буй <<хүнд>> наркотикийн 1-2-хон хувь [Голунов 2007] буюу 3000 орчим хил зөрчигчид (голдуу хил орчмын оршин суугчид) саатуулагдаж байгаа энэ хил бодит байдал дээр байгаагаараа биш, зарим улс төрчид, нийтлэлчдийн бодож байгаагаар Оросын хувьд өрнөөс ирэх аюул заналын эсрэг нэн чухал саад хаалт юм.


Оросын удирдлагад нэг бус удаа хандаж байсан, хилээ нэгдсэн орон зайд оруулж өмнөд хилээ хамтран манах, хамгаалах Н.Назарбаевын саналыг хүлээн авсан бол Орос улс одоогийнхоосоо хоёр дахин бага хил манах байлаа. Энэ санал хэрэгжсэн бол эдийн засгийн ихээхэн хэмнэлт гарч, Орос-Казакстаны хамтын ажиллагааны боломж өргөжин, хуучин Зөвлөлтийн орон зайн үлэмж хэсэгт байр суурыа бэхжүүлэх боломж Оросод байсан юм.

Гэхдээ, хоёр улсын хил, гаалийн орон зайг нэгтгэх нь, эдийн засаг, хууль сахиулах болон бусад салбарт олон тооны урт удаан хугацаа шаардсан зохицуулалт хийгддэгийг Европын холбооны өргөжсөн туршлага харуулж байна. Орос, Казакстаны тухайд согтууруулах ундааны зах зээл дээр (Казакстаны согтууруулах ундаа Оросынхоос хоёр дахин хямд) үнийн болон, Казакстаны нутгаар дамжин орж ирж байгаа Хятадын бараанд гаалийн бодлого барих, ариун цэвэр-эрүүл ахуйн шалгалтыг стандартчилах, хил, гааль дахь авилгатай шийдвэртэй тэмцэх чиглэлүүдээр нэгдсэн бодлого боловсруулах хэрэгтэй байна. Түүний хажуугаар Оросод ч гэсэн <<гадаад>> хилийн хамгаалалтын үнэ цэнэтэй дундын систем, хоёр талын харилцаа (1990-ээд онд хуучин ЗХУ-ын хилийн хамгаалалтад гардаг шиг) муудаад ирэхэд нураад уначихгүй гэдэг баталгаа хэрэгтэй.

Энэ чиглэлээр тохиролцоонд хүртэл хугацаа хэрэгтэй нь мэдээж. Төрийн хилийн бодлогын алив нэгэн сонголт, тухайн хэсгийн урт, хил орчмын байдал, хил дамнасан хөдөлгөөний эрчим, зэргэлдээх улсын нийгэм эдийн засаг, соёлын байдал, аюулгүй байдалд учирч болох сорилт зэрэг тодорхой хэсгийн өвөрмөц онцлогоор тодорхойлогддог байна. Ийм учраас хилийн аюулгүй байдлыг хангах загварыг Оросын хөрсөнд автоматаар хуулбарлан буулгах нь сайнгүй л болов уу. Гэсэн хэдий ч иймэрхүү туршлагуудыг харгалзан үзэх нь ОХУ-ын хилийн бодлогыг төлөвлөхөд ихээхэн тустай байх болно.

Орос хэлнээс орчуулсан Д.Нямдорж

ПОГРАНОМЕТРИКТ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СИСТЕМИЙГ ХЭРЭГЛЭХ НЬ



Хил судлалын шинжлэх ухааны хур их мэдлэгийг хойч үедээ дамжуулах, шинжлэх ухааны салбаруудын хооронд мэдээлэл солилцоход бидний олон жил хэрэглэж ирсэн уламжлалт бичиг үсэг хүч мөхөсдөнө. Том зузаан толь бичиг хэрэглээд ч хүч дутна, бас алдаа мадаг гарна. Аугаа суут Эйнштейний томъёолсон "харьцангуйн ерөнхий онол"-ын тэгшитгэлийг (огторгуйд буй масс, энергийн холбоосыг харуулдаг 4 хэмжээст 16 компонент бүхий тензор тэгшитгэл) яаж үгээр илэрхийлэх вэ, англи хэлнээс яаж монгол руу хөрвүүлэх вэ, ядаж л "тензор" гэдэг үгийг оноож яаж орчуулах вэ. Ийм учир шалтгааны улмаас шинжлэх ухаан нь өөрийн гэсэн бичиг үсэгтэй болсон байна, үүнийг загвар гэнэ. Энэ нь шинжлэх ухааны "тоон загвар" юм.

Тоон загвар гэхээр математик загвар болно. Яагаад заавал тоон загвар гэсэн, яагаад түүхийн загвар, философийн загвар, эрүүл мэндийн загвар, эрх зүйн загвар гэхчлэн бусад шинжлэх ухааны салбаруудаар нэрлээгүй нь дараах учиртай, тайлбарлаваас: Шинжлэх ухаан нь хөгжин төгөлдөржих тусмаа улам бүр математикжиж, тоон загвар, тоон тэгшитгэлээр өөрийгөө илэрхийлдэг болно.

Шинжлэх ухаан нь математикийг хэрэглэдэг болсон тэр үедээ л сая төгс боловсронгуй болно гэдгийн учир энэ. Энэхүү математик хэмээх хэл нь өөрийн гэсэн бичиг үсэгтэй байж таарна, тэр нь тоон-загвар, тоон тэгшитгэл ажгуу. Эндээс математик бол шинжлэх ухааны хэл нь юм гэсэн үндэслэл гардаг байна. Дээр нэр дурдсан Эйнштейний зохиосон алдарт тензор тэгшитгэл нь тоон загвар мөн. Эдүгээ шинжлэх ухаанууд гойд ихээр математикжиж, судлаачид нь тоон загвараар л үр дүнгээ илэрхийлж хоорондоо ярилцдаг болов, ингэж л шинжлэх ухаан хөгжинө, ингэж л судлаач эрдэмтэд ялгарна. Бидний өнөөдөр ажиллаж буй, залуу үеийнхний маргааш ажиллах Хил судлалын салбарын маань тоон хэл нь, тоон тайлбар нь, тооцоо томъёолол нь пограномерик юм. Пограномерик хэмээх арвин энэ рашаанаас бага багаар аягалан, байнгын уншигч нартаа хүртээж байх болно. Хэвлэн буй материалыг математикийн ухааны доктор, профессор А.Лувсандэндэвийн орчуулгаар хүргэж байна.

XX зууны эхээр шинжлэх ухаан технологийн практик хэрэглээний шаардлагаар нийтийн үйлчилгээний онол бий болсон ба энэ онолын хөгжлийн суурийг тавихад Дани улсын эрдэмтэн, Копенгагены холбооны компаны ажилтан А.К.Эрланг онцгой

хүчин чармайлт гаргасан байна. Нийтийн үйлчилгээний онолыг зөвхөн холбооны салбарт хэрэглээд зогсохгүй, цэргийн алба, хил судлал, техник, тээврийн салбарт хэрэглэж болох нь харагдав. Нийтийн үйлчилгээний ерөнхий онолыг боловсруулахад орос, зөвлөлтийн гарамгай математикч А.Я.Хинчин (1894-1959) ихээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Хил хамгаалах салбарт техник хэрэгслийн ашиглалтын үр ашиг, шалган нэвтрүүлэх боомтуудын ажлын ачааллын шинжилгээнд нийтийн үйлчилгээний онолын аргуудыг хэрэглэж байна. Нийтийн үйлчилгээний онол, нийтийн үйлчилгээний системийг (НҮС) судалдаг, өөрөөр хэлбэл олон нийтэд шаардлагатай ямар нэгэн үйлчилгээг хилчид (бололцооныхоо хэрээр) үзүүлэх үйл ажиллагааг авч үзнэ. НҮС шаардлагатай үйлчилгээнүүд ба үйлчилгээний сувгуудаас тогтоно. Практикт ихэвчлэн дараах хоёр төрлийн үйлчилгээний систем байдаг:

Үйлчилгээний анхдагч төрлийн системд (шалган нэвтрүүлэх байр) үйлчлүүлэгч (зорчигч) үйлчилгээний сувгууд (паспорт шалгах тасалгаа) чөлөөгүй байвал дарааллаар үйлчлүүлнэ.

Хоёрдогч төрлийн систем (шууд дохиололтой хилийн застав)-д (хил зөрчигчийн дохиолол) ирэх мөчид үйлчилгээний суваг завгүй байвал үйлчилгээ үзүүлэх боломжгүй. Үүнийг сааталтай үйлчилгээний систем гэнэ. Энэ тохиолдолд хил зөрчигч баригдалгүй хил нэвтэрнэ гэсэн үг.

Хил зөрчигч дохиоллын системээр хуурамч дуудлага өгөөд хүлээж байтал, түгшүүрийн бүлэг 15 минутын дараа ирж шалгахад хил зөрчсөн ул мөр илрүүлээгүй байна. Хил зөрчигч цаг орчим болоод дохиоллыг дахин ажиллуулаад ажиглахад түгшүүрийн бүлэг цаг орчмын дараа ирээд мөн л юу ч олсонгүй. Хил зөрчигч нэг цагийн дараа дохиоллын шугамыг тасдан хил зөрчжээ. Үүнийг нь өглөө явж байсан манаа илрүүлсэн сонгодог жишээ байдаг.

Дээрх хоёр төрлийн систем нь зөвхөн техникийн онцлогоороо ялгаатайгаас гадна үндсэн үзүүлэлтээрээ өөр юм.

Хүлээлттэй системд хүлээлтийн дундаж хугацаа ба сувгуудийн завгүйдлийг авч үздэг. Сааталттай үйлчилгээний системийн хувьд үйлчилгээний татгалзлын магадлал (үйлчлүүлэгчээ алдах) чухал байдаг.

Хил хамгаалалтын техник хэрэгсэл, хүн хүчний үйлдлийн үнэлгээ ба бүтцийн тогтолцооны оновчтой хэлбэрүүдийг сонгоход нийтийн үйлчилгээний онолын мэдлэг, түүний үнэлгээний аргуудыг хэрэглэх хэрэгтэй.


7.1. НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СИСТЕМИЙН АНГИЛАЛ НҮС-ИЙН ЧАНАРЫН АНГИЛАЛ

Аль ч НҮС дотроо (нэгж, хэрэгсэл, үйлчилгээний хэсгүүд) гэх мэт тодорхой тооны бүтэцтэй байдаг ба эдгээрийг үйлчилгээний сувгууд гэнэ. Сувгуудын үүргийг (паспорт шалгагч, радио холбооны оператор, жижүүрийн оператор), түгшүүрийн бүлэг, хаах бүлэг, холбооны шугам, автомашинууд, засварын бригад гэх мэт хэсгүүд гүйцэтгэнэ.

НҮС бүр системийн оролтод ирсэн ямар нэг дуудлагын урсгал буюу шаардлагууд үйлчлэх үүрэгтэй. Дуудлагууд ихэвчлэн системийн оролтод санамсаргүй хугацаанд эрэмбэгүйгээр ирдэг.Тухайн суваг ирсэн дуудлагад үйлчилсний дараа суларч дараагийн дуудлагыг хүлээн авч үйлчлэхэд бэлэн болдог. Дуудлагын урсгалын ба үйлчилгээний хугацааны санамсаргүй байдал НҮС-ийг жигд бус ачаалалд оруулдаг. Хэсэг хугацаанд НҮС-ийн оролтод дуудлагууд бөөгнөрч дараалал үүсгэдэг ба зарим дуудлагууд үйлчилгээ авалгүй хаяж явдаг, заримдаа суваг

чөлөөтэй байхад дуудлага ирэхгүй бол НҮС гүйцэд ачаалагдахгүйд хүрч сувгууд сул зогсолт хийдэг.

Зураг 7.1.-д НҮС-ийн схемийг үзүүлэв.



Зураг. 7.1. Нийтийн үйлчилгээний системийн схем.

Нийтийн үйлчилгээний системийн ангиллыг авч үзье.

□ Ангиллын 1-р шинж: үйлчилгээний урсгал системд гаднаас орж ирнэ. Энэ системийг нээлттэй систем гэнэ. Үйлчилгээ авсны дараа үйлчлүүлэгч системийг орхин явна.

Нээлттэй системийн жишээ нь: зорчигчид шалган нэвтрүүлэх цэгээр дамжин өнгөрөх, түгшүүрийн дохиогоор гарах гэх мэт.

Оролт ба гаралтгүй системийг хаалттай систем гэнэ. Үйлчилгээний дуудлагууд зөвхөн систем дотроо үйлчлүүлнэ. Хаалттай системийн жишээ нь хил хамгаалах байгууллагын доторх техник хэрэгслийн үйлчилгээ юм.

□ Ангиллын 2-р шинж: үйлчилгээний үелэлээр нь нэг ба олон үелэлт үйлчигээний систем гэж ангилна. Хэрэв НҮС-ийн сувгууд нэгэн төрлийн буюу ижил үйлчилгээ үзүүлдэг бол нэг үелэлтэй НҮС гэнэ.

НҮС-ийн сувгууд цувран байрласан ялгаатай үйлчилгээ үзүүлдэг (үйлчилгээ хэд хэдэн шатлалтай буюу үелэлтэй) бол олон үелэлтэй НҮС гэнэ. Олон үелэлтэй НҮС-ийн жишээ нь онгоцны буудал дээр зорчигчдыг хүзүүвчнээс зөөж ирэх, бүртгэх, гаалийн үзлэг, хилийн шалган нэвтрүүлэх ба бусад шалгах ажиллагаанууд болно.

□ Ангиллын 3-р шинж: Үйлчилгээний сувгийн тоогоор нь нэг сувагтай ба олон сувагтай НҮС гэж ангилна.*n*-сувагтай (сувгийн тоо нь хоёроос олон). Энд болон цаашид суваг бүр нэг л дуудлагад үйлчилнэ гэж үзнэ.Олон сувагт НҮС нэг дуудлагад үйлчилгээ үзүүлэх хугацаагаараа өөр нэгэн төрлийн ба ялгаатай сувгуудтай байж болно.

Нэг сувгийн үйлчилгээ үзүүлэх хугацаа $T_{\text{ү}}$ тасралтгүй санамсаргүй хэмжигдхүүн байна. Олон сувагтай системийн жишээ нь хэд хэдэн паспорт шалгагчтай шалган нэвтрүүлэх цэг. Нэг сувагтай системийн жишээнд түгшүүрийн дохиоллоор үйлчлэх хилийн застав байж болно.Түүний үйлчилгээний нэг суваг нь түгшүүрийн ба хаалтын гэсэн хоёр бүлэгтэй.

□ Ангиллын 4-р шинж: үйлчилгээний хүлээлтийн боломжоор нь хүлээлттэй ба цуцлалттай НҮС гэж хоёр ангилна.

Хэрэв шинээр ирсэн дуудлагад үйлчлэх суваг байхгүй бол системийн үйлчилгээ авахгүйгээр орхин явдаг. Ийм системийг цуцлалттай НҮС гэнэ. Дуудлага тасрах («үйлчилгээ аваагүй», ө.х. баригдаагүй хил зөрчигч) буюу залгасан дугаар чөлөөгүй үед дахин залгах нь цуцлалттай НҮС-ийн жишээ юм.

Хүлээлттэй системийг түр зуурын ба хязгааргүй удаан хүлээлттэй гэж хоёр ангилдаг.

Дарааллын урт ба хүлээлтийн хугацаагаар нь шинжинэ.

Түр зуурын хүлээлттэй үйлчилгээний системийн жишээ нь хилийн мөргөлдөөний үед шархадсан хилчдийн амь нас эмнэлэгт хүргэгдэх хугацаа,эмчийн үзлэг, мэс заслын

дарааллын хүлээлт, мэс засалд орох хугацаанаас хамаарна.

• Ангиллын 5-р шинж: үйлчилгээний дэгээр нь ангилна. Үйлчилгээний дэг гэдэг нь үйлчилгээний дарааллаас тогтсон журмаар сонгох үйлчилгээг хэлнэ. Дараах үйлчилгээний дэгүүд байдаг:

-FIFO дэг нь ирсэн дарааллаар нь үйлчлэх, (түрүүлж ирсэн нь,түрүүлж үйлчлүүлэх);

- LIFO дэг нь эсрэг дарааллаар үйлчлэх, (сүүлд ирсэн нь, түрүүлж үйлчлүүлэх);

-Санамсаргүй дарааллаар үйлчлэх нь: дарааллаас санамсаргүйгээр сонгож үйлчилнэ.

• Ангиллын 6-р шинж: Дуудлагын үйлчилгээний үргэлжлэх хугацаа, дуудлага хоорондын зай ба дуудлагууд ижил тархалтын функцтэй системийг нэгэн төрлийн ачаалалтай байна гэнэ.

Ерөнхий тохиолдолд дуудлагууд тархалтын функцээрээ, дуудлага хоорондын зайгаараа, үйлчилгээний хугацаагаараа ялгаатай байвал нэгэн төрлийн бус ачаалалтай систем гэнэ. Нэгэн төрлийн бус ачаалалтай системийн жишээнд хилийн боомтоор зорчигч тээврийн автобус, суудлын болон ачааны автомашин нэвтрэн өнгөрөх байж болно.

• Ангиллын 7-р шинж: дуудлагын урьтачлах үйлчилгээ.

Үйлчилгээний урдачлах байдлаар нь системийг дараах байдлаар ангилна:

-дуудлагууд урдачлалгүй байвал урдачлах үйлчилгээгүй систем гэнэ.

- дарааллаас яг үйлчилгээнд орох мөчид дуудлагын урдачлалыг тооцохыг харьцангуй урдачлалтай систем гэнэ.

-Үнэмлэхүй урдачлалтай систем нь үйлчилгээний явцад урдачлал нь тооцогдоно. Өндөр урдачлалтай дуудлагууд бага урдачлалтай дуудлагын үйлчилгээг тасалдуулах эрхтэй.

- Холимог урдачлалтай систем гэдэг нь дуудлагуудын зарим нь харьцангуй урдачлалтай, зарим нь үнэмлэхүй урдачлалтай байх ба бусад нь урдачлалгүй байна.

 Ангиллын 8-р шинж: нийтийн үйлчилгээний системийн загварчлал ба хэрэглэж байгаа судалгааны аргаар нь:

- Аналитик арга;

- Системийн шинжилгээний статистик загварчлалын арга гэж ангилна.

Мөн өөр ангиллын шинжүүд байж болно: (үйлчилгээний сувгуудын найдвартай ажиллагааны түвшин буюу эвдрэл, үйлчилгээний алдаа гэх мэт).

Нийтийн үйлчилгээний системийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцооны хамгийн энгийн томъёонууд дуудлагын урсгал энгийн ба дуудлагын үйлчилгээний хугацаа зэрэгт функцээр илэрхийлэгдэж байхад гардаг.

Үзэгдлийн энгийн урсгал

Үзэгдлийн энгийн урсгал буюу Пуассоны стационар урсгал дараах чанаруудтай:

1) Стационар урсгал нь хугацааны дурын (a,b) интервалд яг к ширхэг дуудлага ирэх магадлал хэрэв интервалыг t хугацаагаар шилжүүлэхэд ө.х. $(a+t,b+t)$ интервалаар солиход үл өөрчлөгдөнө.

2) Энгийн урсгал үр дагаваргүй байх нь к ширхэг дуудлага $(T,T+t)$ хугацааны турш ирэх магадлал энэ хугацааны завсраас өмнө ирсэн дуудлагаас хамаарахгүй. Хоорондоо үл огтлолцох хугацааны интервалуудад ямар нэг тооны дуудлагууд харилцан хамааралгүй байхыг үр дагаваргүй байх гэж ойлгоно.

3) Урсгал жирийн байх нь хугацааны тухайн агшинд хоёр болон түүнээс олон дуудлагад үйлчлэх боломжгүй гэсэн үг.

Мэдлэгийн олон салбарт (физик, найдвартай ажиллагааны онол, тээвэр,

погранометрик г.м) энгийн урсгал маш ховор тохиолддогийг туршлагаар нотолжээ. Үнэхээр стационар урсгалын тухай ойлголт бодит байдалд үл нийцэх хийсвэрлэл юм. Үнэндээ түгшүүрийн дохиолол цаг агаарын байдлаас ихээхэн хамаардаг. Бороотой үед дохиоллын эрчим эрс нэмэгдэх жишээтэй. Паспортын шалгалтанд орох зорчигчдын оролтын эрчим нислэгийн хуваарь, хоногийн турш өөрчлөгдөнө. Гагцхүү үзэгдлийг хугацааны маш богино завсарт авч үзвэл анхны ойролцооллоор стационар урсгал мэтээр тооцож болох юм. Тухайлбал, нэвтрэн өнгөрүүлэх цэгүүдэд хоногийн хугацааны хэд хэдэн интервал тус бүрт үйлчилгээний системийн шинжилгээ хийж болох юм.Цаг агаарын төлөв бүрт тусад нь түгшүүрийн дохиоллын үйлчилгээний системийн шинжилгээг хийнэ.

Мөн жирийн урсгалын таамаглал амьдралд бараг хэрэгждэггүй. Учир нь автобусаар ирсэн зорчигчид бөөнөөрөө паспортын шалгалтанд ирдэг. Энэ тохиолдолд нэг зорчигчийн дуудлага биш, зорчигчдын бүлгийн дуудлага гэж үзнэ. Гэвч энгийн урсгалын гурван чанар яг нарийн биелэгдэхгүй ч гэсэн бодит урсгалыг судлахад тулгуур болдог. «Энгийн» гэх нэр нь энгийн урсгалтай НҮС-ийн математик загвар хялбар бичигддэгтэй холбоотой. Энгийн урсгал ч үр дагавартай байдаг. Үзэгдлүүдийн урсгал хоорондоо хатуу функционал хамааралтай байдаг. Албадлагаар ч энгийн урсгалыг бий болгож болдоггүй. Санамсаргүй үзэгдлийн онолд энгийн урсгалыг хязгаарын тохиолдол гэж үздэг. Магадлалын онолд энгийн тархалтыг хязгаарын тохиолдол гэж үздэгтэй ижил юм.

Хангалттай их n тооны үл хамаарах, стационар ба жирийн урсгалын нийлбэржилтийн дүнд λ -эрчимтэй энгийн урсгалд ойролцоо загвар гаргаж болно.

Энгийн урсгалын эрчим нь оролтын урсгалуудын эрчмийн нийлбэртэй тэнцүү.


$$\lambda = \sum_{i=1}^{n} \lambda_i$$

«Пуассоны» урсгал гэсэн нь хугацааны тухайн интервалд болсон үзэгдлийн тоо энгийн урсгалын чанарын дагуу Пуассоны тархалттай байдагтай холбоотой. Үүнийг хялбараар тайлбарлая.

Хугацааны Ot тэнхлэгийн дагуу энгийн урсгалыг хязгааргүй санамсаргүй цэгүүдийн дараалал мэтээр дүрслэе. (зураг. 7.2).

Санамсаргүй хэмжигдхүүн Х-ээр дурын хугацааны τ завсарт оногдсон үзэгдлийн тоог тэмдэглэв. Хугацааны интервал τ -г n ширхэг тэнцүү элементар хэрчимд $\Delta t = \tau / n$ хуваая. Δt -элементар хэрчимд оногдох үзэгдлийн тооны математик дундаж нь $\lambda \Delta t$ байна. Энд λ – урсгалын эрчим. Урсгал жирийн байх чанар ёсоор элементар хэрчимд хоёроос илүү үзэгдэл явагдах магадлалыг тооцохгүй.

Иймээс Δt -хэрчимд дүрслэгдэх цэгүүдийн тооны $\lambda \Delta t$ математик дундаж ойролцоогоор түүнд оногдох нэг цэгийн магадлалтай тэнцүү.



Зураг. 7.2. Үзэгдлийн энгийн урсгал

Элементар хэрчим Δt -д ядаж нэг үзэгдэл оногдсон бол «чөлөөгүй» гэж нэрлэх ба ямарч үзэгдэл болоогүй бол «чөлөөтэй» гэнэ. $\Delta t = \tau / n$ -хэрчим «чөлөөгүй» байх магадлал $\lambda \Delta t = \lambda \tau / n$ байна. $\lambda\tau/n$; «чөлөөтэй» байх магадлал нь $1 - \lambda \tau / n$. «Чөлөөгүй» байгаа элементар хэрчмийн тоо (m –ширхэг хэрчим чөлөөгүй) гэж үзвэл $X = m$.Хугацааны τ -интервалд оногдох үзэгдлийг бином тархалттай санамсаргүй хэмжигдхүүнээр (n ба

$p=\lambda\tau/n$) төлөөлүүлбэл Бернуллийн томъёогоор:

$$P(X=m)=C_n^m\left(\frac{\lambda\tau}{n}\right)^n\left(1-\frac{\lambda\tau}{n}\right)^{n-m}$$

(Урсгалын үр дагаваргүй чанар, «Чөлөөгүй» n ширхэг элементар хэрчмүүдийн үл хамаарал нь бином тархалтын хуулийг нөхцөлдүүлж байна.

Мэдээж элементар хэрчмүүдийн тоог хязгааргүй нэмэгдүүлбэл $n\to\infty$ $p=\lambda\tau/n\to 0$ болох ба $np=\lambda\tau$ бином тархалт $a=\lambda\tau$ параметртэй Пуассоны тархалтад шилжинэ.

$$P_m(\tau)=\frac{(\lambda\tau)^m}{m!}e^{-\lambda\tau} \quad (1)$$

Тухайн тохиолдолд τ-интервалд нэгч үзэгдэл явагдаагүй (m = 0) бол магадлал нь:

$$P_0(\tau)=e^{-\lambda\tau} \quad (2)$$

(2) томъёо ёсоор t интервалд нэгч үзэгдэл явагдаагүй бол үзэгдлийн магадлал нь:

$$P(T\geq t)=e^{-\lambda t} \quad (3)$$

эсрэг үзэгдлийн магадлал нь ө.х. Т санамсаргүй хэмжигдхүүний тархалтын функц нь:

$$F(t)=P(T<t)=1-e^{-\lambda t}\approx\lambda\Delta t \quad (4)$$

Жишээ 1. Шалган нэвтрүүлэх цэгт ирэх суудлын автомашины эрчим $\lambda=1.5\ddot{o}\grave{a}\tilde{a}^{-1}$ (дунджаар цаг бүр 1,5 автомашин ирнэ). Яг 0,1,2,…,8 суудлын автомашин τ=2 цагт ирэх магадлалуудыг тооцоол.

Бодолт. (1) томъёогоор магадлалуудыг олж таблиц зохиоё:

Автомашины тоо	0	1	2	3	4	5	6	7	8
Магадлал	0,050	0,149	0,224	0,224	0,168	0,101	0,050	0,022	0,008

Таблицаас харахад 2 цагийн дотор нэгч автомашин ирэхгүй байх магадлал 0,05.

Тухайлсан 2 цагийн дотор 2 ба 3 автомашин ирэх магадлал хамгийн их байна.


Жишээ 2.

Жишээ 1–ийн нөхцөлд суудлын автомашины ирэлтийн эрчмийг $0.5\ddot{o}\grave{a}\tilde{a}^{-1}$ (дунджаар 2 цагт нэг машин ирэх) аас $3\ddot{o}\grave{a}\tilde{a}^{-1}$ хүртэл 0,5 алхамтайгаар өөрчлөгдөнө.

$\tau=2$ цагт 0, 1, 2, …, 8 суудлын машин ирэх магадлалын график байгуул.

Бодолт.(1) томъёогоор магадлалуудыг тооцоолж график байгуулна.

(зураг. 7.3).



Зураг. 7.3. Автомашины ирэлтийн ялгаатай эрчмүүдийн магадлалын хамаарал.

Хугацааны санамсаргүй агшинд ирсэн дуудлагуудаас харахад зарим интервалд үйлчилгээний систем сул зогсоод, өөр интервалд олон дуудлага ирэхэд дараалал үүсгэх буюу заримдаа үйлчилгээ цуцлагдаж байдаг.

НҮС-ИЙН Д.КЕНДАЛЛЫН АНГИЛАЛ

Нийтийн үйлчилгээний онолд янз бүрийн НҮС-ийн онцлогийг илэрхийлсэн маш эвтэйхэн товч тэмдэглээ хэрэглэдэг. Эдгээр тэмдэглэгээг A/B/N гэсэн гурван үсгээр хийдэг:

- A – Тархалтын хуулийг илэрхийлдэг;
- B – Үйлчилгээний үргэлжлэх хугацааны тархалтыг илэрхийлнэ;
- N – НҮС-ийн үйлчилгээний хэрэгслийн тоо.

Заримдаа НҮС төгсгөлөг дараалалтай байдаг. Энэ үед тэмдэглэгээг дөрвөн үсэг A/B/N/K болгодог. Энд K үсэг (чухамдаа N шиг тоо буюу хүлээлттэй сувгийн тоо).

Гурав буюу дөрвөн үсгийн тэмдэглэгээг Кендаллын тэмдэглэгээ гэдэг. Эдгээр тэмдэглэгээнд A ба B дараах үсгүүдээр солигдож болно.

$\{M, D, Ek, G, U\}$ дараах зааврааар үсэг орлуулна:

- A буюу B = M, хэрэв дуудлагад үйлчлэх үргэлжлэх хугацаа ба дуудлага ирэх хугацааны интервалын тархалтын функц экспоненциал хуультай байвал (M – Markovian);
- A буюу B = D, хэрэв дуудлагад үйлчлэх үргэлжлэх хугацаа ба дуудлага ирэх хугацааны интервалын тархалтын функц тодорхойлогдсон байвал (D – Determinate);
- A буюу B = Ek, хэрэв харгалзах тархалтын функц Эрлангийн k – зэрэгтэй байвал (E – Erlang). Эрлангийн k-зэргийн урсгал энгийн урсгалын k-дугаар дуудлагаар өдөөгдөнө.
- A буюу B = G, ерөнхий тархалттай байвал (G – General);
- A буюу B = U – харгалзах тархалтын функц жигд тархалттай байвал (U – Uniform distribution).
- Тэмдэглээний хэлбэрийн жишээнүүд:

M/M/1 нэг сувагтай НҮС-ийн оролтын урсгал энгийн, үйлчилгээний үргэлжлэх хугацаа экспоненциал тархалттай байхад.

D/E2/3/5 – НҮС-ийн оролтын урсгал байнгын, үйлчилгээний үргэлжлэх хугацааны тархалт Эрлангийн 2-р зэргийн функцтэй ба 3 үйлчилгээний сувагтай, 5 хүлээлтийн сувагтай;

M/G/2 – оролтын урсгал нь энгийн НҮС, үйлчилгээний үргэлжлэх хугацааны тархалт ерөнхий ба 2 үйлчилгээний сувагтай.

НҮС –ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НҮС-ийн үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлтийг гурван үндсэн бүлэгт хуваана:

1. НҮС-ийн ашиглалтын үр ашгийн үзүүлэлтүүд:

- НҮС-ийн үнэмлэхүй нэвтрүүлэх чадвар–нэгж хугацаанд НҮС-ийн үйлчилж чадах дуудлагын дундаж тоо.
- НҮС-ийн харьцангуй нэвтрүүлэх чадвар– НҮС-ийн нэгж хугацаанд үйлчилсэн дуудлагын дундаж тоог энэ хугацаанд ирсэн дуудлагын дундаж тоонд харьцуулсан үзүүлэлт.
- НҮС-ийн чөлөөгүй үеийн үргэлжлэх дундаж хугацаа.
- НҮС ашиглалтын коэффициент – НҮС дуудлагад үйлчлэх хугацааны дундаж хувь.

2. дуудлагын үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд:

- Дуудлагын дараалалд хүлээх дундаж хугацаа.
- Дуудлагын НҮС-д байх дундаж хугацаа.
- Хүлээлтгүйгээр үйлчилгээнээс

цуцлагдсан дуудлагын магадлал.

• Дахин ирсэн дуудлагын шууд үйлчлүүлэх магадлал.

• Дараалалд байгаа дуудлагын дундаж тоо.

• НҮС-д байгаа дуудлагын дундаж тоо г.м.

3. «НҮС – үйлчлүүлэгч» хосын үйл ажиллагааны үр ашгийн үзүүлэлтүүд

Энд «үйлчлүүлэгч»-ийн дор бүх дуудлага буюу дуудлагын эх үүсгүүрүүдийг ойлгоно. Иймүзүүлэлтийн тоонд хил хамгааллын техник хэрэгслийн техникийн бэлэн байдлын коэффициент, хууль бусаар далайн бүтээгдхүүний олборлолтын арилгасан дундаж хохирлын хэмжээ г.м.

ЦЭРГИЙН ДАРГА БҮХЭН БАГШ БАЙХ ҮҮРЭГТЭЙ УЧРААС ТЭДНИЙГ БАГШ БОЛГОЖ БЭЛТГЭХ ЁСТОЙ

/Ойлголтоо нэгтгэхийн тухайд.../

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж нэгэнтээ "...одоо бол үзэгдэл тойрч маргах цаг биш, үйлдэл, шийдэл хэрэгтэй...Ойлголтоо нэгтгэж, шийдлээ гаргаж, түүнийгээ тууштай хэрэгжүүлэх хэрэгтэй..." гэж хэлсэн билээ. Ойлголт нэгдээгүйн улмаас хүн бүр, юм болгоныг хүссэн хүссэнээрээ тайлбарлаж, зальтай нэг нь зайлшгүй хийх ажлаа хүртэл зайлуулан түлхэж, миний, хүний гэж маргах үзэгдэл бидний дунд ч байсаар байна. Одоо үзэгдэл тойрч маргалгүй, үйлдэл шийдэлд хүрэхийн тулд зарим ойлголтоо бага багаар ч болов нэгтгэж эхлэе.

Хилийн отряд (анги)-ын сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох талаар бид дээр дооргүй л ярьдаг. Сургана, бэлтгэнэ гэхээр хичээл сургууль хийгдэж таарна. Хэн тэгээд тэр хичээл сургуулийг чинь заах юм бэ? Хилийн сургууль төгсгөөд очиж байгаа офицеруудаа бид, хил хамгаалахад хэрэгтэй бүхэнд сургаж, сурсан эрдмээ сургах төвшинд бэлтгэж, тэд ч <<Бид багш шүү, хилийн анги, салбарт явагдах хичээлүүдийг биечлэн заах багш шүү, би бэлэн үү, багш болсон уу>> гэж өөрөө өөрөөсөө асуудаг, тэгж өөрөө өөрийгөө шаарддаг болгон гаргаж, <<цэргийн дарга бүхэн багш байх ёстой>> гэсэн сэтгэлгээ *(одоо бол, багш биш дарга гэсэн сэтгэлгээ нь давамгайлаад байна)* суулгаж, багшлах мэдлэг, дадлагатай болгож гаргах шаардлагатай байгаа тул би энэ удаа, **"цэргийн дарга бүхэн багш байх ёстой учраас тэднийг багш болгож бэлтгэх ёстой"** гэсэн асуудал дэвшүүлж түүндээ хариулт өгөхийг оролдлоо. Уншигчид ч санал бодлоо хуваалцаж, нэгдсэн ойлголтод хүрэхэд нэмэр тус болох биз гээд үүнийг үл өгүүлэн цааш өгүүлэх нь: Манай үеийнхний олонхи нь, шинжлэх ухаан технологийн дээд эрэмбэд гарчихсан, сансрын уудмыг алин хэдий эзэмшчихсэн, хүчний тэнцвэржүүлэгч гэдгийг нь дэлхий нийтээр хүлээн зөвшөөрчихсөн, ОХУ-д суралцаж,тэндэхийн "школ"-той болсондоо бахархаж явдаг билээ.

Бахархалгүй яахав, бахархах юмаараа хэн ч адилхан л бахархана. Харин миний хувьд Оросын алдартай багш нараар ном эрдэм заалгаад, санаандаа хүртэл сураагүйдээ хааяа хааяа харамсаж явдаг юм. Академид байхад минь хичээл зааж байсан миний багш Кутьенков В.А, академиийн сонсогч та нөхөд, цэргийн дарга / командир/ хэдий ч, сурган хүмүүжүүлэгч /педагог/ болохынхоо хувьд багш, багш багшдаа, **"хэлж байгаагаа мэддэг, хийлгэж байгаагаа чаддаг"** БАГШ болох ёстой юм шүү гэж сургадагсан.

Эндээс, цэргийн болон энгийн дээд сургууль төгсгөж, дүрэмт хувцас өмсөн, мөрдэс зүүсэн офицер, ахлагч хэн ч адилхан цэргийн дарга-сурган хүмүүжүүлэгч нар байх нь, тэд сургах ч, хүмүүжүүлэх ч үүрэгтэй, тийм учраас багш нар байх нь ээ гэсэн гаргалгаа гарч байгаа биз? Хил хамгаалах байгууллагын төв штабаас, хилийн отряд, застав, харуул хүртэлх бүх түвшинд сургалт явагдаж байгаа. Урд нь бид, бүх шатны сургуульд хичээл заадаг тэр хүмүүсийг л багш гэж явцуу хүрээнд ойлгодог байжээ гэж мэдэн будилсан ч, дор хаяад л бид чинь үр хүүхдээ сургаж хүмүүжүүлдэг багш-сурган хүмүүжүүлэгчид биз дээ? Ингээд үзэхээр цэргийн дарга офицер, ахлагч хэн хүнгүй бүгдээрээ л багш юм байна шүү гэдэг дээр ойлголт нэгдэж байгаа

байхаа гэж бодогдож байна.

Тэгвэл багш хүний эрхэм зорилго болгон, миний багшийн тодорхойлсон **“багш нар хэлж /зааж/ байгаагаа мэддэг, хийлгэж байгаагаа чаддаг байх ёстой”** гэдэг асуудал дээр жаахан тогтоё. Бид бүгдээрээ багш юм байна гэдэг дээр ойлголт нэгдсэн учраас багшийн үүрэг яаж хуульчлагдсаныг хууль сөхөж харцгаая.

“Дээд боловсролын тухай хууль”-ийн багшийн эрх, үүрэг гэсэн долоо дугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 2.1-д багш **“багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн явуулах”** үүрэгтэй гээд заачихаж.

Удирдлагын шинжлэх ухаанд дарга хүн, бүх хүмүүст таалагдах албагүй ч гологдож болохгүй гэдэг бол, сурган хүмүүжүүлэх ухаанд багш хүн, суралцагсаддаа гологдож болохгүйгээс гадна таалагдах үүрэгтэй. Нэг үгээр, ийм л хүн үнэхээр хичээл заахаас, багш байхаас яах вэ гэсэн бахархал төрүүлэхүйцээр хичээлээ бэлдэн зааж, өөрөө өөрийгөө тэднээр хүлээн зөвшөөрүүлнэ гэсэн үг. Үүний тулд багш хүн өөртэйгөө ажиллаж, зааж байгаа хичээл бүрээ судлаачийн төвшинд судлаж /судлаачийн үүрэг ноогдуулаад байгаагийн учир нь энэ/, тухай бүр шинэ мэдээллээр баяжуулан, дээрх хуулинд заагдсан үүргээ биелүүлж ажиллах ёстой болно. Эндээс **багш бүхэн судлаач байх үүрэгтэй** гэсэн логик дүгнэлт гарч ирнэ. Сэдэв бүрээ судалж, өөрийн болгон, тэр ч чанараараа “хэлэх гэж байгаагаа мэддэг болж байж” танхимд орж ирэх хэрэгтэй байх нь. Тэгж хичээл заадаг багш нар ХСИС- д л лав олон бий, тэднээс ирж суралцаж, урьж хичээл заалгахад юу нь болохгүй гэж?...Түүнээс биш энд, энд тэнд тааралдах зарим “багш” нарын “зааж” байгаа шиг хаа нэгтээгээс нэг юм, хам хум хуулж ирж “сонин уншлага” хийгээд, боловсролтой суралцагчийн цагийг барж дургүйг хүргэн, инээдийг хөдөлгөөд, алиалагч болж золигтохын нэр биш юм. Багш, сурган хүмүүжүүлэгчийн хэмжээнд хүрч, зиндаанд ажиллаж байгаа багш байтугай, дурын хэн нэгэн хэлж байгаа үгээрээ, хийж байгаа үйлдлээрээ өөрөө өөртөө дүн тавьж байдаг болохоор, багш хүн мэдлэг, чадвар, дадлага, туршлага юм юмаараа онцгой тасархай байх үүрэгтэй.

Өөрөөр хэлбэл багш хүн суралцагчийнхаа харах толь, барих баримжаа, үйл хөдлөлийн үлгэр дуурайл байх ёстой. Хэлээд байгаа юмаа, ингээд хийдэг юмаа гээд үзүүлээд өгдөг байх хэрэгтэй. Тэгж байж **“хийлгэж байгаагаа чаддаг”**-аа харуулна. Эс тэгвээс таны үг, үйлдэл зөрж, суралцагсдын итгэл үнэмшил алдагдан, сургалтын чанарт сөргөөр нөлөөлнө.

Ухаарахгүй бол сэхээрдэггүйн зовлонг сайн ойлгодог багшийн хувьд орчин цагийн залуу багш нар, дарга захирагч/ багш/, сурган хүмүүжүүлэгч /багш/ нараа санаж сэрэхэд нь хэрэг болуужин гэж дээрх сэдвийг хөндлөө.

Дээрх бичлэгээ нэгтгэн дүгнэвэл цэргийн дарга нар чинь **бүгдээрээ** багш, сурган хүмүүжүүлэгчид юм байна шүү, тийм болохоор багшид тавигддаг бүх шаардлагыг хангаж, үүргээ биелүүлэн, багш шиг багш болоход бас ч ажилтай юм байна шүү гэсэн нэгдсэн ойлголтод хүрсэн байх гэж бодож байна.

Хэрэв ойлголт нэгдсэн бол-шийдэл бэлэн байна, одоо багш шиг багш болох шийдлээ, тууштай хэрэгжүүлэх л үлдлээ дээ, БАГШ нараа.

Д.Нямдорж

Бэсрэг бичвэрүүд

(Уншихгүй ч байсан болно)

Уг чамайг хорин нэг шившвэл ...
Үйлс бүтээх шид ч болж чадна.
Зүрхэнд шивэх жад ч болж мэднэ.

С.Дулам

Манай зарим нөхөд уншсан мэдсэнээ ургуулан сэтгэж,өөрийнхөө үйл ажиллагаатай **уялдуулан шинжиж хэрэгтэй санааг тусгаж авахдаа** тааруухан байна уу даа гэсэн бодол хаяа хаяа төрдөг юмаа.Уншихад цаг бага орох, товч хураангуй тэгсэн атлаа хүнд юм өгч сэдэл төрүүлэхээр **"хамтарч унших"** бэсрэг бичвэрүүд боломжтой үедээ тэрлэж байх санаа төрлөө.

Уг бичвэрүүд уриалан дуудсан,ухаарал өгсөн,урам хайрласан, хаа нэгтээ харуусаж эмзэглэсэн янз янзын л өнгө аястай байх болно.

"Ямагт мэдлэг чинь хүрэлцэхгүй байгаа мэт суралцагтун,
Олж мэдсэнээ гээхээс айж байгаа мэт суралцагтун"

/Кунз/

хэмээх **уриалан дуудсан** бэсрэг бичвэр №1

...Хилчин хамт олны халуун бүлийн гишүүн болгон хийж бүтээхийн их хүслээр жигүүрлэн байгын бодол,мөнхийн эрлээр ажиллаж амьдрах юм.Тэд яаж бусдаас ялгарч, олноос онцгойрч, түмнээс тасрах, яаж албыг бэхжүүлж, ажлыг сайжруулан, улсын хил халдашгүй дархныг амаараа биш, ажлаараа харуулахаар уйгагүй эрэлхийлж, суулгүй ажиллаж байна. Амьдрал баян. Ингэнэ тэгнэ гэсэн бэлэн жор байхгүйгээс хойш ажлыг сайжруулах аргыг, амжилтанд хүргэх нууцыг ном сэтгүүл уншиж хайна, юм юм сонсож хайна. Ахмадаасаа асууж хайна, анд нөхөдтэйгээ маргаж хайна, ажлынхантайгаа зөвлөж хайна. Эцэс төгсгөлгүй эрэлд хатаж, энд тэндгүй хайна.

Хайснаа олно, олсноо хэрэгжүүлнэ, болсноо бататгана. Нээрээ л тиймдээ.

Туркийн нэрт яруу найрагч Назим Хикметийн тэртээ нэгэнтээ бичсэн:

Хэрэв би шатахгүй юм бол
Хэрэв чи шатахгүй юм бол
Хэрэв бид шатахгүй юм бол

Хэн энэ түнэр харанхуйг гийгүүлэх юм бэ? (түнэр харанхуйг гийгүүлэх юм бэ гэснийг ажлын алдаа, албаны бэрхшээлийг давах юм бэ гэж уншина уу) гэсэн мөрүүд энүүхэн ойрхон сонсогдож байна.

Уншаад өөртөө тавих асуулт:

-Кунз **"Ямагт мэдлэг чинь хүрэлцэхгүй байгаа мэт суралцагтун"**гэж ээ?

-Би ингэж эрэлхийлж, тэгэж **суралцаж** чадаж байгаа бил үү?

-Уншихаа больчихвол, сэтгэхээ байчихдаг болохоор **эрлийн үзүүр эцэс төгсгөлгүй** гэдэгтэй санал нэгдэх үү?

Хурандаа Д.Нямдорж

ОЮУНЫ ЗУРАГЛАЛ ХЭМЭЭХ ШИНЭ БИЧИГ ҮСЭГ



Х.Гөлгөө

Монголын Хил Судлалын Академийн гишүүн, ХСИС-ийн Хил судлалын докторант

Хүн төрөлхтөн гурван төрлийн бичиг үсгийг мэддэг гэнэм, үүнд:

1.Уламжлалт бичиг үсэг
2.Шинжлэх ухааны бичиг үсэг
3.Оюун ухааны бичиг үсэг

Монголчууд уламжлалт бичиг үсэгт бараг бүгдээрээ тайлагдсан, шинжлэх ухааны бичиг үсэгт хэдхэн хүн тайлагдсан, харин оюун ухааны бичиг үсэгт огт тайлагдаагүй гэвэл та зөвшөөрөх үү? Зөвшөөрөхөөс аргагүй гэнээ, яагаад гэдгийн учир харин яваандаа тайлагдана, дуустал тэвчээртэй уншигтун.

Уншигч та бичиг үсэгт тайлагдсан уу, гэж асуувал танд хачин сонсогдох байх,...та "Би бичиг үсэгт тайлагдаагүй байж чиний бичсэнийг уншиж байгаа хэрэг үү" гэх биз, гэтэл тийм биш болоод байна, учрыг өгүүлье.

Хүн төрөлхтөн 1) Анхдагч түвшний буюу уламжлалт, 2) Дунд түвшний буюу шинжлэх ухааны, 3) Дээд түвшний буюу оюуны гэсэн гурван бичиг үсэгтэй ажгуу. Тэгэхлээр, тухайн хүний бичиг үсэгт тайлагдсан эсэхийг асуухдаа чухам аль түвшнийх нь вэ гэдгийг эхэлж тодруулах шаардлагатай болох юм. Бичиг үсэг гэж ерөнхий ярих бус доод-дунд-дээд түвшний бичиг үсэг гэж ялган салгаж ярих учиртай.

НЭГ. УЛАМЖЛАЛТ БИЧИГ ҮСГИЙН ТУХАЙ

Хүн төрөлхтөн бичиг үсэг гэдэг ойлголтыг цаг үе бүрд өөр өөрөөр ойлгож, тэр хэмжээгээрээ бичиг үсгээ сайжруулсаар эдүгээтэй золгосон байх бөлгөө...Эрт үеийн хүмүүс хад чулуун дээр ан гөрөөсний гэх мэт элдэв зураг сийлдэг байж. Эдгээр нь одоогийн бидэнд түүхийн дурсгал, соёлын их өв төдийгүй хаана, ямар үндэстэн, хэдүйд амьдарч байсан, бид яг энд байсан эсэхийг тодруулах баримт юм. Өвөг дээдэс маань аажмаар хэд гурван дүрс бүхий бичигтэй болжээ, өмнөхөөсөө хамаагүй том дэвшил, тэгээд дүрсийнхээ тоог олшруулав, зарим газарт тэмдэгт зохиож эхэлж, түүнийгээ галиглан дуудах болов.

Тэмдэгт үсэг ашиглах нь дүрс бичгээ бодвол сурах, хэрэглэхэд хялбар байсан тул тархах нь илүү байжээ. Бичиг үсгийн анхны хэлбэр нь "юм бичиг" гэх бөгөөд цааш нь "зураг бичиг", "санаа бичиг", "өгүүлбэр бичиг", "үеийн бичиг", "цагаан толгойт бичиг" гэсэн дараалалтай гэнэ. Томоохон бүс нутаг юмуу хаагдмал овог аймгууд өөр өөрсдийнхөөрөө үсэг зохиож байв, ингээд олон үсэг бичиг үүссэн байна, бас үүнд хаадын ч гэмээр ухаантны ч гэмээр хүчин зүйл нөлөөлж нэг үндэстэн